ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2014 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САР

Лиахона

Амилсан Аврагчийн төлөөх баяр баясал ба талархал, 16-р хуудас

Бошиглогчийг дагах таван арга зам, 22-р хуудас

Санваарын адислалууд бүх хүмүүст хүртээмжтэй, 46, 50, 53, 54, 60-р хуудсууд

*“Эх хүн хө-
хүүл хүүхдээ
мартаж чадах
уу? Төрүүлсэн
хөвгүүнээ
энэрэхгүй
байж чадах уу?
Хэдийгээр тэр
мартаж болох
ч Би чамайг
мартахгүй.
“Үзэгтүн, Би
алгандаа
чамайг
сийлсэн.”*

Исаиа 49:15–16

Лиахона, 2014 оны дөрөвдүгээр сар

16

ЗАХИАСУУД

4 **Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Бат бөх зангуу**
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

7 **Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Аврагч ба Гэтэлгэгч**

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

12 **Бид Их Эзэний мутар билээ**
Нийл К.Ньюэлл
Бразил, Эквадор, Филиппин болон Оросын гэгээнтнүүд гачигдалтай хүмүүст үйлчлэх гэдэг нь чухам юу гэсэн үг болохыг харуулж байна.

16 **Онцгой гэрчүүд амьд Христийн тухай гэрчилж байна**
Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын гишүүд Аврагчийн тухай гэрчилж байна.

22 **Бошиглогчийг дага**
Ахлагч Виллиам Р.Вокэр
Бид эдгээр таван сургамжийг ерөнхийлөгч Томас С. Монсоны хувийн үлгэр жишээнээс олж харж, суралцах ёстой.

26 **Газар бүрийн анхдагчид: Филиппин: Далайн арлууд дээрх сүнслэг хүч**
Филиппинд байгалийн гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл тохиолдож байгаа ч тэндхийн гэгээнтнүүд гайхамшигтай өсч хөгжиж байна.

32 **Асуултуудад хариулахын тулд Авралын төлөвлөгөөг ашиглах нь**
Ларин Портэр Гаунт
Амьдралын зарим чухал асуултад хариулт авахад маань Авралын төлөвлөгөө тусалж чадна.

АЛБАД

8 **Хуучин Гэрээний бошиглогчид: Мосе**

10 **Бидний гэр орон ба гэр бүлүүд: Христийн амилсны баярын өмнөх долоон өдөр**

36 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой**

80 **Биднийг дахин уулзтал: Ирээдүйгээс итгэл найдварыг олох нь**
Стэн Пагсли

ХАВТСАН ДЭЭР
Нүүрэн талд: *Цэцэрлэг дэх бунхан,* Ж. Көрк Ричардсын зурсан зураг, хуулбар хийж болохгүй. Хавтасны дотор талд: Гэрэл зураг чимэглэлийг Жон Люк.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

40 **Хэрэв та нар миний алдар суугийн төлөө бүхнээ зориулах аваас**
Кэтерин Нэлсон, Хэйди Макконки нар
Хүн даруу байх гэдэг нь зөвхөн зөв хувцаслахаас ч илүү чухал зүйл юм.

44 **Залуучуудын тухай хөрөг өгүүлэл: Финланд дахь хөрвөлт ба золиослол**
Мэлиса Зэнтэно

Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санамж: Түүний дуртай зүйлүүд юу вэ?

ӨСВӨР ҮЕЙЙНХЭНД ЗОРИУЛАВ

46 **Эрэгтэй, эмэгтэй хүмүүс Их Эзэний ажилд**
Ахлагч М. Рассэлл Баллард
Бурханы хаант улсад эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийн тухай доорх үнэнүүдийг эрэгтэй, эмэгтэй хүмүүс аль аль нь ойлгодог байх хэрэгтэй.

50 **Үйлчлэхэд бэлтгэж, бэлтгэхийн тулд үйлчлэх нь**
Дэвид Л.Бэк
Та нарын Аароны санваарын үйлчлэл амьдралын тань үлдсэн хугацаанд жишиг болж хэвших болно. Харин яаж?

53 **Бүх хүмүүсийг адислах хүч**

54 **Санваарын адислалуудыг гэр орондоо авчрах нь**
Бонни Л.Оскарсон
Таны хүйс болон гэр бүлийн нөхцөл байдал ямар вэ гэдгээс үл хамааран та гэр бүлээ адислах санваарын хүчийг олж авч чадна.

56 **Зохистой байдлаас ирдэг итгэл үнэмшил**
Ахлагч Жэффри Р.Холланд
Санваараа ашиглахаар дуудагдах үед түүнийг хүлээж авах итгэл чамд байгаа юу?

60 **Хаалга ба зам**
Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очиход санваар танд хэрхэн тусалдгийг одоо авч үзье.

62 **Асуулт, хариултууд**
Сайн мэдээний сургаалуудад харшилдаг үр хөндөлт гэх мэт сэдэв сургууль дээр яригдвал би юу хэлэх хэрэгтэй вэ?

64 **Үнэн үү, худал уу?**
Дэвид А.Эдвардс
Энэ тааврыг таарч, Сатан бидэнд хэрхэн худал хэлдэг талаар илүү их зүйлийг мэдэж аваарай.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

67 **"Өвөө, энэ чинь маш амархан!"**
Ахлагч Энрикэ Р.Фалабэлла
Рэквиэл өөрийгөө Мормоны Ном унших насанд хүрээгүй гэж боддог байжээ.

68 **Портэрын амлалт**
Кэрол М.Стэфэнс
Портэр гэрээнүүдээ сахидаг ч үүнийгээ мэддэггүй байжээ!

70 **Хүүхдийн хэсгийг гэртээ авчрах нь: Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний төвд гэр бүл байдаг**
Жан Тэйлор

72 **Өөдрөг сайхан санаа**

73 **Том чулууг зайлуулсан нь**
Ахлагч Тэрэнс М.Винсон
Их Эзэн бидэнд асуудлуудаа, бүр жижигхэн асуудлуудаа хуртэл шийдэхэд туслахыг хүсдэг.

74 **Дэлхий даяарх найзууд: Би Филиппиний Дриа байна**

76 **Бага насны хүүхдүүдэд зориулав**

81 **Бошиглогчийн хөрөг: Ховард В.Хантэр**

2014 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ДУГААР 15 NO. 2
ЛИАХОНА 10984 363
Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг, Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Боид К.Пакэр, Л.Том Пэрри, Рассэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, М.Рассэл Баллард, Ричард Г.Скотт, Робэрт Д.Хэйлс, Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук, Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

Эрхлэгч: Крэйг А.Кардон
Зөвлөхүүд: Хосе Л.Алонсо, Мэрвин М.Арнольд, Шэйн М.Бөүэн, Стэнли Г.Эллис. Бага Кристоффэл Голдэн

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр
Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал: Винсэнт А.Ваун
Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг
Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон
Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр
Редакцийн баг: Сюзан Баррэт, Бриттани Бийти, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Минди Рая Фрийдмэн, Лори Фүллэр, Гаррэт Х.Гарфф, ЛаРин Портэр Гаунт, Жэннифэр Грэйс Жөүнс, Майкл Р.Моррис, Салли Жонсон Одэкөрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн
Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрьюс, Фэй П.Андрус, Мэндэл М. Бэнтли, С.Кимбалл Ботт, Том Чайлд, Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брад Тиэри, П.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Жэйн Анн Пэтэрс
Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс
Хэвлэх баг: Кэвин К.Банкс, Конни Бөүторп Бриж, Жүүли Бурдэтт, Браян У.Гиги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон, Гэйл Тэит Раффэрти
Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэдвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн, Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" бүюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын, свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украйн, унгар, урду, фижи, фин, франц, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2014 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувилан олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
April 2014 Vol. 15 No. 2. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is $5.00 per year; Canada, $6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address *must* be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard, American Express) may be taken by phone. (Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдэш хэрхэн хийх санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглах өгүүлэл, үйл ажиллагаанууд багтсан. Дор хоёр жишээ өгөгдсөн болно.

ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭВИД СТОКЭР

"Христийн амилсны баярын өмнөх долоон өдөр," 10-р хуудас, **"Онцгой гэрчүүд амьд Христийн тухай гэрчилж байна,"** 16-р хуудас: Та эдгээр өгүүлэл дэх материалуудыг Христийн амилсны баярын өмнөх долоо хоногт гэр бүлтэйгээ хийх өдөр тутмын онцгой цугларалт дээр ашиглаж болно. Христийн амилсны баярын өмнөх ням гаргаас эхлэн та 17-р хуудсан дээрх Тэргүүн Зөвлөлийн гишүүдийн гэрчлэлийг уншиж, "Христийн амилсны баярын өмнөх долоон өдөр" өгүүлэл дэх заавруудыг дагаарай. Түүнээс хойш өдөр бүр хоёр төлөөлөгчийн гэрчлэлийг уншиж, захиасыг нь гэрийнхэнтэйгээ хуваалцахын тулд судрууд ба дуунуудыг мөн "Христийн амилсны баярын өмнөх долоон өдөр" өгүүлэл дэх үйл ажиллагааг ашиглана уу. Христийн амилсны баярааб та lds.org/bible-videos дахь "Тэр амилсан" Библийн видео бичлэгийг үзэж болно (энэ бичлэг хэд хэдэн хэл дээр байгаа).

"Өвөө, энэ чинь маш амархан!" 67-р хуудас: Та энэ өгүүллийг уншсаны дараа цаг гарган, ямар хугацаанд хэдий хэр зүйл уншихаа тооцоолж болно. Гэр бүлээрээ Мормоны Номоос нэг хуудас уншиж, үүнд хэр хугацаа орсныг хар. Тэгээд танай гэр бүл Мормоны Номыг бүхэлд нь уншихад хэр зэрэг их хугацаа зарцуулахыг тооцож үзнэ үү. Та нар Мормоны Номыг хамтдаа унших зорилго тавьж болно. Өдөр бүр тодорхой хугацааг уншихад зарцуулах хуваарь гаргаснаар та нар зорилгодоо хүрэхэд өөрсдөдөө тусалж чадна.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон сүмийн бусад материалуудыг **languages.lds.org** вэбсайтаас олон хэлээр үзэх боломжтой.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заана.

Авралын төлөвлөгөө, *32, 37, 39, 70*
Ариун сүмүүд, *26, 44*
Бишрэл хүндэтгэл, *76*
Бошиглогчид, *8, 22*
Гэр бүл, *46, 50, 54, 70*
Гэрчлэл, *62*
Гэрээнүүд, *68*
Даруу байдал, *40*
Ерөнхий чуулган, *4*
Есүс Христ, *4, 7, 10, 16, 76*
Монсон, Томас С., *22*
Мормоны Ном, *67*
Найдвар, *80*
Номлогчийн ажил, *26, 62*
Санваар, *46, 50, 53, 54, 56, 60*
Сүмийн түүх, *26*
Үй гашуу, *37, 39*
Үйлчлэл, *12, 36, 38, 50*
Үлгэр дуурайл, *22*
Халамж, *12, 36*
Хантэр, Ховард В., *81*
Христийн амилсны баяр, *10, 16*
Хувь хүний үнэ цэнэ, *7, 12*
Хуучин Гэрээ, *8*
Хэл, *40*
Хөрвөлт, *26, 44*
Цагаатгал, *7, 10, 16, 32, 76*
Эмэгтэйчүүд, *46*
Ялган таних чадвар, *64*

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

БАТ БӨХ

зангуу

АНУ-ын Аляскийн үзэсгэлэнт сайхан эргийн дагуу аварга том усан онгоцоор аялах онцгой аз завшаан саяхан надад тохиосон юм. Онгоцны ахмад алслагдсан, нам гүмхэн буланд хоноглохоор бэлтгэхдээ далайн түрлэгийн дараалал, усны гүн, аюултай саадаас хэр зэрэг хол байгаа гэх мэтээр усан онгоцны байршилд болон нөхцөл байдалд анхааралтай дүн шинжилгээ хийсний эцэст зангуугаа хаяж бөхлөн, аюулгүй газарт зогссоноор зорчигчдод Бурханы гайхамшигтай бүтээлүүдийг харах, нүд хужирлан бишрэх боломж тохиолдсон билээ.

Би далайн эргийг ширтэн зогсох үедээ сэвэлзүүр салхины болон далайн намуухан түрлэгийн аясаар усан онгоц үл мэдэг туугдаж буйг анзаарав. Гэсэн ч бөхлөгдсөн зангууны хүчээр онгоц зангууны татлагын урттай тэнцэхүйц тойрог дотор бат бөх зогсож байлаа.

Ахмад зөвхөн шуурга ойртсон үед л зангууг доош буулгахад бэлэн байлгахын тулд үүнийг усан онгоцон дээр авч явдаггүй ажээ. Тэрээр зорчигчдыг болон багийнхныг амарч байх үед усан онгоцыг аюултай ус руу хөвж орох юм уу хайргадахаас урьдчилан сэргийлж, хамгаалах арга хэмжээ авахын тулд зангууг буулгасан байлаа.

Би энэ үйл явдлыг тунгаан бодоод хэрэв үүнийг сургаалт зүйрлэл болгон ашиглахгүй юм бол би хэзээ ч нисэх онгоц жолоодоогүйтэй адил юм болно гэсэн бодол санаанд орж ирэв.

Бидэнд зангуу яагаад хэрэгтэй байдаг вэ?

Зангууны зорилго нь цаг агаар муудсан үед усан онгоцыг аюулгүй байлгахад хяналт тавих эсхүл түүнийг хүссэн газарт нь аюулгүй байлгах явдал мөн. Гэвч эдгээр амин чухал зорилгуудыг хэрэгжүүлэхийн тулд зөвхөн зангуутай байх нь хангалтгүй. Зангуу бат бөх, найдвартай байх ёстой бас зөв цагт, зөв газарт зохих ёсоор ашиглагддаг байх ёстой.

Хувь хүмүүст болон гэр бүлүүдэд ч мөн зангуу хэрэгтэй.

Бэрхшээл нь агуу хүчит шуурга лугаа адил биднийг буруу зам руу оруулж, хад мөргүүлэхээр заналхийлж болно. Гэхдээ зарим үед, салхи намуухан, ус тогтуун—юм бүхэн аюулгүй тайван байгаа мэт үед ч гэсэн бидэнд аюул тохиолдож болно. Чухамдаа бид урсгал дагуу тогтуухан хөвөх үед мөн нүдэнд үл анзаарагдам хөдөлгөөнтэй үед ч гэсэн хамгийн том аюулд орсон байж болно.

Сайн мэдээ бол бидний зангуу юм

Зангууг хэрэг болох үед бэлэн байлгахын тулд сайн арчилж тордон, бат бөх, хүчтэй байлгах ёстой. Түүнээс гадна энэ нь эсэргүүцэгч хүчний хүнд дарамтыг тэсэн гарах чадвартай сууринд бэхлэгдсэн байх ёстой юм.

Мэдээж хэрэг, Есүс Христийн сайн мэдээ бол ийм зангуу юм. Ертөнцийг Бүтээгч Өөрийн хүүхдүүдийг аюулгүй байдал ба удирдамжаар хангах бурханлаг зорилгын төлөө энэхүү зангууг бэлтгэсэн билээ.

Өөрийн хүүхдүүдийг гэтэлгэж, тэднийг дэргэдээ буцаан аваачих гэсэн Бурханы төлөвлөгөөний зэрэгцээ сайн мэдээ гэж юу вэ?.

Бид бүх зүйлийн мөн чанар тогтворгүй байдгийг мэдэх учраас өөрсдийн зангууг сайн мэдээний үндэс сууринд бат бөх бэхлэх ёстой. Энэхүү зангууг бид бардамналын балчиг шавхайд эсвэлэс иттэл үнэмшлийнхээ өнгөн хөрсөнд гүехэн бэхлэх ёсгүй.

Энэ сард бид сүмийн Ерөнхий чуулган дээр Бурханы үйлчлэгчдийн хэлсэн үгсийг сонсох боломжтой байлаа. Тэрхүү үгс судруудтай болон Сүнсний өдөөлтүүдтэй

нэгдэн, амьдралын бэрхшээл, хүнд сорилтууд дунд гуйвшгүй, тууштай байхын тулд бидний зангуугаа бэхлэх ёстой мөнхийн үнэт зүйлсээр болон зарчмуудын найдвартай, бат бөх үндэс сууриар хангадаг билээ.

Эртний бошиглогч Хиламан: "Мөн эдүгээ, хөвгүүд минь, санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун; иймээс чөтгөр хүчит салхиа, тийм ээ, хуй салхин дахь дайралтаа илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит шуурга та нар дээр нүдэхэд, энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халаглалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон, бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй суурь болох хадны учир болой" (Хиламан 5:12) хэмээн сургасан юм.

Бат бөх зангууны үнэ цэнэ

Бидний зангууг сорих болон биднийг урсгал даган идэвхгүй хөвөхөд уруу татах арга зам амьдралд байдаг. Гэсэн хэдий ч, хэрэв бидний зангуу Гэтэлгэгчийн маань хадан дээр зөв бэхлэгдсэн л бол энэ нь салхины болон далайн түрлэгийн хүчээс мөн давалгааны өндрөөс үл хамааран бат бөх байх болно.

Мэдээж хэрэг, усан онгоц далайн боомт дээр байнга зогсохоор бус харин зангуугаа өргөж, амьдралын далайд хөвөхөөр бүтээгдсэн билээ. Гэхдээ энэ нь өөр цаг үед зориулсан сургаалт зүйрлэл юм.

Энэ мөчид би сайн мэдээний болон бидний Гэтэлгэгчийн хадны зангуу биднийг гуйвшгүй бөгөөд аюулгүй байлгах болно гэдгийг мэдсэнээр тайтгарлыг олдог билээ.

Ийм зангуу биднийг аюул ба золгүй явдалд өртөхөөс сэргийлнэ. Энэ нь үргэлж өөрчлөгдөж байдаг, юутай ч зүйрлэшгүй, амьдралын хамгийн дээд сайн сайхныг эдлэх агуу боломжийг бидэнд олгох болно.

Амьдрал сайхан мөн амьдрах ч сайхан. Салхи шуурга, ширүүн урсгал биднийг үзэгдэх болон үл үзэгдэх аюул руу аваачиж мэдэх ч сайн мэдээний захиас ба түүний бурханлаг хүч нь Тэнгэрлэг Эцэгийнхээ аюулгүй зогсоолд эргэж очих зам дээр биднийг баттай байлгах болно.

Тиймээс дөрөвдүгээр сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг зөвхөн *сонсоод* зогсохгүй, захиасуудыг нь өдөр тутмын амьдралдаа бат бөх зангуу болгон *хэрэгжүүлцгээе.*

Бурхан энэхүү онцгой чухал хүч чармайлтад биднийг адисалж, удирдах болтугай! ■

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Амлагдсан нутаг руу далайгаар хөвсөн Лихайн гэр бүлд зангуу хэчнээн их чухал байсан тухай ярилцах талаар бодож үз (1 Нифай 18-ыг үзнэ үү). Нифай хүлэгдсэн, Лиахона ажиллахаа больсон болон усан онгоц хүчтэй шуурганд туугдсан үеийг та онцгойлон авч үзэж болно (1 Нифай 18:11–15). Бид сайн мэдээнд бат бөх итгэлтэй болоогүй үед ямар үр дагаврууудтай тулгардаг вэ? Та 1 Нифай 18:21–22-ыг онцгойлон авч үзээд бид Аврагч руу эргэснээр аюулгүй байдлыг хэрхэн олж болох талаар ярилцана уу.

STOCKTREK IMAGES/THINKSTOCKИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Чуулган бид хоёр

Сара Дийкс

Ерөнхий чуулганы бямба, ням гараг уйтгартай, урт юм шиг надад санагддаг байж билээ. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам би чуулганы өдрүүдэд дуртай болж, тэсч ядан хүлээдэг болсон. Ерөнхий чуулганы бямба, ням гарагт бид сүнслэг байдлын хувьд дахин цэнэглэгддэг ч энэхүү мэдрэмж нь даваа гаригт амьдрал хэвийн байдлаар үргэлжлэх үед алга болж бүдгэрэх нь амархан байдаг. Чуулганаас аль болох их зүйлийг сурч мэдэхэд надад дараах хэдэн санаа тусалсан юм.

Би чуулганд бэлтгэхдээ асуух асуултуудаа бичиж, дараа нь эдгээр асуултууд хэрхэн хариулагдсан талаар тэмдэглэл хөтөлдөг. Тэгээд чуулган дээр хэлсэн үгсээс болон чуулганы дуу хөгжмөөс ажлаа хийх явцдаа өдөр бүр нэг хэлсэн үг эсвэл нэг дуулал сонсож байхын тулд тэдгээрийг LDS.org-аас татаж, MP3 тоглуулагч дээр хуулж авдаг. Мөн би *Лиахона* сэтгүүлийн чуулганы дугаарыг уншиж судлах дуртай. Онцгой сонирхол татсан хэсгүүдийг тодруулан тэмдэглэхийн хамт сэтгүүлийнхээ хуудасны захад тэмдэглэл хийдэг. Дараагийн чуулган хүртэл би сэтгүүлээ маш сайн ашигладаг бөгөөд манай гэрийнхэн Лиахонагийн захиасуудыг заримдаа гэр бүлийн үдшээр хамтдаа судалдаг.

Бид чуулганы үеэр мэдэрсэн сүнсийг удаан хугацаанд хадгалж, захиасуудаас үргэлжлүүлэн суралцахын тулд хөдөлмөрлөх шаардлагатай ч энэ нь надад агуу адислал авчирдаг билээ. Би Ерөнхий чуулганы захиасуудаас судалснаар шаардлагатай үед маш их хүч чадал ба удирдамжийг хүлээн авдаг. Мөн эдгээр захиасууд нь сүнслэгээр нөлөөлөгддөг гэдгийг би мэднэ.

Зохиогч нь Канадын Торонтод амьдардаг.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Зангуугаа бөхөл

Ямар зүйл та нарыг сайн мэдээнд бат бөх итгэлтэй болгох вэ? Хөвгүүний гар дахь уяанаас зангуугаа бөхлөх найдвартай газрууд хэмээн ерөнхийлөгч Угдорфын хэлсэн зүйлс рүү шугам тат.

ЗҮҮН ТАЛД: ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РОБЕРТ КЭЙСИ; ЧИМЭГЛЭЛИЙГ КЭТИ МАКДИЙ

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхээр эрэлхийл. Аврагчийн амьдрал болон зорилгыг ойлгох нь таны Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж мөн айлчлагч багшлалтаар дамжуулан харж ханддаг хумүүсийг тань хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл ***reliefsociety.lds.org*** *хаягаар орж үзнэ үү:*

Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Аврагч ба Гэтэлгэгч

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

"Есүс Христийн яруу сайхан нэрсийн дотроос хамгийн гайхамшигтай нь Гэтэлгэгч гэдэг нэр юм" гэж Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д. Тодд Кристоффэрсон хэлжээ. "*Гэтэлгэх* гэдэг нь өр эсвэл төлбөрийг төлж барагдуулах гэсэн утгатай юм. *Гэтэлгэх* нь бас төлөөсийг нь төлснөөр аврах эсвэл чөлөөлөх гэсэн утгатай байж болно. . . . Эдгээр утгууд тус бүрдээ Есүс Христийн Өөрийн Цагаатгалаар дамжуулан гүйцэлдүүлсэн агуу Гэтэлгэлийн өөр өөр талуудыг дүрслэн харуулдаг. Энэ нь толь бичигт тайлбарласнаар 'нүгэл үйлдэгчийн төлөө золиослол хийх замаар нүгэл ба нүглийн төлөөх шийтгэлээс чөлөөлөх' гэсэн утгатай юм."[1]

Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бөртон "Тэнгэрлэг Эцэг . . . Өөрийн төрсөн Ганц төгс Хүүгээ бидний нүгэл, зовлон шаналлын төлөө болон бидний хувийн амьдралд байдаг шударга бус бүх зүйлийн төлөө зовлон эдлүүлэхээр илгээсэн юм.

". . . Олон жилийн хүнд сорилт, уй гашууг биеэр туулсан нэгэн эмэгтэй нулимс урсган, 'Би өөрийгөө үнгэгдэн сэмэрч, элэгдсэн мөн халтартаж, хорчийсон 20 долларын дэвсгэрттэй адилхан болсныг ухаарсан. Харин . . . үнэ цэнийн хувьд би 20 доллартай бүрэн дүйнэ' хэмээн ярьж билээ. Бурханы хувьд түүнийг хувь хүнийх нь нүглийг цагаатгахаар Хүүгээ илгээхүйц тийм үнэ цэнэтэй байснаа тэр эмэгтэй мэддэг ажээ. Сүм дэх эгч бүр энэ эмэгтэйн ойлгосон зүйлийг мэддэг байх хэрэгтэй"[2] гэж хэлсэн байдаг.

АМЬД УС, ХОВАРД ЛАЙОН

Судруудаас

2 Нифай 2:6; Хиламан 5:11–12; Мосе 1:39

ЭШЛЭЛҮҮД

1. Д. Тодд Кристоффэрсон, "Гэтэлгэл" *Лиахона,* 2013 оны 5-р сар, 109.
2. Линда К.Бөртон, "Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэл бидний зүрх сэтгэлд бичигдсэн үү?" *Лиахона,* 2012 оны 11-р сар, 114.

Би юу хийж чадах вэ?

1. Бид өөрсдийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч Есүс Христэд талархдагаа хэрхэн харуулж болох вэ?
2. Бид Аврагчийн цагаатгагч золиослолын адислалуудыг амьдралдаа хэрхэн авч болох вэ?

Итгэл, гэр бүл, халамж

Бидний түүхээс

Есүс Христэд итгэх итгэлээ ашиглан, Түүний сургаалуудаас суралцан, тэдгээрийн дагуу амьдарч, Түүний үйлчлэл, гайхамшгуудыг мөн сүр жавхланг гэрчилсэн эмэгтэйчүүдийн тухай шастирууд Шинэ Гэрээнд байдаг.

Есүс худаг дээр тааралдсан эмэгтэйд ингэж хэлсэн билээ:

"Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх аминд хүртэл оргилох булаг болно.

"Эмэгтэй Түүнд, Эзэн, тэр усаа надад өгөөч. Тэгвэл би цангахгүй. . . .

"Христ гэгч [Мессиа] ирэхийг би мэднэ. Тэр Нэгэн ирэхдээ бүх зүйлсийг бидэнд мэдүүлж өгнө гэв.

"Есүс түүнд Чамтай ярьж байгаа Би бол Тэр мөн гэж айлдав."

Нөгөөх эмэгтэй "усныхаа савыг орхин" хот руу явж, Түүний тухай гэрчлэлээ хэлжээ. (Иохан 4:6–30-ийг үзнэ үү.)

МОСЕ

"Мосе бол Христийг бошиглогчийн хувьд Израилын түмэн цэргийн энэхүү эртний удирдагчтай зүйрлүүлэхээр тийм агуу нэгэн байлаа."[1] *—Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Брүс Р.Макконки (1915–1985)*

Миний хүмүүс болох израилчууд Египетэд боолчлолд байсан үед би төрсөн. Израил боолчуудын тоо өсч байгаагаас айсан Фараон бүх эрэгтэй израилчуудыг төрөнгүүт нь алж байх зарлиг буулгасан байлаа. Ээж минь намайг хамгаалахын тулд төрсний минь дараа Нил мөрөнд сагсан дотор хийж тавих хүртлээ гурван сар нуусан гэдэг. Фараоны охин намайг олж, хүүгээ болгон өсгөсөн юм.[2]

Би өсч том болоод Египетийг орхин, Мидианы нутагт амьдарч байлаа. Тэнд би хоньчин бөгөөд тахилч Иетрогийн таалалыг олж, Зиппорагийн охинтой гэрлэж, Иетрогоос Мелкизедек санваар авсан.[3]

Нэг өдөр намайг Иетрогийн сүргийг хариулж явтал Их Эзэн шатаж байгаа бутан дотор харагдаж, намайг дуудан, Израилын хүүхдүүдийг боолчлолоос чөлөөл гэв.[4]

Би Египетэд эргэж ирээд Их Эзэний хүмүүсийг чөлөөлөхийг Фараоноос гуйхад тэрээр тэдний ачааг харин ч улам нэмэгдүүлэв. Их Эзэн олон өвчин, тахлыг египетчүүд дээр илгээсэн ч Фараон зүрх сэтгэлээ хатууруулж, израилчуудыг чөлөөлөхөөс татгалзсаар байв. Сүүлчийн тахал нь Египетийн айл болгонд төрсөн ууган хүүг алсан устгагч тэнгэр элч байлаа. Израилчууд өө сэвгүй хурганы цусыг тоотон дээрээ түрхэж, гэрээсээ гаралгүй байснаар устгагч тэнгэр элчээс аврагдсан юм. Их Эзэн энэхүү гайхамшгийг жил бүр санаж байхад нь израилчуудад туслахын тулд надаар дамжуулан Дээгүүр өнгөрөх баярыг ёслол болгон нэвтрүүлсэн билээ.[5]

Энэхүү сүүлчийн тахал нь Фараоныг бууж өгөн, израилчуудыг чөлөөлөхөд хүргэсэн юм. Гэвч Фараон хожим нь зүрх сэтгэлээ хатууруулж, Египетийг орхин явсан израилчуудын араас цэргээ явуулсан. Улаан тэнгисийг хага ярах хүчээр Их Эзэн намайг адисалсан бөгөөд биднийг хуурай газар дээгүүр зуттан гарахад Фараоны цэргийг тэнгисийн ус нөмрөн залгисан юм.[6]

Их Эзэн биднийг өдөр нь үүлэн дунд, шөнө нь галан баганан дунд цөл дундуур удирдсан.

МОСЕ ЗЭГСЭН ДУНД © PROVIDENCE COLLECTION; *МОСЕ УЛААН ТЭНГИСИЙГ ХУВААЖ БАЙГАА НЬ,* РОБЭРТ Т.БАРРЭТ; *МОСЕ БА ХАВТАНГУУД,* ЖЭРРИ ХАРСТОН; *МОСЕ ААРОНЫГ ТОХИНУУЛАЛД ДУУДАВ,* ХАРРИ АНДЭРСОН; *МОСЕ БА ГУУЛИН МОГОЙ,* ЖУДИТ А.МЭХР

Тэрээр биднийг усаар, маннагаар мөн бөднө шувуудаар хангасан юм.[7]

Би Синай уулан дээр гарч тэнд 40 өдөр байхдаа Их Эзэнээс Арван зарлигийг хүлээн авсан. Намайг уулнаас буцаж ирэхэд израилчууд Бурханаас нүүр буруулж, шүтээн болгон алтан тугал хийсэн байлаа. Тэд Бурханы надад өгсөн хуулийг хүлээн авахаар зохистой биш болсон байв. Иймээс би уг хууль бүхий хавтангуудыг эвдсэн юм. Намайг уул руу буцаж очиход Их Эзэн бага хуулийг надад өгсөн бөгөөд энэ нь миний нэрээр Мосегийн хууль хэмээн нэрлэгддэг.[8]

Их Эзэн цөлд асар эсвэлс авсаархан ариун сүм барих загварыг надад илчилсэн. Бид аян замдаа дотор нь сүсэглэн залбирахын тулд асрыг авч явдаг байлаа. Энэ асарт хүмүүс ёслолууд хүлээн авдаг байсан ба би Их Эзэнтэй "анд нөхөртэйгөө ярьж байгаа мэт, нүүр нүүрээрээ тулан ярьдаг байлаа."[9] Их Эзэн бас асрын хамгийн ариун хэсэгт, ариунаас ариун газарт байх ёстой нандин шүтээн болох гэрээний авдрыг хэрхэн хийхийг надад үзүүлсэн.[10]

Их Эзэн израилчуудыг зэмлэхийн тулд "галт могойнуудыг" илгээсэн үед гуулин могой хийж, саваанд өлгөн, өндөрт өргөж, тэдэнд харуулахыг надад зарлиг болгосон билээ. Могойнд хатгуулсан бүх хүмүүс үүнийг хараад эдгээгдэж болох байв. Гэвч олон хүн бардамналынхаа улмаас мөн тэдэнд энэ зүйл хэтэрхий энгийн санагдсанаас могойг олж хараагүй. Иймээс тэд мөхсөн юм.[11]

Их Эзэн израилчуудыг амлагдсан нутагт очихыг зөвшөөрөхөөс өмнө тэднийг цөлд 40 жил тэнүүчлэхээр болгосон юм.[12] Би амлагдсан нутагт очоогүй харин Их Эзэнд "Сүнсээр дээш аваачигдсан билээ."[13] ■

ЭШЛЭЛҮҮД

1. Брүс Р.Макконки, *Mormon Doctrine,* 2 дахь хэвлэл, (1966), 515; мөн Дэд хууль 18:15–19-ийг үзнэ үү.
2. Египетээс гарсан нь 1; 2:1–10-ыг үзнэ үү.
3. Египетээс гарсан нь 2:11–22; Сургаал ба Гэрээ 84:6-г үзнэ үү.
4. Египетээс гарсан нь 3; 4:1–17-г үзнэ үү.
5. Египетээс гарсан нь 5–12; Езекиел 45:21-ийг үзнэ үү.
6. Египетээс гарсан нь 14-р бүлгийг үзнэ үү.
7. Египетээс гарсан нь 13:21–22; 15:22–27-р шүлгүүд; 16-р бүлэг; 17:1–7 –г үзнэ үү.
8. Египетээс гарсан нь 24:18; 31:18; 32; 34-ийг үзнэ үү.
9. Египетээс гарсан нь 33:11
10. Египетээс гарсан нь 25–29; 40:21-ийг үзнэ үү.
11. Тооллого 21:6–9; 1 Нифай 17:41; Алма 33:19–20-ийг үзнэ үү.
12. Тооллого 14:33–34-ийг үзнэ үү.
13. Алма 45:19.

МЭДЭЭ БАРИМТЫН ХАЙРЦАГ: МОСЕ

Мосегийн бичсэн судрууд: Мосе бол Агуу Үнэт Сувд дахь Мосегийн номоос гадна Библийн эхний таван ном болох Эхлэл, Египетээс гарсан нь, Левит, Тооллого ба Дэд хуулийн зохиогч юм.

Мөнх бус амьдралын өмнөх үүрэг: тухайн эрин үеийг тэргүүлэхээр сонгогдсон (Абрахам 3:22–23-ыг үзнэ үү)

Мөнх бус амьдралын үе дэх үүргүүд: Израилчуудыг Египетээс удирдан гаргав; Синай уулан дээр хууль хүлээн авав (Египетээс гарсан нь 12; 20-р бүлгүүдийг үзнэ үү)

Мөнх бус амьдралын дараах үүргүүд: Хувиралтын уулан дээр хүрч ирэн, санваарын түлхүүрүүдийг Петр, Иаков, Иохан нарт өгөв (Судруудын удирдамж, "Хувиралт," scriptures.lds.org-ыг үзнэ үү); 1836 оны 4-р сарын 3-нд АНУ-ын Огайо дахь Көртландын ариун сүмд ирж, Израилын цугларалтын түлхүүрүүдийг Иосеф Смитэд сэргээв (С ба Г 110:11-ийг үзнэ үү)

ХРИСТИЙН АМИЛСНЫ БАЯРЫН ӨМНӨХ ДОЛООН ӨДӨР

Есүсийг дэлхий дээр амьдарч байхдаа юу хийж байсан талаар та болон танай гэр бүл суралцаж болно. Христийн амилсны баярын өмнөх ням гаргаас эхэл. Өдөр бүр заасан судрыг уншиж, үйл ажиллагааг хий эсвэл дууг (эсвэл уг сэдвээр өөр нэг дуу) дуул. Тэгээд судрын түүхтэй тохирох Есүсийн зургийг хайчилж аваад хоосон хайрцаг дотор наа. Бүх хайрцаг дүүрэхэд Христийн амилсны баяр болох болно! ■

1 ДЭХ ӨДӨР
Тэнгэрлэг Эцэг өөрийн хүү Есүсийг дэлхий дээр төрөхөөр илгээсэн юм.
- Лук 2:4–7
- "He Sent His Son" (*Children's Songbook,* 34).

2 ДАХЬ ӨДӨР
Есүс хүүхэд байсан. Бид сайн мөн эелдэг байснаар Түүнтэй адилхан болж чадна.
- Лук 2:40, 52
- "Jesus Once Was a Little Child" (*Children's Songbook,* 55).

3 ДАХЬ ӨДӨР
Есүс Тэнгэрлэг Эцэгийн бүх зарлигийг, түүний дотор баптисм хүртэх зарлигийг дагасан юм.
- Матай 3:13–17
- "When Jesus Christ Was Baptized" (*Children's Songbook,* 102).

4 ДЭХ ӨДӨР
Есүс өвчтэй хүмүүсийг эдгээх, хараагүй хүмүүст дахин хардаг болоход нь туслах, шуургыг намдаах зэрэг олон гайхамшгийг үйлдсэн билээ.
- Марк 4:36–39
- "Tell Me the Stories of Jesus," (*Children's Songbook,* 57).

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БЭТ М.ВИТТАКЕР

5 ДАХЬ ӨДӨР
Есүс сүүлчийн үдшийн зоогийн үеэр Түүнийг дурсан санах арга зам болгон ариун ёслолоос хүртэхийг шавь нараасаа хүссэн юм.
- Лук 22:19–20
- Энэ ням гаргийн ариун ёслолын үеэр Есүсийн тухай бодоход өөртөө туслахын тулд хийж болох ямар нэг зүйлийн талаар эцэг, эхдээ яриарай.

6 ДАХЬ ӨДӨР
Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр бидэнд хайртай учраас Есүс бидний нүглийн төлөө зовох гэж энэ дэлхий дээр ирсэн бөгөөд тиймээс бид өршөөгдөж, Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очиж чадна.
- Лук 22:41–44
- Та Есүсийн золиослолд талархдагаа Түүнд харуулахын тулд өнөөдөр юу хийж чадах вэ?

7 ДАХЬ ӨДӨР
Есүс булшинд гурав хоносны дараа амилсан билээ. Тэр амилсан учраас бид бас амилуулагдах болно.
- Иохан 20:15–17
- Лук 24:36–40
- "Did Jesus Really Live Again?" (*Children's Songbook*, 64).

Та энэ үйл ажиллагаагаар lds.org/music дээрх дуунуудыг сонсож болно.

Бид Их Эзэний мутар билээ

Ядуусыг эрж олон, зовж зүдэрч буй хүмүүст үйлчлэх нь Есүс Христийн шавь байхад шийдвэрлэгч ач холбогдолтой юм.

Нийл К.Ньюэлл
Халамжийн үйлчлэл

Эдийн засгийн их уналтын эхний жилүүдэд Солт Лэйкийн хөндийн зургаан гадасны ерөнхийлөгчид сүмийн үй олон гишүүнд заналхийлж, нөхцөл байдлыг нь улам дордуулж байсан ядуурал, өлсгөлөнг шийдвэрлэхийн тулд хамтран ажиллахаар шийджээ.[1] Эдийн засгийн хямрал газар бүрийн хүмүүст нөлөөлсөн ч Ютад байдал бүр хүнд байлаа.[2]

Тэр үед гачигдалтай хүмүүст туслах нөөц боломж сүмийн удирдагчдад хомсхон байв. Тэд мэдээж хэрэг, мацгийн өргөлийг ашиглаж болох байсан ч байнга өсөн нэмэгдэж байсан хэрэгцээ нь тэдэнд урьд өмнө нь тулгарч байснаас хэт давж гарсан байлаа. Дезерет ажил эрхлэлтийн товчоо Тэргүүлэх бишопын зөвлөлийн удирдлага дор 1900-аад оны эхээр үндэслэн байгуулагджээ. Гэхдээ энэ нь тийм их хэмжээний хэрэгцээг шийдвэрлэх хүчин чадалтай болоогүй байв.

Санваарын эдгээр зургаан удирдагч хэрэв гадаснуудынхаа хүмүүст туслах шаардлагатай л бол хүлээж болохгүй гэдгийг мэдэж байв. Тэд тэр даруй үйлдэл хийж, хүмүүсийг ажилтай болгож эхэлжээ. Тэд эрчүүдийг зохион байгуулж, талбайд аваачин, ургац хураах ажил олж өгсөн аж. Үүнд талархсан тариаланчид эрчүүдийн хөдөлмөрийн хөлс болгож хоол хүнс өгөөмрөөр өгчээ. Илүүдэл хүнсийг агуулахад хадгалж, өлсгөлөн хүмүүст хандивласан юм. Хандивын хэмжээ өсөхөд гэгээнтнүүд хүнс нөөцлөхийн тулд лаазалж эхлэв. Энэ нь өнөө үеийн халамжийн хөтөлбөрийн үндэс суурийг тавьсан ажээ.

Наян жилийн дараа дэлхий даяарх өнөө үеийн сүмийн удирдагчид сүмийн гишүүдийг харж хандан, тусламж хэрэгтэй хүмүүст хүрч тэдэнд туслахад шийдвэр төгс байна.

2011 оны аравдугаар сарын Ерөнхий чуулган дээр Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф: “Бид хэн нэгэн гэнэт гарч ирээд хэрэгцээтэй зүйлсийг маань өгдөг болоосой хэмээн олонтоо мөрөөддөг. Заримдаа бидэнд асуудал тулгарахад тухайн асуудлаар мэргэшсэн зөвлөгчийг хүсэн хүлээдэг. Бид ийнхүү байхгүй, бүтэхгүй зүйлсийг хүлээн сууснаараа хөршдөө үзүүлж чадах тусламжаа үзүүлэхгүй мөн үйлчлэх боломжоо боогдуулж байдаг. Мэргэжлийн зөвлөгчөөр туслуулах нь буруу биш ээ. Гэхдээ асуудлыг шийдвэрлэхэд хэдэн ч мэргэжлийн зөвлөгч байгаад нэмэргүй юм шүү. Харин Их Эзэн сүм зохион байгуулагдсан газар бүрд Өөрийн санваартнуудыг болон байгууллагуудаа өгсөн байдаг” хэмээн хэлсэн билээ.[3]

Сүмийн орон нутгийн удирдагчдыг болон гишүүдийг үйлдэл хийхэд уриалсан энэхүү уриалга нь дэлхий даяарх олон хүнийг Ариун Сүнсээр нөлөөлөгдөн,

“ямар үйлдэл хийхээ бодож олоход” хүргэсэн юм гэж ерөнхийлөгч Угдорф хэлсэн билээ.[4] Тэд ажиллахад бэлтгэгдэж, “гачигдагсад, өвчтөнүүд хийгээд зовж шаналагсдыг бүх зүйлд санаж байх”-аар (С ба Г 52:40) шийдсэн юм.

Эквадор

Эквадорын Гвияквил дахь бишоп Жонни Морантэ тойргийнхоо гишүүдийг хараад сэтгэл нь шаналжээ. Олон гэр бүл амьдралын наад захын хэрэгцээт зүйлстэй байхын төлөө тэмцэлдэж байлаа. Бишоп тэдэнд туслахыг хүсч, тойргийн удирдагчидтай зөвлөлдөн, асуудлыг Их Эзэнд танилцуулсан ажээ.

Тус бүс нутагт ажил эрхлэх боломж хомс байсан учраас тэр 11 эгчээс бүрдсэн бүлэгтэй хамт ажиллаж, жижиг бизнес эрхлэх боломж байгаа гэдэгт тэднийг итгүүлэн дэмжихээс ажлаа эхэлжээ. Хэрэв тэд үйлдвэрлэн, борлуулж чадвал орон байр цэвэрлэх чанартай, хямд үнэтэй материалын хэрэгцээ орон нутагт нь байгааг эдгээр эгч нар анзаарсан ажээ. Харин тэд ийм хэрэгслүүдийг хэрхэн хийж сурах билээ?

Тэр үед бишоп Морантэ өмнө нь эм зүйч-химичээр ажиллаж байсан нэг эгч тойрогт нь байдгийг санажээ. Нөгөөх 11 эгч химич эгчээс тусалж болох эсэхийг асуухад тэр аюулгүй, чанар сайтай цэвэрлэгээний материал хэрхэн хийхийг тэдэнд заахдаа баяртай байх болно гэв.

Тэгээд тэд бизнес төлөвлөгөө хийж, орон нутагтаа эгч бүрийн хариуцах хэсгийг газрын зурагт тэмдэглэн, тэдний хийж болох цэвэрлэгээний материалуудыг сонгож, баглаа боодол, хаяг, шошгоны зургийг гаргасан байна.

Хэдхэн сарын дараа тэд байнгын үйлчлүүлэгчидтэй болж, ядуурлаа бууруулах болон гэр бүлийнхээ хэрэгцээг хангахад туслах хангалттай орлоготой болсон ажээ.

Орон нутгийн эмийн компанийн менежерүүд энэ бизнесийн тухай мэдээд ажилгүй эм зүйч-химичийн тухай сонирхох болсон гэнэ. Эцэстээ тэд түүнтэй ярилцлага хийж, өөрийнхөө үйлдвэрлэлийг удирдуулахаар түүнийг ажилд авчээ.

Орос

Оросын Москва хотын Речной тойрогт тойргийн түүхчээр үйлчилж байсан Галина Гончарова мөсөн дээр хальтирч унаад хоёр гараа хугалжээ. Тэр эмэгтэй эмнэлэгт хүргэгдэж, хоёр гараа шохойдуулав. Тэр хоолоо өөрөө идэх байтугай хувцсаа өмсөж мөн үсээ самнаж ч чадахгүй бүр утсаа ч авч чадахгүй болжээ.

Тойргийн нөхөд нь тохиолдсон зүйлийг мэдээд тэр даруй хариу арга хэмжээ авчээ. Санваартнууд түүнд адислал өгч, Халамжийн Нийгэмлэгийн эгч нартай хамтран энэ сайн эгчид тусалж байх хуваарь гарган, хэрэгцээг нь шийдэж байхад тусалсан байна.

Тойргийн номлолын удирдагч Владимир Никифоров “Христийн гаргүй цээж хөшөөний тухай Ерөнхий чуулган дээрх нэг хэлсэн үгэнд гарч байсныг бид санадаг

Галина Гончарова халтирч унаад гараа хугалсны дараа Халамжийн Нийгэмлэгийнх нь эгч нар түүнд гар нь болж үйлчилжээ.

байлаа.[5] Хөшөөний доод талд ‘Та нар бол миний гар’ гэсэн дурсгалын пайзыг хэн нэг нь байрлуулсан байдаг. Тэгвэл энэ сайн эгчийг хүндээр бэртсэн хэдэн долоо хоногийн турш Речной тойргийнхон дээрх дурсгалын пайзан дээрх үгсийг хэрэгжүүлэгчид болсон юм. Чухамдаа бид түүний гар нь болсон билээ гэж тэд хэлсэн юм.

Филиппин

2011 онд халуун орны Воши шуурга Филиппиний арлуудыг үер, салхи хоёроор сүйрүүлэхэд 41000 орчим гэр орон эвдэрч, 1200 гаруй хүн амиа алдсан юм.

Филиппиний Кагаян ди Оро гадасны ерөнхийлөгч Макс Сааведра онцгой байдалд бэлэн байх гадасны баг байгуулахаар өдөөгджээ. Тэрээр янз бүрийн үүрэг даалгавруудыг—өвчтэй эсвэл бэртсэн хүмүүсийг эрж олон,

аварч, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэхээс эхлэн бүхий л ажил үүргүүдийг биелүүлэх янз бүрийн хороодыг зохион байгуулсан байна.

Үерийн ус аюулгүй түвшинд хүрч татрах үед сүмийн удирдагчдыг болон гишүүдийг дайчилжээ. Тэд гишүүн бүрийг үер, хар салхийг эсэн мэнд өнгөрүүлсэн эсэхийг нягтлан, гарсан эвдрэлийг тогтоов. Нэг гишүүн нь үерт боогдсон гишүүдийг аюулгүй газарт хүргэх резинэн салуудыг өгсөн байна. Хоол хүнс, хувцас, хөнжлийг хэрэгтэй байгаа бүх хүмүүст тараан, цуглааны байруудыг түр зуур хоргодох байр болгон гаргаж өгчээ. Цэвэр ус хамгийн их хэрэгтэй байсан учир ерөнхийлөгч Сааведра гал командын машин бүхий орон нутгийн нэг компанитай холбоо барьсны үр дүнд тэд түр хоргодох газрууд болсон цуглааны байруудад цэвэр ус хүргэж өгсөн ажээ. Эмнэлгийн мэргэжил, туршлагатай гишүүд бэртсэн хүмүүст эмнэлгийн тусламж үзүүлжээ.

Сүмийн гишүүд гамшгийг эсэн мэнд өнгөрүүлсэн болохоор ерөнхийлөгч Сааведра багийнхаа хамт хот дахь нүүлгэн шилжүүлэх бусад төвүүдэд очиж, туслахыг санал болгожээ. Тэд хүмүүст хоол хүнс, хангамжийн бусад зүйлсийг аваачиж өгсөн байна. Олон гишүүн гэр орноо алдсан ч шуурга зогсмогц амин хувиа бодолгүйгээр бусдад үйлчилсэн юм. Бороо зогсож, газар хатахад гурван гадасны "Мормон Тусламжийн Гар" сайн дурынхан хангамжийн зүйлсийг хүргэх, цэвэрлэгээ хийхэд туслахын тулд ажиллажээ.

Бразил

Бразилын Сэтэ Лагоас хотод мансууруулах бодист автсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асрах газар байдаг. Тэд бэрхшээлийг давж гарахын тулд өдөр бүр тэмцэж чармайж байв. Өдөрт 30 орчим жижиг талх хийхэд ашигладаг жижиг шарах зуух тэдэнд байжээ. Хэдийгээр тэр эмэгтэйчүүд орон нутгийн хүмүүнлэгийн тусламжийн холбооноос бага зэрэг тусламж авдаг байсан ч хоол хүнсээр хомсхон байлаа. Бразилын Сэтэ Лагоас гадасны сүмийн удирдагчид эдгээр эмэгтэйчүүдийн хэрэгцээг мэдээд тэдэнд туслахыг хүсчээ.

Тэд тэр эмэгтэйчүүдэд юу хэрэгтэй байгаа талаар нь ярилцжээ. Хэрэв тэд ахиухан талх хийж чаддагсан бол өөрсдийгөө хангаад зогсохгүй цөөхөн талх зараад л нэн тэргүүний хэрэгцээт орлогоо олж чадна гэж ярьсан юм.

Сүмийн удирдагчид болон гишүүд эдгээр эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд орон нутгийн цагдаагийн газартай мөн нэг сургуультай хамтран ажилласан байна. Сүмийн хүмүүнлэгийн тусламжаар мөн сүмийн болон орон нутгийн сайн дурынхны туслалцаа дэмжлэгтэйгээр байгуулсан талхны шинэ цех өдөр бүр 300 талх үйлдвэрлэх боломжийг тэдгээр эмэгтэйчүүдэд олгосон юм.

Эмэгтэйчүүд олсон орлогоороо талхны цехийн анхны ажилчнаар асрах газар дахь эмэгтэйчүүдийн нэгийг хөлслөн ажиллуулах боломжтой болж билээ.

Халамжийн ажил

Эргэн тойрныхоо хүмүүсийн тулгамдсан хэрэгцээг хараад тэднээс нүүр буруулаагүй олон арван жилийн өмнөх сүнслэгээр нөлөөлөгдсөн сүмийн удирдагчид шиг өнөөдөр дэлхий даяарх сүмийн удирдагчид болон гишүүд мөн ийм үйлчлэлийг орон нутагтаа өөр өөрийн арга замаар хийж байна.

Ерөнхийлөгч Угдорф бусдыг халамжлах талаар: "Гол гатлахгүйн тулд голын усыг дуусахыг хүлээн суух буюу хүнд хэцүү асуудлуудаа шийдвэрлэхгүй зүгээр суух нь Их Эзэний арга зам биш ээ. Нэгдэн нийлж, ханцуйгаа шамлан хөдөлмөрлөж, гүүр юм уу завь бүтээж өөрсдийн бэрхшээлийн голыг гатлах нь Их Эзэний арга зам мөн" хэмээн сүмд хандаж хэлжээ.[6]

Ядуусыг эрж олон, зовж зүдэрсэн хүмүүст үйлчлэх нь Есүс Христийн шавь байхад шийдвэрлэгч ач холбогдолтой юм. Энэ бол Есүс Христ Өөрийн цаг үеийн хүмүүст үйлчилж байсан тэр ажил юм. "Их Эзэний арга замаар хангах энэхүү ажил нь сүмийн үйл ажиллагааны жагсаалтад бичигдсэн жирийн нэг зүйл биш юм. Энэ ажлыг хойш тавьж, хайхралгүй өнгөрөөж болохгүй. Энэ бол манай шашны болон сургаалын гол үндэс мөн" гэж ерөнхийлөгч Угдорф хэлсэн байдаг.[7] ■

ЭШЛЭЛҮҮД

1. Гадасны эдгээр дөрвөн ерөнхийлөгч—Хью Б.Браун, Харолд Б.Лий, Хэнри Д.Моил, Марион Ж.Ромни нар хожим нь төлөөлөгчөөр дуудагдсан бөгөөд дөрвүүлээ хожим нь Тэргүүн Зөвлөлд үйлчилж байв. Харолд Б.Лий сүмийн 11 дэх ерөнхийлөгч болжээ.
2. 1930 онд Юта ажилгүйдлийн хувь хэмжээгээр Нэгдсэн Улсад хоёрдугаар байранд орж байв. Гарт Л.Мангум, Брус Д.Блүмэл, *The Mormons' War on Poverty: A History of LDS Welfare 1830–1990* (1993), 95.
3. Дийтр Ф.Угдорф, "Их Эзэний арга замаар хангах нь," *Лиахона,* 2011 оны 11-р сар, 54.
4. Дийтр Ф.Угдорф, "Их Эзэний арга замаар хангах нь," 55.
5. Дийтр Ф.Угдорф, "Та нар бол миний мутар," *Лиахона,* 2010 оны 5-р сар, 68.
6. Дийтр Ф.Угдорф, "Их Эзэний арга замаар хангах нь," 55.
7. Дийтр Ф.Угдорф, "Их Эзэний арга замаар хангах нь," 55–56.



Тэргүүн Зөвлөлийн болон Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын гишүүд бол “бүх дэлхийд Христийн нэрний тусгай гэрчүүд” (С ба Г 107:23) болох өнөө үеийн бошиглогч, үзмэрч, илчлэгчид юм. Иймээс тэд дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч Есүс Христ болон түүний зорилгын бурханлаг мөн чанарын тухай гэрчлэх үүрэг хариуцлагатай билээ.

Эдгээр сонгогдсон бөгөөд итгэмжлэл хүлээсэн эрэгтэйчүүд Аврагчийн Цагаатгал, амилалтыг мөн Тэрбээр амьд гэдэг нь үнэн бодитой тухай гэрчлэлээ доорх эшлэлүүдээр хуваалцаж байна.

Онцгой гэрчүүд амьд Христийн тухай гэрчилж байна

Есүс бол бидний Гэтэлгэгч

"Бурхан амьд гэдгийг миний бие онцгой гэрчийн хувьд бүх зүрх сэтгэл, оюун санааныхаа эрч хүчээр дуу хоолойгоо өргөн гэрчилж байна. Есүс бол Түүний Хүү, махан биеэр төрсөн Эцэгийн Ганц Хүү мөн. Тэр бол бидний Гэтэлгэгч; Тэнгэрлэг Эцэгийн өмнө бидний Зууч билээ. Тэрээр бидний гэм нүглийг цагаатгахын төлөө загалмай дээр амьсгал хураасан юм. Тэрбээр амилалтын анхны үр жимс болсон. Тэр амиа өргөсөн учраас бүх хүн дахин амьдрах болно. 'Би Гэтэлгэгч амьдыг мэднэ' гэсэн энэ өгүүлбэр надад ямар агуу баяр баяслыг бэлэглэдэг гээч!" ["Би Гэтэлгэгч амьдыг мэднэ" *Сумийн дуулал болон хүүхдийн дуу* х. 38].

Ерөнхийлөгч Томас С.Монсон, "Гэтэлгэгч минь амьдыг би мэднэ!" *Лиахона,* 2007 оны 5-р сар, 25..

Би бол гэрч

"Би тэр нэгэн үдэш хоёр шавийнх нь Еммау дахь гэрт тэдэнтэй хамт байсан мэт Их Эзэний амилалтыг баттайгаар гэрчилж байна. Тэр нэгэн хурц нартай өглөө Иосеф Смит Палмира дахь ойн төгөлд Эцэг, Хүү хоёрыг гэрэлт баганад харахдаа Түүнийг амьд гэж мэдэж авсан шиг Тэр амьд гэдгийг би баттайгаар мэднэ. . . .

". . . Иймээс бидний амилсан Аврагч ба Гэтэлгэгчийн гэрчийн хувиар би гэрчилж байна."

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, "Надад ирэгтүн," *Лиахона,* 2013 оны 5-р сар, 25.

Цагаатгал ба аврал

"Бурхан Эцэг бол сайн мэдээний зохиогч; энэ бол Бурханы авралын төлөвлөгөөний эсвэс гэтэлгэлийн төлөвлөгөөний хамгийн чухал хэсэг юм. Есүс Христийн Цагаатгал гэтэлгэл ба авралыг боломжтой болгосон учраас үүнийг Есүс Христийн сайн мэдээ гэдэг. Бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүд биеийн үхлээс аливаа болзолгүйгээр гэтэлгэгдэх бөгөөд Есүс Христийн сайн мэдээг хүлээн авч, дуулгавартай дагасан нөхцөлд бүх хүмүүс нүглээсээ гэтэлгэгдэх болно . . . .

"Энэ тухай би бүх зүрх сэтгэл, оюун ухаанаараа гэрчилж байна."

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, "Бидэнд баярлах шалтгаан байхгүй гэж үү?" *Лиахона,* 2007 оны 11-р сар, 19, 21.

LEAD, KINDLY LIGHT, СИМОН ДЬЮВЭЙ © ALTUS FINE ART; СУУРЬ ЗУРГИЙГ ЭРИК ЖОНСЭН

Есүс бол Христ

“Бурхан бол бидний Эцэг гэдгийг би мэднэ. Тэрбээр Өөрийн Хүү Есүс Христийг Иосеф Смитэд танилцуулсан юм. Есүс бол Христ гэдгийг би мэднэ гэдгээ та бүхэнд тунхаглаж байна. Тэр амьдыг би мэднэ. Тэрбээр цагийн голчид мэндэлсэн билээ. Түүнийг Өөрийн сайн мэдээг заасных нь төлөө шүүсэн юм. Тэр гашуунаар зовон шаналж, цовдлогдоод гурав дахь өдрөө амилсан. Тэрбээр Эцэгийнхээ адил мах, ясан биетэй. Тэрбээр Өөрийн Цагаатгалыг хийсэн. Түүний тухай гэрчлэлээ би хэллээ. Би бол Түүний гэрч.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч Боид К.Пакэр, “Арванхоёр,” *Лиахона,* 2008 оны 5-р сар, 87.

Хүмүүний гэр бүлийн төлөөх төлөөс

“[Есүс Христ] бол Эцэгийн мөнхийн төлөвлөгөөний төвд байдаг бөгөөд хүн төрөлхтний өмнөөс нүглийн төлөөсийг нь төлсөн Аврагч юм. Бурхан Адам, Ева хоёрын уналтыг ялахын тулд хайртай хүүгээ илгээсэн билээ. Тэрбээр бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч байхаар дэлхийд ирсэн. Тэр Өөрийн амийг бидний төлөө өгснөөр бие махбодын үхлийн саад тотгорыг даван туулсан юм. Түүнийг загалмай дээр амьсгалаа хураахад Түүний сүнс биеэс нь салсан. Гурав дахь өдөр нь Түүний сүнс, бие хоёр дахин хэзээ ч салахгүйгээр үүрд эргэн нэгдсэн юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Л. Том Пэрри, “Авралын төлөвлөгөө,” *Лиахона,* 2006 оны 11-р сар, 71.

Хүн төрөлхтний түүхийн гол үйл явдал

“Түүний хөлс нь цусны дусал мэт дусалж байсан Гетсеманид (Лук 22:44), түүнчлэн “гавлын газар” буюу үхэл гэсэн утгатай Голгота (эсвэл Калвари) дээр Түүний бие загалмай дээр өргөгдсөнөөр [Аврагчийн] Цагаатгал хийгдсэн юм (Марк 15:22; Матай 27:33; мөн 3 Нифай 27:14-ийг үзнэ үү). Энэхүү хязгааргүй Цагаатгал төгсгөлгүй үхлээс хүмүүнийг чөлөөлсөн юм (2 Нифай 9:7-г үзнэ үү). Аврагчийн Цагаатгал амилалт ба мөнх амьдралыг бүх хүмүүст боломжтой болгосон билээ. Түүний Цагаатгал бүх хүн төрөлхтний түүхэнд гол үйл явдал болсон юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон, “Аврагч амьд гэдгийг мэдэхээс ирдэг амар амгалан ба баяр баясгалан,” *Лиахона,* 2011 оны 12-р сар, 22.

Нүглийн төлөөх золиослол

“Есүс Христ бүх хүмүүсийн нүглийн төлөө Өөрийгөө золиослохын тулд ойлгохын аргагүй зовлон шаналлыг амссан билээ. Энэхүү золиослол нь сайн сайхны дээд оргил болсон өө сэвгүй цэвэр Хургыг хилэнцийн дээд хэмжүүр болох бүх дэлхийн нүглийн төлөө өргөл болгосон юм. . . .

“Энэхүү золиослол—Есүс Христийн Цагаатгал авралын төлөвлөгөөний төвд байдаг билээ. . . .

“Есүс Христ бол Мөнхийн Эцэг Бурханы Төрсөн Ганц Хүү гэдгийг би мэднэ. Түүний цагаатгагч золиослолын ачаар бидэнд үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралын боломж баталгаатай байдаг билээ. Тэр бол бидний Их Эзэн, бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс, “Золиослол,” *Лиахона,* 2012 оны 5-р сар, 19, 22.

Аврагч өнөөдөр Өөрийн сүмийг удирддаг

“Есүс Христийн Цагаатгал нь бидний авралын төлөө дэлхий дээр Түүний Хүүгийн гүйцэтгэх үүргийн талаарх бидний Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний салшгүй хэсэг байлаа. Бидний Тэнгэрлэг Эцэг зуучийн үүрэг гүйцэтгээгүйн төлөө, тэрчлэн эцэг хүний зөн совингоороо Хайртай Хүүгээ авраагүйн төлөө бид хэчнээн их талархалтай байх ёстой билээ. Тэрбээр та нарыг болон намайг мөнхийн хайраар хайрладаг учраас бидний Гэтэлгэгч байх урьдчилан томилогдсон үүргээ гүйцэлдүүлэх боломжийг Есүст олгосон билээ. . . .

“Бүх хүн төрөлхтөний Аврагч бөгөөд Гэтэлгэгч Есүс Христ амьд юм. Бурханы амилсан Хүү амьд—Тэрбээр амьд гэдгийг би гэрчилж байна. Мөн Тэрбээр өнөөдөр Өөрийн сүмийн ажил хэргийг удирддаг билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч М.Рассэлл Баллард, “Цагаатгал ба нэг бодгалийн үнэ цэнэ,” *Лиахона,* 2004 оны 5-р сар, 85, 86.

Бидний найдвар, бидний Зууч мөн бидний Гэтэлгэгч

“Бидний аюулгүй байдал [бидний Тэнгэрлэг Эцэг], түүний Хайрт Хүү Есүс Христ хоёрын гарт байдаг билээ. Аврагч та нарт хайртайг би мэднэ. Та нарын гэрчлэл амьдралд тань сайн сайхан зүйлсийг авчрагч төгс хүч, тодорхой бус байдлын энэ цаг үед амар амгаланг ба итгэл найдварыг өөрт тань өгөгч хүч байхын төлөө гэрчлэлээ хүчирхэгжүүлэх таны хичээл зүтгэлийг Тэрбээр батлах болно.

“Түүний тухай гэрчлэх эрх мэдэл олгогдсон Түүний Төлөөлөгчдийн нэг миний бие Аврагч амьд гэдгийг, Тэр бол амилж, алдар сууг олсон, төгс хайраар дүүрэн хүн гэдгийг мэднэ гэдгээ би хүндтэйгээр гэрчилж байна. Тэр бол бидний найдвар, бидний Зууч мөн бидний Гэтэлгэгч.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г.Скотт, “Бат бөх гэрчлэлийн хүч,” *Ensign,* 2001 оны 11-р сар, 89; *Лиахона,* 2002 оны 1-р сар, 103.

Гашуун аяганаас уусан нь

“Гетсеманий цэцэрлэгт бидний Аврагч мөн Гэтэлгэгч Цагаатгалын гашуун аяганаас уухаас ухарч няцаагүй юм [С ба Г 19:16–19-ийг үзнэ үү]. Мөн Тэрээр Эцэгийнхээ хүслийг биелүүлэхийн тулд эцэс сүүлд нь “Энэ нь төгслөө” [Иохан 19:30] гэж хэлэх хүртлээ загалмай дээр дахин зовсон юм. Тэр эцсээ хүртэл тэвчсэн билээ. Аврагчийн бат зогсож байсан төгс дуулгавартай байдлын хариуд Тэнгэрлэг Эцэг маань Түүнийг ‘Миний Хайрт Хүүг, миний ихэд таалсан түүнийг, би өөрийнхөө нэрийг алдаршуулсан түүнийг болгоогтун’ [3 Нифай 11:7] хэмээн тунхагласан.

“. . . Бүгдээрээ Аврагч Есүс Христтэй хамт бат зогсож, Бурханы нэрийг алдаршуулцгаая. Тэр амьд гэдгийг би онцгойлон гэрчилж байна.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс, “Ариун газруудад бат зогсоцгооё,” *Лиахона,* 2013 оны 5-р сар, 51.

Бурханы цорын Ганц төгс Хүү

“Бурхан бол ямар ч цаг үе, ямар ч газарт мөн ямар ч нөхцөл байдалд биднийг хайрлагч, биднийг өршөөгч Тэнгэр дэх Эцэг минь юм гэдгийг би мэддэг. Эцэг ба Хүүгийн хүслийн дагуу төгс бус биднийг аврахаар сайн дураараа харамгүйгээр амиа өгсөн Есүс бол Бурханы цорын ганц төгс хүү байсан гэдгийг би мэднэ. Тэрээр үхээд дахин амьдрахын тулд амилсан бөгөөд Тэр үүнийг хийсэн учраас та ч мөн бид ч амилах болно гэдгийг би мэднэ.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд, “Эзэн минь, би итгэж байна,” *Лиахона,* 2013 оны 5-р сар, 95.

Аврагч амьдыг би мэднэ

"Би Их Эзэн Есүс Христийн мөнхийн, хязгааргүй золиослолыг гэрчлэн, талархлаа өргөж байна. Аврагч амьдыг би мэднэ. Түүний гэтэлгэгч хүчийг бас Түүний хүч чадал өгөгч хүчийг би биеэрээ үзсэн хүн. Тиймээс би эдгээр хүч үнэн бодитой бөгөөд бид бүгдэд боломжтойг гэрчилж байна. Бид мөнх бус амьдралын аянд урагш тэмүүлэхдээ 'Их Эзэний хүчээр' бүх зүйлийг хийж чадна мөн бүх сорилт, бэрхшээлийг даван туулж чадна."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар, "Цагаатгал ба мөнх бус амьдралын аян," *Ensign,* 2012 оны 4-р сар, 47; *Лиахона,* 2012 оны 4-р сар, 19.

Христ үүргээ биелүүлсэн

"[Аврагч] 'хүн төрөлхтний нүглүүдийн ачаа дарамтыг' болон 'Сатаны учруулж мэдэх . . . аймшгуудыг' [Жэймс Э.Талмэйж, *Jesus the Christ,* 613] Өөр дээрээ авсан юм. Тэрбээр энэхүү үйл явцад ад зэтгэрийн аргаар зохион бодсон тамлах аргуудыг хийгээд цовдлолт руу хөтөлсөн аймшигт, эмгэнэлт үйл явдлуудыг хүлцэн тэвчсэн билээ. Энэхүү үйл явц Улаан өндөгний баярын ням гарагт Христийн ялгуусан амилалтаар дууссан юм. Ийнхүү Христ Аврагч ба Гэтэлгэгчийн ариун үүргээ биелүүлсэн юм. Бид бас үхлээс амилуулагдаж, бидний сүнс биетэйгээ дахин нэгдэх болно. . . .

"Есүс Христ амьд, Тэрээр дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч мөн гэдгийг би төлөөлөгчийн хувиар гэрчилж байна. Тэрээр жинхэнэ аз жаргалд хүрэх замыг бэлтгэсэн билээ."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Квинтин Л.Күк, "Бид Есүс Христийг дагадаг," *Лиахона,* 2010 оны 5-р сар, 83–84, 86.

Аврагч биднийг гэтэлгэсэн

"Аврагч Гетсеманид болон загалмай дээр зовон шаналснаараа бидэн дээр ирэх шударга ёсны шаардлагуудыг хангаж, биднийг нүглээс гэтэлгэсэн юм. Тэрбээр наманчилдаг хүмүүсийг уучилж, ариусгадаг. Цагаатгал нь бас бусдын буруу үйлдлийн улмаас бидэнд учирсан зовлон зүдгүүрээс биднийг эдгээж, хохирлыг нөхөн барагдуулах шударга ёсны шаардлагыг хангадаг. "Учир нь болгоогтун, тэрээр бүх хүмүүний шаналлыг тэвчинэ, тийм ээ амьдрагч бүхний шаналлыг, Адамын гэр бүлд багтах эр, эм, хүүхэд аль алиных нь болой" (2 Нифай 9:21; мөн Алма 7:11–12-ыг үзнэ үү). . . .

". . . Төгс гэтэлгэл нь зөвхөн Есүс Христээр, гагцхүү Түүгээр ирсэн юм. Тэрбээр Гэтэлгэгч гэдгийг би даруухнаар мөн талархалтайгаар хүлээн зөвшөөрч байна."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д. Todd Кристоффэрсон, "Гэтэлгэл," *Лиахона,* 2013 оны 5-р сар, 110, 112.

Амилалт ба амь

"Бид юуны түрүүнд өөрсдийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч Есүс Христийг тунхагладаг. Бид бүгд одоо ямар байгаагаараа, ирээдүйд ямар байхаараа Түүнд өртэй юм. . . .

"Түүний дараах үгс зуун зууныг дамжин цуурайтсаар байна:

"'Би бол амилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч амьдарна:

"'Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй' (Иохан 11:25–26).

"Ах эгч нар аа, Тэр амьд. Тэр амилсан. Тэр дэлхий дээрх Өөрийн ариун ажлыг удирддаг."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн, "Түүнд ирэгтүн," *Лиахона,* 2009 оны 5-р сар, 80.

АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ НЬ

Амилсан хүн ямархуу байдалтай харагдах бол?

"Энэ амьдралыг туулсны дараа бидний . . . бие алдар сууг олж, аливаа өвчин зовлонгоос ангид, үзэсгэлэн төгөлдөр болно. Амилуулагдсан эрэгтэй эсвэл эмэгтэй хүнийг харахаас илүү сайхан зүйл гэж байхгүй болно. Эрэгтэй хүн [эсвэл эмэгтэй хүн] амилсан биетэй болсноос илүү сайхан зүйл байхгүй байна хэмээн би төсөөлөн бодож байна. Эхний амилуулалтын өглөө алдар сууг олсон хүмүүн болж босч ирэн, Бурханы оршихуйд өргөмжлөгдөх найдварыг агуулаагүй нэг ч хожмын үеийн гэгээнтэн . . . байхгүй гэдэг нь тодорхой юм."

Ерөнхийлөгч Лорэнзо Снөү (1814–1901), Conference Report, 1900 оны 10-р сар, 4.

ABIDE WITH ME, СИМОН ДЬЮВЭЙ © ALTUS FINE ART

Далын ахлагч
Виллиам Р.Вокэр

БОШИГЛОГЧИЙГ дага

Хэдэн жилийн өмнө, Ерөнхий чуулганы яг өмнөхөн ерөнхийлөгч Томас С.Монсон нэгэн гайхалтай хичээл заасан билээ. Энэ удаад тэрээр бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлүүдэд үйлчилж байсан бөгөөд дэлхийн өнцөг булан бүрээс Солт Лэйк хотод ирсэн ерөнхий эрх мэдэлтнүүдэд заасан юм. Энэ бол маш чухал хурал байсан юм. Бидэнд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын зөвлөл заавар өгөх гэж байлаа.

Хурал эхлэх гэж байхад ерөнхийлөгч Монсоноос бусад нь бүгд ирсэн байв. Хурал эхлэхээс хэдхэн минутын өмнө бид бие биетэйгээ хууч хөөрөхөө зогсоож, бошиглогч удахгүй ороод ирэх байх гэж бодоод оршил хөгжмийг сонсон, хүндэтгэлтэйгээр сууж байлаа.

Өглөөний 9 цаг ч болж, бүр өнгөртөл нь бид тэвчээртэйгээр хүлээлээ. Мэдээж хэрэг, тусламж хэрэгтэй болсон эсэхийг шалгахаар хэн нэг нь хажуу хаалгаар гарав. Буцаад орж ирэхдээ "ерөнхийлөгч Монсон удахгүй ирнэ" гэлээ.

Хурал эхлэх ёстой байсан цагаас 15 минутын дараа ерөнхийлөгч Монсон орж ирэв. Түүнийг орж ирэхэд бид хүндэтгэл үзүүлэн бослоо. Бид түүнийг хараад зүгээр байсанд нь санаа амарсан юм. Гэхдээ түүнийг яагаад хоцорсныг илтгэх ямар нэг мэдэгдэхүйц шалтгаан харагдсангүй.

Ерөнхийлөгч Монсон шууд индэр дээр гараад "Ах нар аа, хоцорсонд уучлаарай, гэхдээ энэ өглөө эхнэрт минь миний тусламж хэрэгтэй байсан юм" гэж хэлэв.

Надад үнэхээр гүн сэтгэгдэл төрж, их даруусч билээ. Би ерөнхийлөгч Монсоны хэлсэн үгсийг бодохгүй байж чадахгүй байсан.

Энэ бол маш чухал хурал байсан ба сүмийн ахмад удирдлага тэр чигээрээ цугласан байсан ч ерөнхийлөгч Монсон бүгдэд нь үлгэр жишээ үзүүлсэн юм. Түүний тусламж хэрэгтэй үед тэрээр эхнэрээ халамжлахын тулд цаг гаргасан байна. Энэ нь их том сургамж байсан. Би тэр өдрийн сургалтаас зөвхөн тэр том сургамжийг л санадаг: "Эхнэрт минь миний тусламж хэрэгтэй байсан юм."

Хэрэв бид ерөнхийлөгч Монсонг дагаж, түүнтэй илүү адилхан байхыг хичээн чармайвал Их Эзэн Есүс Христийн итгэлтэй шавь нар байх үйлсэд гарцаагүй амжилт олох болно.

Бошиглогчийн үлгэр жишээг дагах нь

Би ерөнхийлөгч Монсоны жишээг дагах 5 арга замыг санал болгох гэсэн юм.

1. Бид аливаад өөдрөг нааштай хандвал аз жаргалтай байж чадна.

Агуу Үнэт Сувд номд бошиглогч Иосеф Смитийг "хөгжүүн баяр хөөртэй" хэмээн дүрсэлсэн байдаг (Иосеф Смит—Түүх 1:28). Энэ нь мөн адил ерөнхийлөгч Монсонг дүрсэлдэг.

Нэг удаа ерөнхийлөгч Монсон "Бид . . . эерэг хандлагатай байхыг сонгож чадна. Бид салхины чигийг өөрчилж чадахгүй ч завиныхаа жолоог чиглүүлж чадна. Өөрөөр хэлбэл, бидэнд юу ч тохиолдож байсан, бид эерэг хандлагатай, аз жаргалтай байхыг сонгож чадна" гэж хэлсэн.[1]

Нэгэн өдөр би Тэргүүн Зөвлөлийн танхимын гадна сууж байлаа. Намайг тэнд ариун сүмийн ажил хэргийн талаар хэлэлцэхээр урьсан байсан юм. Би өрөөний гадаа чимээгүйхэн сууж байхдаа Тэргүүн Зөвлөл аль хэдийн хуралдаад эхэлчихсэн, намайг удахгүй дуудах байх гэж бодож байв.

Намайг тэнд сууж байхад танхимд нэг хүн шүгэлдээд явж байхыг би сонслоо. "Хэн нэгэн ёс зүйн талаар ойлголтгүй л явж байна даа. Сүмийн ерөнхийлөгчийн

Ерөнхийлөгч Монсон ариун сүм бүрийг адислахдаа хүүхдүүдийг их анхаардаг. Тэр тэднийг ариун сүмийн булангийн чулуу тавих ёслолд оролцуулах дуртай.

өрөөний гадаа шүгэлдээд явж болохгүй шүү дээ" гэж би дотроо бодов.

Төд удалгүй нөгөө шүгэлдэж байсан хүн булан тойроод гарч ирсэн нь ерөнхийлөгч Монсон байсан юм. Тэрээр аз жаргалтай бас өөдрөг байв. Тэр надтай сайхан мэндлээд "бид хурлаа хэдэн минутын дараа эхлэх байх аа" гэж хэлж билээ.

Сүмийн бүхий л ачааг мөрөн дээрээ үүрдэг ч тэрээр аз жаргалтай байхын үлгэр жишээ байж, үргэлж л эерэг хандлагатай байдаг. Бид ч тийм байх ёстой.

2. Бид хүүхдүүдэд эелдэг байж, хайраар хандаж чадна.

Есүс хүүхдүүдийн талаар олонтоо ярьдаг байсан. Түүний бошиглогч, ерөнхийлөгч Монсон мөн адил хүүхдүүдийн талаар ярьдаг ба ялангуяа ариун сүмийн онцгойлон адислал дээр хүүхдүүдийг хэрхэн хайрлаж байгаа нь хүүхдүүдэд хэрхэн хандахыг бидэнд заадаг. Ариун сүмийн онцгойлон адислал бүрд тэр хүүхдүүдэд анхаарлаа илүү хандуулдаг. Тэр хүүхдүүдийг булангийн чулууны ёслолд оролцуулах дуртай бөгөөд үргэлж хэдэн хүүхдийг булангийн чулуунд хэсэг шавар тавьж, ариун сүмийг барьж дуусгасны бэлэгдэлд оролцоход урьдаг билээ. Тэр үүнийг тэдэнд зугаатай ажил болгож чаддаг. Бас дурсамжит үйл явдал болгодог. Тэр үргэлж тэдэн рүү маш сайхан инээмсэглэдэг. Мөн тэднийг зоригжуулж, сайшаадаг. Үүнийг харах үнэхээр гайхалтай байдаг.

Түүний дотно мэндчилгээнүүд нь хааяа хэн нэгэнтэй алгаараа цохилцох, чихээ хөдөлгөх зэргээр харагддаг бөгөөд номлолд үйлчлэх, ариун сүмд гэрлэхийг мөн адил урамшуулан дэмждэг билээ.

Хэдэн жилийн өмнө, ерөнхийлөгч Монсон Өүкр Маунтэн ариун сүмийг онцгойлон адислахад энэ өдөр нь түүний төрсөн өдөртэй давхацсан байжээ. Түүнийг ариун сүм дээр ирж, урд хаалганд ойртон ирэхэд хэсэг залуучууд цугласан байлаа. Мэдээж хэрэг, тэд ерөнхийлөгч Монсоны төрсөн өдрийг мэдэж байсан учраас "Төрсөн өдрийн баяр" дууг дуулж эхлэв. Энэ нь түүнд маш их таалагдаж, тэрээр нүүр дүүрэн инээмсэглэв. Тэгээд бас тэднийг өөрөө удирдаж байгаа юм шиг дуулж байхад нь гараараа дохиж эхлэв. Тэд дууныхаа төгсгөлд "урт наслаарай та" гэдэг үгсийг нэмэхэд нь ерөнхийлөгч Монсон надад "энэ хэсэг нь их таалагдлаа" гэж хэлж билээ.

Миний бодлоор түүнийг тэдэнд хайртай гэдэгт нь сүмийн хүүхэд, залуучууд огт эргэлздэггүй учраас тэд түүнд хайртай байдаг!

3. Бид Сүнсний өдөөлтүүдийг дагаж чадна.

Ерөнхийлөгч Монсон: "Амьдралд тохиох хамгийн нандин зүйл бол Сүнсний өдөөлтийг мэдрээд түүний дагуу үйлдэж, дараа нь энэ нь хэн нэгний хэрэгцээ эсвэл залбирлын хариулт байсан гэдгийг олж мэдэх явдал юм. Түүнчлэн хэрэв Их Эзэнд ямар нэг ажил гарвал Том Монсон Түүний төлөө ажлыг нь гүйцэлдүүлэх болно гэдгийг Их Эзэн мэддэг байгаасай гэж би үргэлж хүсдэг" хэмээн Их Эзэний төлөөх үнэнч байдлаа мөн Сүнсний өдөөлтийг дагах амлалтаа яруу тодоор илэрхийлсэн юм.[2]

Бидний хүн нэг бүр ийм загварыг л дагахыг хүсэх хэрэгтэй.

4. Бид ариун сүмийг хайрлаж чадна.

Ерөнхийлөгч Монсон ариун сүм барьж байсан, сүмийн түүхэн дэх агуу хүмүүсийн нэгэнд зүй ёсоор багтана. Тэрээр 2008 оны 2-р сард ерөнхийлөгч болсноосоо хойш, ариун сүм барих агуу ажлыг үргэлжлүүлсээр байгаа билээ. Ерөнхийлөгч Монсон бошиглогч байх 5 жилийн хугацаандаа 33 шинэ ариун сүмийг зарласан юм.

Тэр бидэнд бас: "Бидний хүн нэг бүр цэвэр гар, цэвэр зүрх сэтгэлтэйгээр зохистой амьдрах болтугай. Тэгснээр ариун сүм бидний болон гэр бүлийн маань амьдралд хүрч, адислах болно" гэж хэлсэн.[3]

Мөн тэр дараах гайхалтай амлалтыг нэмж хэлсэн юм: "Бид ариун сүмийг хайрлаж, ариун сүмд хүрч, мөн ариун сүмд орсноор бидний амьдрал итгэлийг маань ямар түвшинд байгааг харуулах болно. Бид эдгээр Бурханы өргөөнд ирж, ариун сүм дотор хийдэг гэрээнүүдээ санаснаар *бид сорилт бүрээ тэвчиж, уруу таталт*

болгоныг давах боломжтой байх болно.”[4]

Ариун сүмийг хайрлах талаарх бошиглогчийн бидэнд харуулсан загварыг дагацгаая.

5. Бид эелдэг, нинжин сэтгэлтэй байж мөн бусдыг хайрлаж чадна.

Ерөнхийлөгч Монсон бол бусдыг хайрлах тухайд гайхалтай үлгэр жишээ болох хүн юм. Түүний бүхий л үйлчлэл өрх гэрүүдэд зочилсон айлчлалтуудаар; адислал өгөхийн тулд хүмүүсийн толгой дээр гараа тавьснаар; бусдыг тайтгаруулж, дэмжсэн төлөвлөөгүй утасны дуудлагуудаар; урам хайрлаж магтсан, талархал илэрхийлсэн захидлууд; эмнэлэг, халамжийн төвүүдэд очсон зочлолтуудаар дүүрэн юм. Тэрээр амсхийх зав чөлөөгүй их ажлын хажуугаар бас талийгаачидтай салах ёс гүйцэтгэх, оршуулганд нь оролцох цаг гаргаж чаддаг.

Ерөнхийлөгч Монсон Аврагчтай адилаар сайныг үйлдэж, (Үйлс 10:38-ыг үзнэ үү), бусдыг адислан, тэднийг хайрлаж явна. Энэ нь түүний амьдралд удирдан чиглүүлэгч хүч болдог.

Ерөнхийлөгч Монсоны эелдэг зангийн онцгой нэгэн жишээ 2012 онд харагдсан билээ. Ютагийн Бригам хотын гоёмсог ариун сүм баригдаж дуусах гэж байхад онцгойлон адислах төлөвлөгөөний талаар ярилцахаар би Тэргүүн Зөвлөлтэй уулзсан юм. Бригам хот нь Солт Лэйк хотоос хойд зүгт ганцхан цагийн зайтай байдаг учраас ерөнхийлөгч Монсоны хувьд тийшээ очоод онцгойлон адислахад тун амархан байх байлаа.

Үүний оронд ерөнхийлөгч Монсон: “Бригам хот бол ерөнхийлөгч Боид К.Пакэрын төрсөн хот, энэ агуу төлөөлөгч надтай мөр зэрэгцэн Арванхоёрт олон жилийн турш үйлчилсэн. Би түүнийг өөрийнхөө төрсөн хот дахь ариун сүмийг өөрөө онцгойлон адислах энэхүү хүндэтгэл, адислалыг хүртээсэй гэж хүсч байна. Би энэ удаад өнжиж, Бригам хотын ариун сүмийг онцгойлон адислахаар ерөнхийлөгч Пакэрыг томилох болно. Би түүнийг баярлуулмаар байна” гэж хэлж билээ.

Энэ нь ерөнхийлөгч Пакэрт болон Бригам хотод өссөн Пакэр эгчийн хувьд мөн адил гайхалтай өдөр байлаа. Би ерөнхийлөгч Монсоны төлөөлөгч найздаа үзүүлсэн эелдэг, сайхан сэтгэлийн илэрхийллийг хараад сэтгэл үнэхээр их хөдөлж билээ. Бид бүгд тийм байж чадна. Бид хуваалцаж, эелдэг байж, өөрсдийгөө биш харин эргэн тойрны хүмүүстээ санаа тавьж чадна.

Бошиглогчийн загвар

Ерөнхийлөгч Монсон бидэнд амьдралаа хэрхэн авч явах замыг Ерөнхий чуулган дээр өөрийн гайхалтай, сүнслэгээр нөлөөлсөн захиасуудаараа заасаар ирсэн билээ. Тэр бидэнд хэрхэн Есүс Христийн дагалдагчид байхыг өөрийнхөө гайхалтай жишээгээр харуулсаар ирсэн юм. Их Эзэн үнэхээр бүх зүйлд загварыг өгсөн. Бидний дагахаар эрэлхийлэх ёстой загваруудын нэг бол хайрт бошиглогчоо дагах явдал юм.

Тэнгэрт биднийг мэддэг бас хайрладаг Бурхан байдаг гэдгийг би гэрчилж байна. Тэр энэ хожмын өдрүүдэд биднийг удирдаж, бидэнд зааж мөн биднийг чиглүүлэх бошиглогчийг бидэнд өгсөн. Бошиглогчоо хайрлаж, дэмжин, үлгэр жишээг нь дагахыг Их Эзэн биднээс хүсэн хүлээдэг гэдэгт би итгэдэг.

Би Томас С.Монсоныг Их Эзэний бошиглогч байх өдрүүдэд амьдарч байгаагаа агуу адислалд тооцдог. Бид бошиглогчоо дагаж, түүнтэй илүү адил байхыг хичээснээр гарцаагүй Их Эзэн Есүс Христийн итгэлтэй шавь нар болох болно. ■

Ерөнхийлөгч Монсон Аврагчийн нэгэн адилаар сайныг үйлдэж, бусдыг адислан, тэднийг хайрлаж явна. Энэ нь түүний амьдралд удирдан чиглүүлэгч хүч болдог.

Айдахо дахь Бригам Янгийн Их сургууль дээр 2013 оны 5-р сарын 5-нд болсон Сүмийн Боловсролын Системийн онцгой цугларалт дээр хэлсэн үгээс. Хэлсэн үгийг бүрнээр нь уншихыг хүсвэл lds.org/broadcasts хаягаар орно уу.

ЭШЛЭЛҮҮД

1. “Messages of Inspiration from President Monson,” *Church News,* 2012 оны 9-р сарын 2, 2
2. *On the Lord’s Errand* (DVD, 2008).
3. Томас С.Монсон, “Ариун сүмийн адислалууд,” *Лиахона,* 2010 оны 10-р сар, 19.
4. Томас С.Монсон, *Be Your Best Self* (1979), 56; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.

Филиппин:

ДАЛАЙН АРЛУУД ДЭЭРХ СҮНСЛЭГ ХҮЧ

“Дорнын сувд” хэмээн нэрлэгддэг Филиппинд сүм 53 жилийн богино-хон хугацаанд гайхал-тай хүч чадал, өсөлт хөгжилтөд хүрчээ.

Нэгдсэн Улсаас ирсэн хоёр залуу номлогчийн Аугусто А.Лимд заасан захиас үнэн гэдгийг нь түүний аль хэдийнээс мэддэг байсан зарчмууд баталсан ажээ. Залуу хуульч бөгөөд Христийн шашинтан Аугусто илчлэлт өнөөдрийг хүртэл байнга ирсээр байгаа гэх мэтийн сургаалууд нь “ахлах сургууль болон коллежид сурч байхдаа л миний итгэдэг байсан зүйлүүд” байлаа гэж хэлэв.[1]

Хэдэн сарын дараа Аугусто ням гарагт болдог сүмийн цуглаануудад оролцохыг зөвшөөрч, Мормоны Номыг уншиж, түүний талаар залбирах урилгыг хүлээн авчээ. “Би Мормоны Номыг Моронайн бидэнд зөвлөсөн тийм сүнстэйгээр нухацтай уншиж эхэлсэн. Би энэ ном үнэн үү гэдгийг мэдэх хүсэлтэйгээр уншиж эхлээд дөнгөж хэдхэн мөр уншсаны дараа гэрчлэлтэй болж эхэлсэн” гэж дурсав.[2]

1964 оны 10-р сард Аугусто Лим баптисм хүртэж, Филиппин дэх Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны гишүүн болжээ. Мөн удалгүй эхнэр нь мөн гэр бүл нь сүмд нэгдсэн байна. Тэрээр сүмд хэдэн арван жил иттэлтэйгээр үйлчилсэн бөгөөд 1992 онд ерөнхий эрх мэдэлтнээр үйлчлэхээр дуудагдсан нь уг албан тушаалд үйлчилсэн анхны филиппин хүн юм. Өнөөдөр Лим ах—“Дорнын сувд” гэгддэг энэ оронд амьдардаг хэдэн зуун мянган хожмын үеийн гэгээнтнүүдийн иттэл, чин сэтгэлийн үйлчлэлийн бэлгэдэл болж байна.

Сайн мэдээний үрийг суулган, соёолуулж буй үржил шимтэй газар

Есүс Христийг мэндлэхээс 550 орчим жилийн өмнө Их Эзэн Мормоны Номын бошиглогч Нифайд: “Би далайн арлууд дээрх тэднийг санахыг, мөн өөрийн үгийг хүмүүний үрст, тийм ээ, бүр дэлхийн бүх үндэстний дээр авчрах” (2 Нифай 29:7) болно хэмээн амласан билээ. Эдгээр үнэ цэнэтэй үгсийг уншсан олон хүнд “далайн арлуудын” нэг нь Филиппин мөн хэмээн бодогддог.

100 сая шахам хүн амтай Бүгд Найрамдах Филиппин Улс Азийн зүүн өмнөд эргийн 7100 орчим арал бүхий том олтриг дээр оршдог. Филиппин бол нөхөрсөг, хөгжилтэй, даруухан хүмүүс оршин суудаг, халуун бүсийн үзэсгэлэнт сайхан орон юм. Гэсэн хэдий ч энэ улс газар хөдлөлт, далайн хар салхи, галт уулын дэлбэрэлт, далайн түрлэгүүдэд болон байгалийн бусад гамшгуудад өртөмтгий; эдийн засаг, нийгмийн олон асуудал хуримтлагдсан орон юм. Өргөн тархсан ядуурал байнга сорилт бэрхшээл учруулж, филиппинчүүд улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн ужиг хямралын үеүдийг даван туулсаар ирсэн юм.

Гэвч Их Эзэний замуудыг мэддэг болсон хүмүүст Филиппин нь сайн мэдээний үрийг суулган соёолуулах үржил шимтэй газар юм. Олон филиппин хүн тагалог болон бусад төрөлх хэлнийхээ хажуугаар мөн л үндэсний хэл нь болсон англи хэлээр ярьдаг. Испаний захиргаанд удаан хугацаагаар байсан учраас хүн амын 90 гаруй хувь нь Христийн шашинтнууд, харин цөөнхийн үлэмж хэсэг нь лалын шашинтнууд юм.

Сүмийг Филиппинд нэвтрүүлэх анхны оролдлогыг 1898 онд Испани-Америкийн дайны үеэр Ютагийн хожмын үеийн гэгээнтэн цэргийн албан хаагч Виллард Кол, Жорж Сиймэн нар хийсэн ажээ. Тэднийг Ютагаас явахаас нь өмнө номлогчоор адисалжээ. Тэд боломж

УСАН ОНГОЦНЫ ГЭРЭЛ ЗУРГИЙГ © GETTY IMAGES; ФИЛИППИНИЙ МАНИЛАГИЙН АРИУН СҮМД ОРСОН ГЭР БҮЛИЙН ЗУРГИЙГ ДАНИЛО СОЛЭТА

Филиппиний залуучууд сайн мэдээний зарчмууд дээр бүтээх үйлсдээ амжилт олохын зэрэгцээ Их Эзэний сүмийн идэвх зүтгэлтэй удирдагчид болж байна.

гарсан үед сайн мэдээг номлож байсан ч баптисм хийгдсэнгүй.

Дэлхийн II дайны үеэр нэлээд хэдэн хожмын үеийн гэгээнтэн Филиппиний арлуудыг дайснаас чөлөөлсөн Холбоотны цэргүүдтэй хамт тулалдсан ажээ. 1944, 1945 онуудад цэргийн бүлэглэлүүд олон газарт сүмийн цуглаануудыг явуулж байсан бөгөөд ХҮГ цэргийн албан хаагч олон гишүүн, дэмжлэг үзүүлэгч бусад хүмүүс дайн дуусаны дараа Филиппинд байсаар байлаа. Тэдний дунд Максин Тэйт болон сүмд нэгдээд удаагүй Жэром Хоровиц нар байв. Тэр хоёр хоёулаа Анисэта Фахардог сайн мэдээтэй танилцуулахад тусалсан ажээ. Хоровиц ах Манилын бөмбөгдүүлж сүйрсэн хэсэгт Анисэтагийн байшинг дахин барихад тусалж байхдаа шинэхэн олж авсан итгэлээ Анисэта, түүний охин Рүт хоёртой хуваалцжээ.

Анисэта гэрчлэлтэй болж, баптисм хүртэхийг хүсч байсан ч тэр үед Филиппиний арлууд дээр байнгын үйл ажиллагаа явуулдаг сүмийн нэгж байгаагүй учраас филиппинчүүдэд баптисм хүртээх эрх мэдлийг сүм олгоогүй байв. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Харолд Б.Лий (1899–1973) Анисэтагийн хүслийг мэдээд Цэргийн албан хаагчдын ерөнхий хорооны даргын эрх мэдлээрээ Анисэтад баптисм хүртээх зөвшөөрөл өгчээ. Анисэта Фахардод 1946 оны Улаан өндөгний баярын өглөө цэргийн албан хаагч гишүүн Лорэн Фэрре баптисм хүртээж, тэрээр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн анхны филиппин гишүүн болжээ.

Номлолын ажил эхэлсэн нь

Дайны дараа сүмийн бүлгүүд АНУ-ын цэргийн хоёр бааз—Кларкийн Агаарын цэргийн болон Сүбийн булангийн тэнгисийн цэргийн баазад зохион байгуулагдаж, хожмын үеийн гэгээнтэн цэргийн албан хаагч гишүүд Филиппинд сүм албан ёсоор байгуулагдахыг хүсэн хүлээх болов. 1955 оны 8-р сарын 21-нд ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972) Филиппинийг сайн мэдээг номлоход зориулан адисалжээ. Гэвч хуулийн хязгаарлалтаар номлогчид ирэхийг 1961 он хүртэл хойшлуулсан байна.

1960 онд, тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын туслах байсан ахлагч Гордон Б.Хинкли (1910–2008) Филиппинд хэд хоногийн хугацаагаар айлчлахдаа: “Би номлолын ажил . . . дэлхийн олон хэсэгт ямар байгаа шигээ тийм үр өгөөжтэй байх болно гэсэн бодлоо илэрхийлсэн” гэж хэлжээ.[3] Дараа жил нь Максин Тэйт Гримм зэрэг гишүүд мөн Саудерн Фар Ийст номлолын ерөнхийлөгч Робэрт С.Тэйлор болон сүмийн гишүүн биш найз нөхөд нь маш их бэлтгэл, бичиг цаасны ажил хийсний эцэст ахлагч Хинкли номлолын ажлыг эхлүүлэхийн төлөө Филиппинийг дахин адислахаар тус оронд эргэж ирэв.

1961 оны 4-р сарын 28-нд ахлагч Хинкли Манила хотын захын дүүрэгт цэргийн албан хаагч гишүүдийн жижигхэн бүлэгтэй мөн америк оршин суугчидтай болон филиппин гишүүн Дэвид Лагмантай уулзаж, онцгой залбирал хэлжээ. Уг залбиралдаа тэрээр “энэхүү захиасыг хүлээн авч, үүгээр адислагдах гишүүд олон мянгаараа байх болно” гэж хэлсэн юм.[4] Их Эзэний үнэн үйлчлэгчийн хэлсэн эдгээр үгс удалгүй бошиглолын үгс болсон билээ.

Үүнээс хойш хэдэн долоо хоногийн дараа анхны дөрвөн номлогч—Рэймонд Л.Гүдсон, Харри Л.Мүррэй, Кэнт К.Лаув, Нэстэр О.Лэдэсма нар Манилад ирэв. “Филиппинчүүд сайн мэдээг дуртайяа хүлээн авч байв. Маш олон тохиолдолд гэр бүлийн тэргүүн нь сүмд нэгдэхээр шийдэхэд гэр бүл нь бүгдээрээ сүмд элсдэг байлаа”[5] хэмээн ахлагч Лаув ярилаа.

Сүм өсч хөгжиж байна

Их Эзэний ажил 1967 онд Филиппиний номлол зохион байгуулагдах хэмжээнд хүртэл өсч хөгжсөн ажээ. Тэр жилийн эцэс гэхэд уг номлол 3193 гишүүнтэй болсноос 631 нь тэр онд хөрвөсөн байлаа. 1973 он гэхэд Филиппин дэх сүм бараг 13000 гишүүнтэй болж өргөжсөн байна. 1973 оны 5-р сарын 20-нд Филиппиний

Манилагийн гадас зохион байгуулагдаж, Аугусто А.Лим ерөнхийлөгч нь болжээ. 1974 онд Филиппиний Манила номлол ба Филиппиний Сэбү хотын номлол гэсэн Филиппиний хоёр номлол болон хуваагдав.

1975 оны 8-р сард ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) Филиппиний анхны бүсийн чуулганыг тэргүүлэхээр Манилад иржээ. Наймдугаар сар шуургатай байсан учраас Манилад гаднаас ирэгчдийн хувьд их хүндрэлтэй байлаа. Лаоаг хотоос сууж явсан гэгээнтнүүдийн автобус шаварт суухад гэгээнтнүүд автобусыг шавраас түрж гаргаад жолоочоос буцаж явахгүй байхыг гуйж байжээ. Нэгэн эгчийн хэлснээр, гэгээнтнүүдийн өөр нэг бүлэг Бурханы амьд бошиглогчийг харж, үгийг нь сонсохын тулд шуургатай далайгаар гурав хоног аялахаар зориглосон гэнэ.

рүү харсан, сүмийн олон гишүүний хувьд харьцангуй ойрхон байлаа. Хүсэлтийг зөвшөөрч, уг газрыг 1981 оны 1-р сард худалдан авав. Гудамжны нэрийг сүмийн хүсэлтээр Ариун сүмийн гудамж болгож өөрчилсөн ажээ.

1982 оны 8-р сарын 25-нд болсон газар хөндөх ёслолд сүмийн 2000 орчим гишүүн болзошгүй далайн хар салхины аюулыг эс хайхран, Филиппиний арлуудаас усан онгоц, галт тэрэг, автобусаар иржээ. Ариун сүмийн барилга удалгүй эхэлж, 1984 оны наймдугаар сард адислагдахад бэлэн болсон байлаа.

Бараг 27000 гишүүн болон гишүүн бус хүмүүс ариун сүмийг адислахаас өмнө ирж үзсэн байна. Тэд ариун сүмийг адислахаас хэдхэн хоногийн өмнө Филиппинийг бүхэлд нь 48 цагийн турш дайрч

ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДЛУУДЫН ОН ДАРААЛАЛ

1898 он: Хожмын үеийн гэгээнтэн цэргийн хоёр албан хаагч Испани-Америкийн дайны үед сайн мэдээг номлож байв

1944–45 он: Хожмын үеийн гэгээнтэн цэргийн олон албан хаагч Дэлхийн II дайны үед номлож байв

1946 он: Анисэта Фахардо баптисм хүртэж, сүмийн гишүүнээр батлагдсан анхны филиппин хүн болов

1955 он: Ерөнхийлөгч Жозэф Фийлдинг Смит сайн мэдээг номлохын төлөө Филиппинийг адислав

Ерөнхийлөгч Кимбалл 1980 онд өөр нэг бүсийн чуулганыг тэргүүлэхээр Филиппинд дахин очихдоо Филиппиний ерөнхийлөгч Фердинанд Маркостой товчхон уулзалт хийсэн ажээ. Энэхүү уулзалт Филиппинд 1983 онд номлогчийг бэлтгэх төвийг нээх болон дараа жил нь Филиппиний Манилын ариун сүмийг адислах замыг тавьсан юм. 1987 онд Филиппиний Микронезийн бүс Манилад төвтэйгөөр үндэслэн байгуулагдав.

Мормоны Номын зарим хэсгүүд 1987 онд тагалог хэлэнд орчуулагджээ. Эдүгээ Мормоны Ном Филиппиний нэлээд хэлээр, түүний дотор сэбү хэлэнд орчуулагдаад байна.

Ариун сүмийн адислалууд

1980 оны 12-р сард ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл Сүмийн үл хөдлөх хөрөнгийн газрын захирлыг ариун сүм барихад тохиромжтой газар олуулахаар Манила руу явуулжээ. Захирал нэлээд хэдэн газрыг үзсэний эцэст Квиезон хотод 1.4 га газар худалдаж авах хүсэлт тавьсан ажээ. Энэ газар Марикинагийн хөндий

өнгөрсөн далайн хоёр хар салхийг эс хайхран, ариун сүмийг үзэхээр ирсэн ажээ. Алслагдсан мужуудаас ирсэн гэгээнтнүүд ядарсан ч, цовоо сэргэлэн байлаа. Голууд эргээ халин үерлэж, зам харгуй усанд автагдан, гүүрүүд эвдэрсэн учраас олон тохиолдолд тэд Манил руу тойруу замаар удаан аялахаас аргагүй болж байв.

Ариун сүмийн үзэсгэлэнт сайхан байдал зочдод түүний дотор нэрд гарсан олон филиппин хүнд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн ажээ. Зохиолч Сэлсо Карунанган "ариун мэдрэмж төрлөө, хэрэв танд ийм мэдрэмж төрвөл та Бүтээгчтэйгээ нүүр тулан учрах нь тэр" хэмээн хэлэв. Филиппиний Цагдаагийн газрын ерөнхий захирал хурандаа Биенвенидо Кастилло: ариун сүм бол "тэнгэрлэг зүйлсийн тухай бясалган бодох газар юм, яагаад гэвэл та ийм орчинд байдаг" гэж ярив. Хоёр гэлэнмаа ариун сүмийг "үнэхээр Их Эзэний өргөө" болохыг мэдэрсэн гэнэ. Филиппиний парламентын гишүүн Эва Эстрада Калав "Би та нарыг манай оронд улам олон ариун сүм бариасай гэж хүсч байна" гэж хөтөч нарт хэлжээ.[6]

ЦЭРГҮҮДИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ISTOCKPHOTO/THINKSTOCK

Тэр үед Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх байсан ерөнхийлөгч Хинкли 1984 оны 9-р сарын 25-ны мягмар гарагт ариун сүмийн барилгыг дуусгах булангийн чулуу тавих цуглааныг удирджээ. Ариун сүмийг адислах есөн хуралдаан селестиел өрөөнд болов. Номхон далайн бүсийн 16 гадас, 22 дүүргээс 6500 орчим гэгээнтэн хуралдаануудад оролцсон байна.

Ариун сүмийг адислах хуралдаан дуусмагц Бага Пауло В.Малит, Эдна А.Ясона хоёр1984 оны 9-р сарын 27-нд Филиппиний Манилагийн ариун сүмд гэрлэсэн анхны хос болсон юм. Ариун сүмийн анхны ерөнхийлөгч В. Гарт Эндрюс гэрлэх ёслолыг гүйцэтгэжээ.

Ёслолын ажилтнуудаас эхлэн сүмийн олон арван гишүүн хувийн хишгээ хүлээн авахын тулд дугаарлан зогсож байлаа. Ариун сүмийн ажил дараагийн өдөр хүртэл шөнөжингөө үргэлжилсэн ажээ.

Гишүүд ариун сүмд орохыг улам их хүсдэг болжээ. Манилагаас хол амьдардаг гишүүд усан онгоцоор эсвэл автобусаар аялахын тулд их золиослол хийх шаардлагатай болдог байв. Гэвч тэд ариун сүмд ирсэн хэвээр байсан ба иттэл бишрэл, шийдвэр төгс байдлын түүхтэйгээр буцдаг байжээ.

Жэнэрэл Сантосын Бэрнардо Обэдоза, Леонидес Обэдоза хоёрын хувьд алс холын Манила дахь ариун сүм рүү явах нь боломжгүй юм шиг санагдаж байжээ. Гэхдээ их үнэтэй ганц ширхэг сувд худалдаж авахын тулд өөрт байсан бүхнээ зарсан худалдаачин шиг (Матай 13:45–46-г үзнэ үү) энэ хос хоорондоо болон хүүхдүүдтэйгээ мөнхийн гэр бүл болж лацдан холбуулахын төлөө ариун сүм явах зардлаа төлөх гэж байшингаа зарахаар шийдсэн ажээ. Тэд байшингаа болон эд хогшлынхоо ихэнхийг зарсны дараа есөн хүнтэй гэр бүлийнхээ Манила хүртэлх усан онгоцоор аялах зардалтай болж чадсан гэнэ. Харин Леонидес эргэж ирээд орох оронгүй яах билээ гэж санаа нь зовоход Их Эзэн орон гэрээр хангах болно хэмээн Бэрнардо эхнэртээ итгүүлжээ. 1985 онд тэд ариун сүмд энэ амьдралд болон үүрд мөнхөд гэр бүлээрээ лацдан богдов Тэд хийсэн золиослол бүрийнхээ

1961 он: Филиппинд номлолын ажил албан ёсоор нээгдэж, анхны дөрвөн номлогч ирэв

1967 он: Филиппиний Номлол зохион байгуулагдав

1973 он: Филиппиний Манила гадас үүсэн байгуулагдав

1974 он: Филиппиний номлол хуваагдаж, Филиппиний Манилагийн болон Филиппиний Сэбу хотын номлолууд бий болов

1975 он: Манилад бүсийн анхны чуулган болов

1983 он: Манилад Номлогчийг бэлтгэх төв нээгдэв

Онцгой байдалд бэлтгэлтэй байх талаарх Халамжийн Нийгэмлэгийн хурал байгалийн гамшигт өртөмтгий нутагт амьдардаг эмэгтэйчүүдийг үнэ цэнэтэй мэдээллээр хангажээ.

ачаар ариун сүмээс асар их үнэт сувдаа олсон учраас тэдний баяр баясгаланг юутай ч зүйрлүүлэх аргагүй байлаа. Мөн Бэрнардогийн үгс биелж, Их Эзэн тэднийг орон байраар хангасан юм. Тэднийг Манилагаас эргэж ирэхэд сайхан сэтгэлт танилууд нь тэдэнд толгой хоргодох байр гаргаж өгчээ. Яваандаа хүүхдүүд нь сургуулиа төгсөх үед тэд өөрийн гэсэн орон байртай болж, шинэ газарт шилжжээ.

2006 оны 4-р сарын 18-нд Тэргүүн Зөвлөл Филиппиний Сэбү хотод ариун сүм барихаар зарлав. Энэ мэдээг сонсоод сүмийн олон гишүүн баярласандаа нулимс дуслуулж байлаа. “Их Эзэн Сэбү хотыг дараагийн ариун сүм барих газраар сонгосон учраас бид адислагдсан юм” гэж Сэбү хотын шашны институтийн захирал Бага Цэзар Пэрэз хэлэв.

ФИЛИППИН ДЭХ СҮМИЙН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ӨСӨЛТ

Сүмийн бүх гишүүнчлэл: 675166*

Тойрог, салбарууд: 1134

Номлол: 17

Ариун сүм: 2 (дахиад нэг ариун сүм баригдаж байгаа)

Гэр бүлийн түүхийн төв: 167

** 2013 оны 9-р сарын байдлаар*

1984 он: Филиппиний Манилагийн ариун сүм адислагдав

1987 он: Манилад төвтэй Филиппиний Микронезия бүс байгуулагдав

1987 он: Мормоны Номын зарим хэсэг тагалог хэлэнд орчуулагдав

2010 он: Филиппиний Сэбү хотын ариун сүм адислагдав

Сэбү хотын ариун сүмийг адисалснаас хойш хэдхэн сарын дараа Филиппиний хожмын үеийн гэгээнтнүүд дахин нэг баярт мэдээ сонсов. 2010 оны 10-р сарын 2-нд ерөнхийлөгч Томас С.Монсон Ерөнхий чуулганыг нээж үг хэлэх үеэрээ Пангасинанд Филиппиний Урданэта ариун сүмийг барихаар зарласан билээ.

Цаашид илүү агуу зүйлүүд ирэх болно

Филиппин дэх Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бусад орнуудынхтай харьцуулахад шинэ ч гэсэн, арлын энэ орон дахь сүмийн хувь тавилан агуу юм. Сүм гайхамшигтай өсч хөгжиж байна. Цаашид илүү агуу зүйлүүд ирэх болно. Ерөнхий эрх мэдэлтнээр үйлчлэхээр дуудагдсан хоёр дахь филиппин хүн болох ахлагч Майкл Жон Ю. Тэ “Их Эзэний ажил бидний тусламжтайгаар эсвэл бидний тусламжгүйгээр ч урагш ахих учраас бид [Филиппиний хожмын үеийн гэгээнтнүүд] өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд өмнө нь хэзээ ч байгаагүй ихээр бэлтгэх хэрэгтэй байна” гэж хэлжээ.[7]

Тийм ээ, 21-р зуун зогсолтгүй урагшилсаар байна. Улам олон филиппин хүн сэргээгдсэн сүмийн захиасыг хүлээн авч, далайн арлууд дээрх энэхүү онцгой сайхан хүмүүст адислал болж байгаа учраас энэ сүм хэмжээний хувьд ч, нөлөөллөөрөө ч өсөх болно. Ахлагч Тэ болон Филиппиний гэгээнтнүүдийн хувьд “Их Эзэний амлалтууд далайн арлууд дээрх тэдэнд агуу их. . .” (2 Нифай 10:21) болох нь эдүгээ биелэгдэж байна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Аугусто А.Лим, Р. Ланиер Бриц, “‘Faithful, Good, Virtuous, True’: Pioneers in the Philippines,” *Ensign,* 1997 оны 8-р сар, 60; *Лиахона,* 1998 оны 2-р сар, 44.
2. Аугусто Лим, Gelene Tobias, “Augusto Lim: The Man of Many Firsts,” countrywebsites.lds.org/ph/index.php/dateline-philippines/jubilee-2011.
3. Шэри Л.Дью, *Go Forward with Faith: The Biography of Gordon B.Hinckley* (1996), 213–15-р хуудсыг үзнэ үү.
4. Гордон Б.Хинкли, “Commencement of Missionary Work in the Philippines,” *Tambuli,* 1991 оны 4-р сар, 18.
5. Кэнт Клайдтай хийсэн Жэймс Нийл Кларкийн ярилцлага, 2007 оны 9-р сарын 3.
6. Францис М.Орквиола, “Temple Dedication Rewards Faith of Filipino Saints,” *Ensign,* 1984 оны 11-р сар, 107.
7. Майкл Жон Ю.Тэ, “Scriptures and Spiritual Preparation” [Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн захиас, 2011 оны 5-р сар]; lds.org.ph/index.php/literature.

МӨНХ БУС БАЙДЛЫН ӨМНӨХ АМЬДРАЛ

БҮТЭЭЛТ

ХӨШИГ

МӨНХ БУС БАЙДАЛ

Асуултуудад хариулахын тулд

АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ашиглах нь

Ларин Портэр Гаунт

Сүмийн сэтгүүлүүд

Бид сэтгэл догдлом цаг үед аж төрж байна. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ "тодорхой бус байдлаас" (С ба Г 1:30) гарч ирлээ. Үүний ачаар манай сүмийн гишүүн биш, Тэнгэрлэг Эцэгийн илүү олон хүүхэд "мормончуудын" тухай сонсож байна. Тэдний зарим нь хачирхалтай, төөрөлдөж мэдэх зүйлсийг сонсож байгаа бол бусад нь танил бөгөөд тайтгарлыг мэдрүүлдэг зүйлсийг сонсож байна. Энэ хоёр бүлгийн хүмүүс аль аль нь асуултуудынхаа хариултыг олохын тулд бидэн дээр ирж болно. Олон хариултыг "аз жаргалын агуу төлөвлөгөө" (Алма 42:8) хэмээн нэрлэгддэг авралын төлөвлөгөөнөөс олж болно.

"Би хаанаас ирсэн бэ?" "Яагаад би энэ дэлхий дээр байгаа вэ?" "Би энэ амьдралын дараа хаашаа явах вэ?" гэсэн асуултууд бол хүмүүс хамгийн их асуудаг асуулт юм. Эдгээр бүх асуултуудад авралын төлөвлөгөөн дэх үнэнүүдээр хариулж болно. Энэ өгүүлэл эдгээр асуултуудад судруудаас болон бидний бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсоны өгсөн хариултуудын заримаас хуваалцаж байна.

Есүс Христэд итгэх итгэл

Наманчлал

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РОБЭРТ АДАМСОН

Би хаанаас ирсэн бэ?

Бид бол мөнхийн хүмүүс. Энэ амьдралаас өмнө бид Бурханы сүнсэн хүүхдүүдийн хувьд Түүнтэй хамт амьдарч байсан. “Төлөөлөгч Паул ‘бид Бурханы үр удам’ [Үйлс 17:29]” хэмээн [заасан] бол, ерөнхийлөгч Монсон “бидний бие мөнх бус эцэг эхийн маань үр удам гэдгийг мэддэг болохоор Паулын үгс ямар учиртайг судалж мэдэх ёстой. Их Эзэн ‘сүнс хийгээд мөн бие нь хүмүүний бодгаль бөлгөө’ [С ба Г 88:15] хэмээн тунхагласан юм’ хэмээн хэлжээ. Тийнхүү энэ нь Бурханы үр удам болох сүнс юм. Еврей номыг бичигч Түүнийг ‘сүнснүүдийн Эцэг’ [Еврей 12:9]” гэж нэрлэсэн байдаг.[1]

Яагаад би энэ дэлхий дээр байгаа вэ?

Дэлхий дээрх бидний амьдралын тухай ерөнхийлөгч Монсон хэлэхдээ “Мэргэн ухаант Бүтээгч дэлхийг бүтээж, түүн дээр биднийг байрлуулан, өмнөх оршихуйн тухай марталтын хөшгийг бидэнд бий болгож, сорилтын хугацааг туулан, Бурханаас бидэнд зориулан бэлтгэсэн бүхнийг хүлээн авахад тэнцэхээр байж, өөрсдийгөө нотлон харуулах боломжийг бидэнд олгосонд бид баярлан талархах ёстой.

“Дэлхий дээр ирэх бидний үндсэн зорилго бол яс, махан биетэй болох явдал гэдэг нь тодорхой юм. Бидэнд бас сонгох эрхийн бэлэг өгөгдсөн билээ. Өөрийнхөө төлөө үй түмэн арга замаар сонгох онцгой боломж бидэнд бий. Энд бид хувийн адармаатай туршлагуудаас суралцаж, сайныг муугаас ялган таньдаг. Бид хорон муу зүйлийг сайн сайхан зүйлээс ялган таньж, бидний үйлдлүүд ямар үр дагаварт хүргэдгийг мэддэг болно” гэжээ.[2]

Би энэ амьдралын дараа хаашаа явах вэ?

Хүмүүний гэр бүлийн бүх гишүүдэд үхэл ирдэг. Харин “хэрэв хүн үхвэл тэрээр амилах уу?” (Иов 14:14). Ерөнхийлөгч Монсон: “Үхэл бол төгсгөл биш гэдгийг бид мэднэ. Энэхүү үнэнийг амьд бошиглогчид бүх эрин зуунуудын туршид заасаар ирсэн юм. Энэ нь бас ариун судруудад бичигдсэн юм. Бид Мормоны Номоос дараах онцгой тайтгаруулагч үгсийг уншдаг билээ:

Бидэнд эсвэл бусад хүмүүст Есүс Христийн сайн мэдээний тухай асуулт байгаа үед хариултаа хаанаас олохыг бид мэддэг үү?

Эцсээ хүртэл тэвчих

Баптисм

Ариун Сүнсний бэлэг

БИ АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР ХААНААС ИЛҮҮ ИХИЙГ СУРЧ БОЛОХ ВЭ?

1. Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд зэрэг судруудад авралын төлөвлөгөөний тухай илүү тодорхой заасан байдаг.
2. Амьд бошиглогчдын үгс conference.lds.org-д байгаа. Та авралын төлөвлөгөө, аз жаргалын төлөвлөгөө, Цагаатгал, өргөмжлөл, шударга ёс ба нигүүлсэл, наманчлал ба амилуулалт гэх мэт үг хэллэгүүдийг судалж болно.
3. "2 дугаар хичээл: Авралын төлөвлөгөө" *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж* гарын авлагын 3-р бүлгийг үзнэ үү.

'Эдүгээ, үхэл хийгээд амилуулалтын хоорондох сүнсний байдлын талаар—Болгоогтун, бүх хүмүүний сүнс энэ зуурдын биеийг орхимогцоо, тийм ээ, бүх хүмүүний сүнс, сайн эсвэл муу байлаа ч өөрсдөд нь амьдралыг өгсөн Бурханд, гэртээ аваачигддаг нь надад нэгэн тэнгэр элчээр мэдүүлэгдсэн билээ.

'Мөнхүү тэгээд улиран тохиох дор, зөв шударга тэдний сүнс тэд өөрсдийн бүх бэрхшээлүүд мөн санаа зоволт хийгээд харамслаасаа амрах диваажин гэж нэрлэгдсэн аз жаргалын байдал, амар амгалангийн байдал, энхийн байдалд хүлээн авагдах болно' [Алма 40:11–12]."[3]

Бид амилуулагдсаныхаа дараа нар лугаа адил алдар суутай селестиел хаант улс, сар лугаа адил алдар суутай террестриел хаант улс, одод лугаа адил алдар суутай телестиел хаант улсын аль нэгэнд эсвэл гадаад харанхуй руу очно (С ба Г 76-р хэсгийг үзнэ үү).

Бурхан үнэхээр байдаг уу? Сатан бодитой юу?

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон Сатан бүгдээрээ биднийг төрөхөөс өмнө тэнгэрт болсон их зөвлөгөөнд оролцсон юм. Тэнгэрлэг Эцэг авралын төлөвлөгөөний хэсэг болж, дэлхийд очин, бидний нүглийг цагаатгах нэг хүн хэрэгтэй байгааг хэлээд "Хэнийг илгээх вэ, би? гэхэд мөн Хүний Хүүтэй адил нэгэн [Есүс Христ] хариулав: Би энд байна, намайг илгээгтүн. Мөн өөр нэг нь [Сатан] хариулж мөн хэлэв: Би энд байна, намайг илгээгтүн. Мөн Их Эзэн хэлэв: Эхнийхийг би илгээх болно.

"Мөн хоёр дахь нь [Сатан] ууртай байв, мөн өөрийн анхны байдлыг хадгалсан нь үгүй мөн тэр өдөр олон нь түүний араас дагав" (Абрахам 3:27–28; мөн С ба Г 29:36–37; Мосе 4:1–4-ийг үзнэ үү).

Сатаны уруу таталтуудыг эсэргүүцэх хүч бидэнд байдаг уу?

Тэнгэрт болсон зөвлөгөөний дараа Сатаныг дагахаар сонгосон сүнснүүдийн гуравны нэг нь түүнтэй хамт тэнгэрээс хөөгдсөн билээ. Тэд болон Сатан биегүй сүнснүүд хэвээр үлдсэн юм. "Бие махбодтой бүх хүмүүс бие махбодгүй тэднийг захирах хүчтэй байдаг"[4] хэмээн бошиглогч Иосеф Смит сургажээ. Тиймээс Сатан биднийг уруу татаж чадах ч, түүнийг эсэргүүцэх хүч бидэнд байдаг.



АМИЛУУЛАЛТ

ЕҮЛҮЛТ

Тэнгэрлэг Эцэг яагаад зарим үед залбиралд маань хариулахгүй байгаа юм шиг санагддаг юм бол?

"Залбирал бол Эцэгийн таалал, хүүхдийн хүсэл хоёр хоорондоо уялдан, нэгддэг үйл явц мөн. Залбирлын зорилго нь Бурханы тааллыг өөрчлөх явдал биш" (Bible Dictionary, "Prayer"). Залбирал бол бид өөрсдийн хүслийг Бурханы таалалд нийцүүлэхийн тулд сонгох эрхээ ашиглахаар шийдэхэд бидэнд тусалдаг арга хэрэгсэл юм (Абрахам 3:25-ыг үзнэ үү). Тэнгэрлэг Эцэг бидний залбиралд үргэлж хариулдаг ч хариулт нь зөвшөөрсөн, татгалзсан эсвэл цаг нь хараахан болоогүй гэсэн хэлбэрээр ирдэг. Үүнд хугацаа чухал юм.

Намайг сайхан амьдрах гэж хичээх үед яагаад сорилтууд тулгарах хэрэгтэй байдаг вэ?

Сорилтууд бол авралын төлөвлөгөөний хэсэг юм. Биднийг Есүс Христ болон Түүний сайн мэдээнд тулгуурлах үед сорилтууд биднийг хүчирхэг болгож, цэвэршүүлэн, төгөлдөржүүлдэг. Тэнгэрлэг Эцэг сорилт бэрхшээлийн үед биднийг өргөн дэмждэг. Бидэнд тулгарсан хүнд сорилтууд "[бидэнд] туршлага суулгаж, мөн [бидний] сайн сайхны төлөө байх болно" (С ба Г 122:7).

Юу нь зөв, юу нь бурууг би яаж мэдэх вэ?

Бурханы бүх хүүхдүүд Христийн гэрэлтэй төрдөг бөгөөд энэ гэрэл нь "сайныг хилэнцтээс ялган мэдэж болохын тулд" бидэнд тусалдаг (Моронай 7:16). Түүнээс гадна Ариун Сүнс амар амгалангийн халуун мэдрэмжээр үнэнийг бидний зүрх сэтгэл, оюун ухаанд гэрчилдэг билээ (С ба Г 8:2–3-ыг үзнэ үү).

Би ноцтой нүглүүд үйлдсэн ч гэсэн уучлагдах уу?

Бид бүгдийг зөвийг буруугаас ялган таньж, сонголт хийх явцдаа нүгэл үйлдэх болно гэдгийг Бурхан мэддэг байсан юм.[5] Гэвч бүх нүгэл араасаа шийтгэлийг дагуулдаг бөгөөд шударга ёс нь энэхүү шийтгэлийг шаарддаг. Тэнгэрлэг Эцэг Өөрийн нигүүлслээр Есүс Христэд Цагаатгалыг гүйцэтгэж, бид бүгдийн төлөө шударга ёсны шаардлагуудыг биелүүлэх боломжийг олгосон билээ (Алма 42-р бүлгийг үзнэ үү). Өөрөөр хэлбэл, Христ Гетсеманид зовон шаналж, Голгота дээр амиа өгснөөр бидний бүх нүглийн төлөөсийг төлсөн юм. Гэхдээ бид наманчлан, сайн мэдээний ёслолуудыг хүлээн авч, Христийн Цагаатгалыг ашигласан тохиолдолд энэ нь боломжтой болно. Бидний нүгэл өршөөгдөх болно (С ба Г 1:31–32-ыг үзнэ үү). ■

ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, "Амьдралын ураалдаан," *Лиахона,* 2012 оны 5-р сар, 91; мөн Абрахам 3:22–26-г үзнэ үү.
2. Томас С.Монсон, "Амьдралын ураалдаан," 91–92; мөн Алма 34:32–34-ийг үзнэ үү.
3. Томас С.Монсон, "Амьдралын ураалдаан," 93; мөн Сургаал ба Гэрээ 76:59–111-ийг үзнэ үү.
4. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 211.
5. Бага насны хүүхдүүд "хариуцлага хүлээж эхлэх хүртлээ" нүгэл үйлдэж чаддагүй (С ба Г 29:46–47-г үзнэ үү).

ТЭД ҮҮНИЙГ ЯАЖ МЭДСЭН ЮМ БОЛ?

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын 2011 оны Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий хуралдааны үеэр Халамжийн Нийгэмлэгийн эгч нарт өгсөн захиас миний зүрх сэтгэлд гүнзгий нөлөөлж, амар амгаланг өгсөн юм. Тэрээр намайг-бүү-март гэдэг нэртэй нэгэн жижигхэн цэцгийн тухай, түүний таван дэлбээ бидний үргэлж санаж явах ёстой таван зүйлийг хэрхэн төлөөлдөг тухай өгүүлсэн билээ.[1]

Цуглааны дараа манай охин Алисса бэлэн хоолоор үйлчилдэг жижигхэн бизнес эрхэлдэг найз Жэссигийнхээ тухай нэгэн түүхийг надад ярьсан юм. Гадасны Халамжийн Нийгэмлэгийн удирдагчид Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий хуралдааны дараа эгч нарт өгөх амтат зууш хийж өгөөч гэж Жэссигээс хүссэн ажээ. Жэсси 250 аяга бялуу хийх хэрэгтэйгээ тэр даруй мэдсэн гэж Алиссад ярьсан байна. Алисса бялуунуудыг гадасны төв дээр хүргэж өгөхөд сайн дурааараа туслахаар болжээ.

Цуглааны өдөр болж, Алисса туслахаар хүрч иртэл Жэсси уйлах шахан зогсож байв. Бялуу бэлэн болж, Жэсси зургийг нь нэг хамаатандаа илгээтэл тэрээр энэ бялуу чинь хуралдаанд зориулан үйлчлэхээр тийм сайхан болоогүй байна гэжээ.

Жэсси өөртөө эргэлзэж эхэллээ. Халамжийн Нийгэмлэгийн удирдагчид түүнийг ийм энгийн бялуунаас арай илүү тансаг зууш хийнэ гэж хүссэн байх ёстой гэж тэр бодсон гэнэ. Тэр бялуугаа тансаг болгож чимэх аргыг олох гэж сандарч байсан ч цаг даанч бага байлаа. Алисса тэр хоёр бялуугаа авчирсан бөгөөд Жэсси ерөнхийлөгч Угдорфыг үгээ хэлэх хүртэл Халамжийн Нийгэмлэгийн эгч нарын сэтгэлийг гонсойлголоо гэж бодож байжээ.

Ерөнхийлөгч Угдорф намайг-бүү-март гэдэг нэртэй нэгэн жижигхэн цэцэгний тухай ярьж байтал дэлгэцэн дээр бяцхан цэнхэр цэцэгний зураг гарч ирэв. Энэ бол энгийн атлаа маш гоё дэлбээтэй үзэсгэлэнт сайхан цэцэг байв. Түүний захиас хүн бүрийн зүрх сэтгэлийг догдлуулсан ба тэрээр бид эргэн тойрондоо байдаг чимэглэлийн том том хиймэл цэцгүүдэд сатаарах биш харин өөрийн заасан энгийн атлаа чухал таван үнэнийг мартахгүй байхыг бидэнд захиж билээ.

Хаалтын залбирлын дараа эгч нар соёлын танхимд орж ирлээ. Алисса, Жэсси хоёрыг орж ирэхэд амтат зууш өрсөн ширээг тойрон зогссон хүмүүс "Тэд үүнийг яаж мэдсэн юм бол оо?" хэмээн асуухыг харжээ.

Бялуу бүрийг царцмаг чихрээр таван дэлбээтэй, энгийн атлаа сэтгэл догдлом гоёор, намайг-бүү-март гэдэг танан цагаан цэцэг гарган чимсэн байлаа. ■

АНУ, Аризона, Гэйл Ашкрофт

Бялуу бэлэн болж, Жэсси зургийг нь нэг хамаатандаа илгээтэл тэрээр энэ бялуу чинь хуралдаанд зориулан үйлчлэхээр тийм сайхан болоогүй байна гэжээ.

ЭШЛЭЛҮҮД

1. Дийтр Ф.Угдорф, "Намайг бүү март," *Лиахона,* 2011 оны 11-р сар, 120.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРЭДЛИ КЛАРК

НАДАД НАЙДВАР ТӨРҮҮЛСЭН АМЛАЛТ

Нөхөр, бид хоёр гэрлэснээсээ хойш удалгүй үрийн зулай үнэрлэж, хүүгээр адислагдсан. Би хүүгийнхээ инээмсэглэхийг харж, нүд рүү нь ширтэхдээ Тэнгэрлэг Эцэгт өртэй болсноо мэдэрч билээ. Манай хүү өөгүй төгс юм шиг санагддаг байв. Нөхөр, бид хоёр энэхүү үнэлж баршгүй бэлгийн төлөө Их Эзэнд өдөр бүр талархдаг байлаа.

2009 оны 2-р сарын 19-нд сургуулиа төгсөх сүүлчийн жил сургуульдаа эргэж очихоор бэлтгэлээ. Гэтэл маргааш нь хайртай хүү минь хумхаа өвчин тусч, хорвоог орхин одохыг бид хоёр яахин мэдэх билээ дээ.

Энэ нь миний хувьд үнэхээр дааж давшгүй хэцүү зүйл байлаа. Манай тойргийн гишүүд биднийг тайтгаруулахаар судрууд авчирч, дуулууд дуулан, бидэнтэй хамт залбирдаг байв. Тэдний тайтгарлын үгс болон үйлдлүүд миний сэтгэлийн зовлонг нимгэлж байсан ч хүүгээ алдсаны төлөөх уй гашуу надаас сүүдэр мэт салахгүй байлаа. Хүүгийнхээ тухай бодох бүр нулимс аяндаа асгарч байв.

Би хүүгээ алдсанаас хойш дөрөв хоногийн дараа *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* номыг судлахаар сүнслэгээр өдөөгдөв. Тэгээд уг номыг гартаа барьж байтал "Нас барах үе дэх найдвар, тайтгарлын үгс" бүлэг аяндаа нээгдэх нь тэр. Би тэр бүлгийг уншиж эхлэхэд Иосеф, Эмма хоёр гэрлэснээсээ хойш халуун ам бүлээсээ өдий олон хүнийг алдсан нь надад гүнзгий нөлөөлөв. Хоёр настай бяцхан охины оршуулга дээр бошиглогчийн хэлсэн үгийн хэсгээс унших үед би зүрх шимшрэм уй гашуугаасаа тайтгарч, хүйтэн усаар толгойгоо шавших шиг болж, дотор минь уужирч билээ.

Би нөхрөө дуудаад дараах хэсгийг хамт уншлаа: "Яагаад эдгээр гэм зэмгүй балчирхан үрсийг . . . биднээс салган авдаг юм бол? гэсэн асуултыг би асуулаа. . . . Их Эзэн олон хүнийг, бүр нялх балчраар нь . . . өнөөгийн энэ дэлхийн гай зовлон, нүгэл хилэнцээс холдуулахын тулд өөртөө авч байна. Тэд дэлхий дээр амьдрахад хэтэрхий цэвэр, энхрий хонгорхон ажээ. Тиймээс зөвөөр тунгаан бодох аваас, тэд хилэнцээс чөлөөлөгдөж байгаа болохоор гашуудахын оронд баярлах шалтгаан бидэнд буй. Учир нь бид тэднийг удахгүй эргүүлж авна."

Бошиглогч тэгээд цааш нь: "—'Эхчүүд үр хүүхэдтэйгээ үүрд хамт байх уу? гэсэн асуултыг асууж болно' Тийм ээ! Тэгэлгүй яахав! Эхчүүд ээ, та нар хүүхдүүдтэйгээ хамт байх болно. Учир нь тэд мөнх амьдарна. Яагаад гэвэл тэдний өр төлөгдсөн юм" гэжээ.[1]

Бид эдгээр сайхан үгсийг уншсанаас хойш, бид Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан хүүтэйгээ дахин хамт байх болно гэсэн энэхүү амлалтын төлөө манай гэр бүлийн залбирал талархлаар дүүрэн байдаг болсон билээ.

Өнөөдөр бид алдсан хүүгээсээ хойш гурван сайхан хүүхэдтэй болоод байна. Бид хүүхдүүддээ үнэн бөгөөд үүрдийн сайн мэдээг заадаг. Сайн мэдээ тэднийг Тэнгэрлэг Эцэг рүү мөн тэдний Аврагч Есүс Христ рүү удирдах болно.

Үхлийн дараах амьдралын тухай бошиглогч Иосеф Смитийн захиас үнэнийг би мэднэ. Хөшигний хоёр талд, манай гэр бүлд авчирсан итгэл найдвар, амар амгалан, баяр баясгалан, аз жаргалын төлөө би энэхүү захиаст үүрд баярлан талархаж явах болно. ■

Нигери, Лагос, Жюлиана Фэехан

ЭШЛЭЛҮҮД

1. *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* (2007), 176, 177.

Тэгээд уг номыг гартаа барьж байтал "Нас барах үе дэх найдвар, тайтгарлын үгс" бүлэг нь аяндаа нээгдэх нь тэр.

НАДАД БУСАДТАЙ ХУВААЛЦАХ ХООЛ ХҮНС ХАНГАЛТТАЙ ИХ БАЙЛАА

Онцгой үед бэлтгэлтэй байх нь гэр бүлдээ болон өөртөө анхаарал халамж тавих явдал гэж би үргэлж боддог байлаа. Гэтэл би 1992 онд өмнөд Флоридад байхдаа нэгэн ням гарагийн өглөө бэлтгэлтэй байхыг өөрөөр ойлгодог болсон юм. Хамгийн их эвдрэл, сүйрэл учруулагч хар салхинуудын нэг Андрей хар салхи Нэгдсэн Улсыг нэрвэж, Флоридагийн Майамид гайхамшигтай сайхан зуныг сүйтгэж билээ.

Би наран шарлагын газрын ойролцоо нэг орон сууцанд түр хугацаагаар ганцаараа амьдарч байсан бөгөөд ажлынхаа шугамаар гурван сарын сургалтын хөтөлбөрт оролцож байв. Хар салхины талаар бидэнд сэрэмжлүүлсэн бөгөөд үд гэхэд бид орон сууцны барилгуудаас нүүх хэрэгтэй байлаа. Миний таньдаг нэг хүн хамт ажиллагсдад маань болон надад зориулж эх газар дахь зочид буудалд өрөөнүүд захиалсан байсан юм. Би сууцныхаа цонхнуудад банз хадаад хувийнхаа эд юмсыг хадгалж, орхиод явлаа.

Эхнэр, хүүхдүүд маань долоо хоногийн хугацаагаар над дээр ирэх байсан учраас би зургаан хүнтэй гэр бүлдээ зориулж, хангалттай хоол хүнс, ус урьдчилан худалдаж авсан байлаа. Би аюулгүй газар руу хэдэн долоо хоног хангалттай хүрэлцэх хоол хүнс авч явах болсондоо сэтгэл тайван байв.

Өглөөний 10:30-д хөдлөхөөр бэлтгэх үед бүх зүйл бэлэн болсонд би сэтгэл хангалуун байсан. Тэгээд өвдөг сөгдөн залбирч, адислалуудынхаа төлөө Тэнгэрлэг Эцэгт талархал илэрхийлж, айсуй яваа шуурганы үед туслахыг Түүнээс гуйлаа. Залбирлаа дуусгах үед "Хэрэв тусламж хэрэгтэй хэн нэгэн байгаа бол түүнийг олоход надад тусална уу" гэж хэлэхэд Сүнс намайг өдөөв.

Хэдхэн минутын дараа 80 орчим насны нэгэн бэлэвсэн эмэгтэй хаалга тогшив. Тэр эмэгтэй "Уучлаарай, би өрөө андуурчээ. Би нэг найзыгаа хайж явна" гэв.

Тэр санаа нь ихэд зовж, уймарсан байдалтай харагдав. Намайг түүнд тусалж болох уу гэж асуухад тэр эмэгтэй сэтгэл санаа минь уймарч, яахаа ч мэдэхгүй бүр хаашаа явахаа ч мэдэхгүй байна гэлээ. Би түүнээс хаана амьдардгийг нь асуугаад бид нөхцөл байдлыг нь үнэлж цэгнээд түүний хэлсэн газар руу хамт явлаа.

Намайг түүнд тусалж болох уу гэж асуухад тэр эмэгтэй сэтгэл санаа нь уймарч, яахаа ч мэдэхгүй бүр хаашаа явахаа ч мэдэхгүй байна гэлээ.

Хамт ажиллагсад маань зочид буудлын өрөөнүүдийн нэгэнд байрлах болно гэдгийг би түүнд хэлээд манай бүлэгтэй хамт байхад урив. Тэр эмэгтэйн сэтгэл уужирч, санаа алдлаа. Бид бэлтгэлээ түргэхэн хангаж, түүний сууц, эд хогшлыг бэхэлж орхиод нөгөө таньдаг хүнээсээ түүнийг машинаар зочид буудалд хүргэж өгөхийг хүслээ.

Намайг явахаар бэлтгэж байх үед дахиад хоёр бэлэвсэн эмэгтэй тусламж хүсч ирэв. Би тэдэнд хар салхины үеэр толгой хоргодох байр хаанаас олж болохыг тодорхой зааж өгөн, тайван байхад нь тусаллаа. Намайг хамт ажиллагсдынхаа нэгнийх нь ачааг авч байтал дахиад нэг настай бэлэвсэн эмэгтэй ирж тусламж гуйсан. Бид түүний нарийн нандин эд зүйлсийг найдвартай газарт хадгалаад явахад бэлтгэхэд нь туслав.

Мөн энэ үед хамтран ажиллагсад маань арал дээр амьдарч байсан коллежийн хоёр оюутныг эх газарт манай бүлэгтэй нэгдэхэд урьсан байлаа. Тэдэнд байсан хоол хүнс гэвэл ердөө ганц таваг хөнгөн зууш, 0.950 литр рашаан л байв. Аз болоход надад тэр хоёр оюутантай төдийгүй бусад хүн бүртэй хуваалцах хоол хүнс хангалттай байсан юм.

Бэлтгэлтэй байж, Их Эзэнээр удирдуулах нь ямар их адислал билээ! Энэ нь аюул тохиолдсон үед бусдыг тайтгаруулж, бараг бүх цаг заваа амин хувиа бодолгүйгээр бусдад туслахад зориулах боломжийг надад олгосон юм. Манай санваарын удирдагчдаас бидэнд өгдөг бэлтгэлтэй байх зөвлөгөөг би шинэ түвшинд өндрөөр үнэлдэг болсон. ■

АНУ, Калифорн, Брэнт Фишэр

НАР МАНДАХЫГ ХҮЛЭЭСЭН НЬ

Би нөхрийнхөө унтаж байгаа эсэхийг нь мэдэхийн тулд түүний амьсгалахыг чагнан, сэрүүн хэвтэж байтал өрөөг харанхуй бүрхэв. 12 настай охин маань гэнэт осолд орж нас бараад дөнгөж хоёр хонож байлаа. Би дахиад нүдээ аньсан ч нойр хүрсэнгүй. Охин минь хамт байсан ч болоосой хэмээн гуниглаж байлаа. Авралын төлөвлөгөөний тухай бүх мэдлэг минь ч охиноо алдсаны төлөөх бидний уй гашууг нимгэлсэнгүй.

Үүр гэгээрэх үед зүрх сэтгэл гэнэт шархиран өвдлөө. Удахгүй нар мандана. Би улбар ягаан гэрэлд умбасан тэнгэрийг оюун ухаандаа төсөөлөн харж байв. Хөөрхий охин минь ягаан өнгөнд дуртай байсансан. Улбар ягаан өнгөтэй нар мандах нь охинтойгоо ойр байгаагаа дахин мэдрэхэд надад хэрэгтэй зүйл байх болно.

“Нар мандахыг харахаар явцгаая” гэж би нойрмоглосон нөхөртөө шивнэн хэллээ.

Бид машин зам дээр зогсон, дорно зүг рүү харан хүлээсээр . . . хүлээсээр л. Тэнгэрийн хаяа гэгээрсэн ч доогуур нь нүүх үүлсийн цаанаас нар гарч ирэхгүй л байлаа.

Би нөхрийнхөө мөрийг толгойгоороо түшин, санаа алдаад юу ч болоогүй юм шиг дүр эсгэхийг хичээж байлаа. Гэвч би илүү их зүйлийг хүсч байв. Надад илүү их зүйл хэрэгтэй байлаа. Тэнгэрлэг Эцэг хайртай охиныг минь Өөртөө авсны дараа энэхүү чин хүслийг минь надад биелүүлж өгөх нь лавтай.

Нөхөр минь гэртээ орохоор эргэхдээ бидний ар талаар баруун тийш харснаа “Хараач!” гэв.

Би эргэж харлаа. Бидний ард үүлс гоё улбар шаргал гэрэлд умбан харагдана. Миний амьсгал давчдаж, нулимс урсаж эхэллээ. Энэ нь миний төсөөлж чадахаас илүү гоё байлаа. Охин минь намайг тэврээд авах шиг санагдав. Миний зүрх сэтгэл шимшрэн өвдөж байгааг Тэнгэрлэг Эцэг мэдэж, ирээдүйд иттэх найдварын амлалт—мөнхийн гэр бүлүүдийн хийгээд ирээдүйд тохиох гайхалтай сайхан хормуудын тухай сэтгэл уярам сануулагчийг Тэрээр илгээснийг би мэдэж байлаа.

Би энэхүү гайхалтай сайхан хормын талаар болон үүний надад өгсөн шинэ ойлголтын тухай олонтоо боддог байлаа. Нар баруунаас мандахыг хүлээдэг хүн бий гэж үү? Гэвч миний гайхамшиг чухам тэнд л хүлээж байсан юм. Адислалууд болон гайхамшгууд санаанд оромгүй газраас гарч ирдэг учраас би тэдгээрээс хэчнээн олныг нь алддаг бол? Би хэрэгтэй гэж үзсэн ямар нэг зүйл дээр анхаарлаа төвлөрүүлээд жинхэнэ чухал зүйлийг хэчнээн удаа анзааралгүй өнгөрүүлсэн бол оо?

Бид нэгэн гайхамшгийн төлөө цөхрөлтгүй залбирсан боловч уг гайхамшиг бидэнд тохиосонгүй, харин охиныхоо эрхтнүүдийг өвчтэй хүмүүст хандивласнаар дөрвөн хүний амьдралыг сайжруулсан гайхамшиг, гэр бүлийн хайр болон тойргийн эв нэгдлийн гайхамшиг, үйлчлэлийн гайхамшгийг би шинэ ойлголтоороо харсан юм. Би гүнзгий уй гашууд автсан ч өглөө бүр улбар ягаан туяа цацруулан мандаж, орой бүр улбар ягаан туяа цацруулан жаргах нарыг хараад бас зам дээрх улбар ягаан цэцэг бүрийг хараад бие сэтгэл минь хүчирхэг найдвараар дүүрэхийг мэдэрдэг билээ.

Би одоо нар мандах үеэр дорно зүг рүү хараад дараа нь баруун зүг рүү хардаг болсон. Адислалууд болон гайхамшгууд үргэлж тохиодог гэдгийг, хэрэв бид түүнд боломж олгох юм бол бидэнд уй гашуу тохиолдсон үед ч нар үргэлж мандах болно гэдгийг мэдээд би инээмсэглэдэг. ■

АНУ, Огайо, Жюлиа Вагнер

Нөхөр минь гэртээ орохоор эргэхдээ бидний ар талаар баруун тийш харснаа “Хараач!” гэв. Бидний ард үүлс гоё улбар шаргал гэрэлд умбан харагдана.



Хэл яриа, зан төлөв, гадаад төрх байдлаараа даруухан амьдрах нь бидэнд гэрлээ цацруулж, Бурханыг алдаршуулахад хэрхэн тусалж чадах вэ?

Хэрэв та нар миний алдар суугийн

төлөө бүхнээ зориулах аваас

Кэтэрин Нэлсон, Хайди Макконки нар

Мөнх бус байдлын өмнө тэнгэрт болсон зөвлөгөөн дээр Есүс Христ бидний Аврагч байхаар сайн дураараа санал гаргаж, Эцэгт хандан, “Таны таалал хэрэгжих болно, мөн алдар суу үүрд таных байх болно” (Мосе 4:2) гэж хэлсэн билээ.

Их Эзэн Эцэгийг алдаршуулахад ямагт үлгэр жишээ үзүүлдэг байлаа. Аврагч мөнх бус үйлчлэлийнхээ үед хэзээ ч Өөртөө анхаарал тавьдаггүй харин дагалдагчдынхаа анхаарлыг Эцэгт хандуулан, “Надад итгэгч хүн Надад итгэж байгаа биш, харин Намайг Илгээгчид итгэж байгаа юм” (Иохан 12:44) гэж хэлдэг байв. Аврагч зан харьцаа, гадаад төрх байдал, үг яриа, үйл хэргээрээ даруу байдлын ач холбогдлыг бидэнд заадаг байлаа.

Энэхүү өгүүлэлд дурдагдсан залуучууд Аврагчийг дагах чин хүсэл эрмэлзлээрээ даруу байдлын дотоод, гадаад илрэлийн тухай өгүүлж, Бурханыг алдаршуулах шийдвэр төгс байдал нь тэдний зан чанарыг хэрхэн төлөвшүүлж, үйлдлүүдийг нь хэрхэн удирдсан тухай хуваалцаж байна.

Бурханыг алдаршуулж, гэрлээ цацруул

Бид даруу байдал гэдэг нь үнэхээр юу болохыг ойлгосон үед л даруу байдал Бурханыг хэрхэн алдаршуулдгийг илүү сайн ойлгож чадна. *Итгэлдээ үнэнч байх нь* товхимолд: “Даруу байдал бол хувцаслалт, үс засалт, үг яриа, зан төлөвт илэрдэг номхон дөлгөөн, зөвт байдал юм. Хэрэв та даруу бол бусдын анхаарлыг өөртөө зохисгүй байдлаар татдаггүй байх ёстой” хэмээн тайлбарлажээ. Үүний оронд та ‘биеэрээ болон сүнсээрээ Бурханыг алдаршуулагтун’ (1 Коринт 6:20).”[1]

Аврагч хэрхэн даруу байсан шиг бид байж сурах юм бол Сүнсийг бид амьдралдаа урьж, “хэрэв та нар [Бурханы] сүр жавхлангийн төлөө бүхнээ зориулах аваас та нарын бүхэл бие гэрлээр дүүргэгдэх болно” (С ба Г 88:67) гэсэн амлалт бидний хувьд биелэгдэх болно. Та бусад залуучуудыг даруу байдлыг хэрхэн ойлгодог талаар уншиж, даруу байдлынхаа дотоод шийдвэр төгс байдал ба гадаад илрэлийг дээшлүүлснээр сүнслэг байдлаа хэрхэн нэмэгдүүлж болохыг авч үзэж болно.

Хэл яриа, зан төлөвөөрөө даруу бай

“Таны үг яриа, үйлдлүүд өөрт чинь болон өрөөл бусдад онцгой нөлөө үзүүлж болно. Санаа бодлоо цэвэр, эелдэг, уриалгахнаар мөн өөдрөг өрнүүн хэлээр илэрхийлж бай, эргэн тойрныхоо хүмүүст үйлдлээрээ аз жаргал бэлэглэж бай. Үг яриа, үйл хэргээрээ даруу байх хичээл зүтгэл чинь Ариун Сүнснээс ирэх удирдамж хийгээд тайтгарлыг нэмэгдүүлэх болно.”[2]

Оросын Волгоградын Дарья Сергеевна Швидко, бид бусадтай харилцахдаа тэдэнд хүндэтгэлтэй хандан, “бодол санаагаа эелдэг зөөлөн, тайван дуу хоолойгоор, зохисгүй бүдүүлэг үгс хэрэглэлгүйгээр илэрхийлдэг байснаар” бид хэл яриагаараа даруу байдаг хэмээн тайлбарлаж байна. Хэл яриагаараа даруу байх нь хов жив хөөцөлдөхгүй, бусдыг шоолж, тэднээр доог тохуу хийхгүй, хорон егөөдөл хэлэхгүй байх явдал мөн. Ийм байх нь бусдыг гомдооход эсвэл өөрийгөө

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

дөвийлгөн бусдаас илүү гэж бодоход биднийг хэзээ ч хүргэхгүй бөгөөд Бурханы бүх хүүхдүүдийн тэнгэрлэг мөн чанарыг хүлээн зөвшөөрч, тэдэнд нинжин сэтгэлээр ханддагаа харуулж байгаа хэрэг юм.

Бидний хэл яриа Бурхан Тэргүүтнийг бид дээдлэн хүндэлдгийг бас харуулах ёстой: "Дэлхийд ихэд нийтлэг байдаг бохир, бүдүүлэг үг хэллэгээс мөн Их Эзэний нэрийг хүндэтгэлтэй бишээр хэрэглэх явдлаас зайлсхий. . . . Ийм хүндэтгэлгүй хэл яриа нь . . . Ариун Сүнсний намуухан өдөөлтүүдийг хүлээн авах [бидний] чадварыг доройтуулдаг."[3]

"Даруу байдал бол хувцаслалт, үс засалт, үг яриа, зан төлөвт илэрдэг номхон дөлгөөн, зөвт байдал юм. Хэрэв та даруу бол бусдын анхаарлыг өөртөө зохисгүй байдлаар татдаггүй байх ёстой."

АНУ-ын Ютагийн Кэлли Прүгийн хэлснээр "бусдын талаар хов жив ярих, тэднийг шоолох зэрэг даруу биш хэл яриа нь хүмүүс хоорондын харилцаанд сэв суулгадаг бол, даруухан хэл яриа нь "бусадтай найрсаг харилцааг хөгжүүлэх бидний чадварыг нэмэгдүүлдэг. Бидний даруу хэл яриа бусад хүмүүст байдаг хамгийн сайн сайхан зүйлсийг олж харахад бидэнд тусалдаг."

Хэл яриагаараа даруу байх мөн зан төлөвөөрөө даруу байх нь нэг юмны хоёр тал юм. "Хэл яриа болон зан төлөвөөрөө даруу байх нь өөрийг тань хэн бэ гэдгийг бас өөрийн тань эрхэмлэдэг зүйлсийг харуулдаг учраас чухал юм" гэж Ютагийн Майк Өүлсэн хэлсэн юм. Үг, үйлдэл хоёр тань зөрдөг бол энэ нь хүмүүст анзаарагддаг. Бусдыг өргөж, Бурханыг алдаршуулдаг бидний хэл яриаг сайн үйлдлүүд дагалддаг байх ёстой. Бусдыг өргөж, Бурханыг дээдлэн хүндлэх бидний шийдвэр төгс байдал бидний үгсээс илүү чухал болохыг бид үйлчлэл ба нинжин сэтгэлийн үйлдлүүдээр дамжуулан харуулдаг билээ. Үг ба үйлдлээрээ шавь байх бидний үлгэр жишээ бусдад сайн нөлөө үзүүлж чадна.

"Зан төлөв, хэл яриагаараа даруу байхыг би үнэхээр чухал гэж үздэг. Даруу бөгөөд бусдын анхаарлыг өөртөө татах зүйлсийг хийдэггүй хүнд ямар нэг сайн зүйл заавал байдаг. Даруу үг яриатай хүмүүс Их Эзэний хүчирхэг савнууд байдаг" гэж АНУ-ын Колорадогийн Кэрри Карлсон ярилаа.

Хувцаслалт, гадаад төрх байдлаараа даруу бай

"Даруухан [хувцаслах нь] эгэл хүн биш харин сүнслэг хүн байхад анхаарлаа төвлөрүүлэхэд бидэнд тусалдаг" гэж Ютагийн Пол Кэйв хэлэв. Бид даруухан хувцасласнаараа бусад хүмүүст өөрсдийгөө танин мэдүүлэх болон харагдах байдлаараа биш харин хувь хүний зан чанараараа үнэлэгддэг.

Бидний хувцасласан байдал нь бусад хүмүүс бидэнтэй хэрхэн харьцах дохио болдог төдийгүй бид өөрсдийгөө хэрхэн үзэж, үнэлдэгт маань нөлөөлдөг. "Бидний бие бол Бурханаас өгсөн бэлэг гэдгийг бид сайн мэдээнээс мэддэг болсон. Бидний бие бидэнд өсч хөгжин, Тэнгэрлэг Эцэгтэйгээ адилхан болоход тусалдаг. Энэ шалтгаанаар даруухан хувцаслах нь чухал юм. Бид ингэснээрээ энэхүү бэлэгтээ болон бусдад хүндэтгэлтэй ханддагаа Бурханд харуулж чадна" хэмээн Бразилын Луи Да Крүз Жониор ярилаа.[4]

Кэрри "даруу бус хувцаслах нь бие бол хүний сүнс болон зан чанараас тусгаар оршдог зүйл гэсэн ойлголтыг төрүүлэх зорилготой юм. Даруу байх нь зарим үед илүү их мөнгө зарж, мэдээж хэрэг бас илүү их цаг хугацаа зарцуулахыг шаарддаг ч миний бие Тэнгэрлэг эцэг, эхийн төрүүлж өсгөсөн, бурханлаг чадавх хийгээд хувь тавилан бүхий үнэ цэнэтэй сүнсийг дотроо агуулдгийг мэдэхэд надад тусалсан билээ. Бид биедээ дэлхийн өгч чадахаас илүү их хүндлэл, анхаарал халамж тавьдаг байх ёстой" хэмээн тайлбарлалаа.

Итгэлдээ үнэнч байх нь товхимолд "Та нар [даруу биш хувцаснаас] зайлсхийхээс гадна, хувцаслалт, гадаад төрх байдал, үс засалтаараа хэт гажууд байхаас зайлсхийх ёстой. Хувцаслалт, үс засалт, биеэ авч явах байдлаар хэзээ ч хааш яйш, салан задгай бүү бай, харин үргэлж цэвэр цэмцгэр бай" хэмээн заажээ.[5] Бид хувцаслалтаараа болон биеэ авч яваа байдлаараа Бурханыг, өөрийгөө болон өрөөл бусдыг хэрхэн хүндэлдгээ харуулдаг.

Жишгүүдийг итгэл төгс дага

Бид даруу байдлын талаарх сайн мэдээний жишгүүдийг дагахыг хичээснээрээ зөвхөн тохиромжтой үед биш харин бүх цаг үед Их Эзэний зарлигуудаар амьдрах итгэл төгс байдлаа харуулдаг билээ.

Жинхэнэ итгэл төгс байдал нь сайн мэдээний зарчмууд дээр суурилсан байдаг. "Даруу байдал бол сайн мэдээ болон авралын төлөвлөгөөний тухай ойлголтынхоо дагуу сэтгэх, ярих болон үйлдэх байнгын

хүсэл ба оюун санааны илэрхийлэл юм.” Бид амьдралынхаа бүх талд сайн мэдээний дагуу амьдрахыг хичээх юм бол бидний хөрвөлт гүнзгийрч, сайн мэдээний зарчмуудаар амьдрах хүсэл улам нэмэгдэх болно.

Өөрийнхөө бурханлаг мөн чанарыг ойлго

Үргэлж даруу байх нь өөрсдийгөө Тэнгэрлэг эцэг, эхийн хүүхдүүд гэдгийг ойлгож мөн үүнд талархалтай байхад тусалдаг бол, өөрсдийнхөө

бурханлаг мөн чанарыг мэддэг байх нь улам бүр даруу байхад бидэнд сүнслэгээр нөлөөлөх болно. Италийн Флоренцын Рафаэлла Фэррини “Даруу байдал надад өөрийгөө Тэнгэрлэг Эцэгийнхээ онцгой охин гэдгийг мэдэхэд тусалсан учраас энэхүү мэдлэг надад даруу байх хүслийг төрүүлдэг” гэж ярилаа.

Бид өөрийнхөө хэн болохыг дэлхийн үнэлэмжээр тодорхойлох нь хувийнхаа үнэлэмжийг үгүй болгож байгаа хэрэг мөн. “Би даруу байдлын тухай гэрчлэлтэй болохоосоо өмнө аз жаргалгүй, сүнслэг байдлын хувьд найдваргүй байсан. Дэлхийн материаллаг болон биет зүйлсийн дарамт хахир хатуу, өршөөлгүй учраас өөрийгөө дэлхийн үнэлэмжээр тодорхойлж байсан нь надад сэтгэл санааны дарамттай бөгөөд сүнслэг байдлын хувьд хор уршигтай байлаа. Би дэлхийг сонсохоо больж, Бурхантай харилцах миний харилцаа намайг тодорхойлдог байхаар нэгэнт шийдсэн учраас амьдрал илүү амар хялбар, эрх чөлөөтэй, аз жаргалтай болсон юм” хэмээн Ютагийн Жюлиана Ауна өөрийнхөө туршлагаас өгүүлж байна. Бид дэлхийн сайшаалын оронд Бурханы тааллыг эрэлхийлснээр амьдралдаа илүү баяр баясгалантай, илүү даруу байх агуу хүсэл эрмэлзэлтэй байх болно.

Даруухан амьдралаар амьдар

“Даруу байдал бидний хийдэг юм бүхэнд, хэл яриа, гадаад төрх, биеэ авч явах байдал, тэр ч байтугай бидний очдог газарт илэрдэг” гэж Оросын Новосибирскийн Галина Викторовна Савчук ярилаа. Даруу амьдрал нь сайн мэдээ хийгээд Бурхантай харилцах харилцаан дахь бидний итгэл төгс байдалтай нягт холбоотой юм.

Жинхэнэ даруу байдал нь зан төлөв, харьцаа хандлага хоёрын нэгдэл юм. Зан төлөв, сэтгэлгээ хоёроо төгөлдөржүүлэхээр ажиллах нь бусад талаа сайжруулахад бидэнд туслах болно. Зан төлөв ба гадаад төрхөөрөө даруу байх явдлыг насан туршдаа тууштай хөгжүүлэхгүй бол даруу амьдралаас ирдэг адислалуудыг бүрэн хүлээн авч чадахгүй. Бид өөрсдийгөө даруу хүмүүс байх ёстой гэдэгт итгэсэн атлаа үүнийгээ үйлдлүүдээрээ үзүүлэхгүй бол өөрийгөө хуурсан хэрэг юм.[6]

Даруу байдалтай холбогдуулж хэлэхэд, бидний бодол санаа Бурханы алдар суугийн төлөө бүрэн чиглэнэ гэдэг нь бид гадаад төрхөөрөө болон дотоод сэтгэлээрээ даруу төлөв амьдрах шийдвэрийг эргэлт буцалтгүй гаргасан байх ёстой. Бидний бодол санаа Бурхан дээр төвлөрсөн үед л бидний гадаад төрх болон үйлдлүүд даруу байдлын зарчмуудад нийцэх болно. Гэхдээ зөвхөн бодол санаагаа Бурхан руу чиглүүлснээр Түүний алдар суугийн төлөө бүхнээ зориулж байгаа явдал биш юм. Үүн лүгээ адил, хувцаслалт, үс засалт даруу байх нь мөнхийн зарчмуудын тухай бодол санаатай салшгүй холбоотой байх ёстой.

Бид Бурханы зарлигуудыг сахисан үед бодол санаагаа Түүн дээр төвлөрүүлэх нь илүү амархан байх болно. Үүн лүгээ адил хэрэв бид бодол санаагаа Бурхан дээр төвлөрүүлбэл Түүнд аяндаа дуулгавартай байх болно.

Бид даруу байдлаар амьдрахыг хичээснээр амьдралдаа Сүнсний нөлөө ихсэж байгааг мэдрэх болно. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс: “Даруу байдал бол Сүнсийг өөртөө байлгахаар зохистой байхын үндэс суурь мөн. Даруу байна гэдэг нь номхон дөлгөөн байна гэсэн үг бөгөөд даруу байснаар бид Сүнсийг өөртэйгөө хамт байлгахад урьдаг” гэж заажээ. Сүнс бидний бодол санаа, үйлдлүүдийг удирдсан үед бидний бодол санаа Бурханы алдар суугийн төлөө бүрэн чиглэж, гэрлээр дүүрэн байх болно.[7] ■

Кэтэрин Нэлсон АНУ-ын Ютад, Хэйди Макконки АНУ-ын Делаваред амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэлүүд* (2004), 106-р хуудас.
2. *Итгэлдээ үнэнч байх нь,* 108-р хуудас.
3. *Итгэлдээ үнэнч байх нь,*108-р хуудас.
4. *Итгэлдээ үнэнч байх нь* товхимол, 107-р хуудсыг үзнэ үү.
5. *Итгэлдээ үнэнч байх нь,*107-р хуудас.
6. Линн Ж.Роббинс, “Та нар ямархуу маягийн эрэгтэй, эмэгтэйчүүд байвал зохих вэ?” *Ensign* эсвэл *Лиахона,* 2011 оны 5-р сар, 103-р хуудсыг үзнэ үү.
7. Робэрт Д.Хэйлс, “Даруу байдал: Их Эзэнээ дээдлэх хүндлэл,” *Ensign,* 2008 оны 8-р сар, 34; *Лиахона,* 2008 оны 8-р сар, 18.

Финланд

дахь хөрвөлт ба золиослол

Финландын итгэлтэй залуу хүн байх нь ямар санагддаг вэ? Нэг залуу эрэгтэй өөрийн соёл заншлаас болон итгэлийн талаар хуваалцаж байна.

Мэлиза Зэнтэно

Финландын Хельсинкийн эргээс хэдхэн бээрийн зайд халдан довтлогчдоос хамгаалахын тулд Суомэнлинна хэмээх далайн бэхлэлт цайзыг 18-р зуунд барьсан ажээ. Зургаан арлыг дамнан үргэлжилсэн энэхүү хүчирхэг цайз финчүүдийн зоримог шийдэмгий зан чанарын бэлгэдэл болон сүндэрлэж байна.

Харин фин гишүүд нийслэл хотдоо ирсэн үед өөр нэгэн барилга руу очдог. Финландын Хельсинкийн ариун сүм бол тэдний хөрвөлтийн болон сайн мэдээний дагуу амьдарснаар тэдний хүлээн авсан хамгаалалтын бодит бэлгэдэл юм.

Финландын Рованиемигийн 24 настай залуу эр Нийло Кэрвинэнгийн хувьд галт тэргээр 10 цаг явж, Хельсинкид ирэх нь ариун сүмд үйлчилснээс ирдэг адислалын төлөө өчүүхэн төлөөс хийж байгаа хэрэг ажээ.

Финландын Хельсинкийн ариун сүмийг 2006 онд адислахаас өмнө Нийло болон түүний тойргийн бусад гишүүд Шведийн Стокгольм, Данийн Копенгагены ариун сүмүүд рүү явдаг байжээ. “Эдгээр ариун сүмүүд рүү очиход ихэвчлэн зуны амралтын үеэр долоо хоног зарцуулдаг байлаа” гэж тэр хэлэв. Автобусаар аялж, майханд унтдаг байсан нь түүнд хамгийн сайхан дурсамж үлдээсэн аж.

Харин эх орондоо ариун сүмтэй болсон нь гайхамшигтай адислал юм. “Хельсинкийн ариун сүмийг барихаар зарлахад би ёстой л магнай хагартлаа баярласан даа. Ариун сүмийн онцгойлон адисалсан адислалын залбирлын хүчийг би тийшээ орох болгондоо мэдэрдэг” гэж Нийло ярилаа.

Ариун сүмийг хайрлах энэхүү хайр нь Нийлог найз нөхдөөс нь тэс ондоо болгосон ажээ. “Финчүүд шаргуу ажилладаг, идэвхтэй амьдралд дуртай ч амьдралдаа сүнслэг зүйлсэд өчүүхэн бага хугацааг зарцуулдаг” гэж тэр хэлсэн. Тэр сайн найз нөхдөөр үргэлж адислагддаг ч найз нарынх нь амьдралын хэв маяг болон хэрхэн амьдрах талаарх түүний заалгадаг зүйл хоёр хоорондоо эрс ялгаатай нь нас ахих тусам түүнд улам тодорхой болжээ. Энэхүү ялгаа Нийлог 17-той байхад нь хувийн гэрчлэлтэй болохыг эрэлхийлэхэд хүргэсэн аж. “Би юунд итгэх ёстой, ямар хүн байх ёстой талаараа шийдвэр гаргах хэрэгтэй байлаа. Их Эзэний адислалуудын ачаар бас гэр бүл, найз нөхдийнхөө удирдамж зөвлөгөөгөөр сүмийн тухай хүчтэй гэрчлэлтэй болсон” гэж тэр ярив.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар хөрвөлтийн тухай хэлсэн үгэндээ “Бид үнэний мэдлэгтэй болж, Их Эзэнд хөрвөсөн үед гуйвшгүй бат бөх байж, хэзээ ч унахгүй байх болно гэдгийг би амлаж байна” гэжээ.[1] Хельсинк рүү аялах нь цаг хугацаа, мөнгө шаарддаг ч Нийло Христийн шавь байх шийдвэр төгс бодолтой хүн. Энэ нь Нийлогийн хувьд золиослол огтхон ч биш ажээ. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Дэвид А.Бэднар, “Их Эзэнд хөрвөгдсөн нь,” *Лиахона,* 2012 оны 11-р сар, 109.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ КУККА ФРИСТРОМ

НИЙЛОГИЙН ТУХАЙ ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Финчүүд ихэвчлэн юу иддэг вэ?
Өөрийн дуртай хоолнуудаас заримыг нь нэрлэвэл: хулд загасны шөл, төмсний нухаштай цаа бугын мах. Бид бас хөх тарианы талх их иддэг.

Та цагийг хөгжилтэй өнгөрөөхийн тулд юу хийдэг вэ?
Би цасны гулсуурт дуртай бас кино үзэх юм уу зүгээр л гадуур явган явах дуртай. Би Японд номлолд үйлчилсэн болохоор боломж гарсан үедээ япон хэл сурдаг.

Финландад хүмүүс яаж болздог вэ?
Болзооны тухайд гэвэл, манай оронд хатуу тогтсон уламжлал байдаггүй. Ерөнхийдөө хүмүүсийн сонирхдог зүйл нэлээд их хэмжээгээр адил байгаа нь мэдэгдсэний дараа л тэд хэн нэгэнтэй гадуур уулзахыг хүсдэг. Финландад болзоо нь хүнтэй танилцах механизм биш байдаг. Гишүүд олон биш боловч тэдний дунд итгэлтэй залуус бий. Заримдаа ганц бие залуу гишүүд ганц бие залуучуудын бүжгэн дээр танилцсан хүнтэйгээ болзож, уулзахын тулд хол газар аялдаг.

ФИНЛАНД ДАХЬ СҮМ

4 715 Хожмын үеийн гэгээнтэн
15 тойрог
15 салбар
2 гадас
1 номлол
2006 оны 10-р сарын 22-нд онцгойлон адислагдсан нэг ариун сүм

ТООГООР

Хүн ам 5 250 000 (2012 оны 1-р сарын байдлаар)
Нууруудын тоо 187 888
Арлуудын тоо 179 584
Саун 2.2 сая

МЭДЭЭ БАРИМТ

Нийслэл: Хельсинк
Хэл: Фин (суоми)

ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮМҮҮС
ИХ ЭЗЭНИЙ АЖИЛД

Тэнгэрлэг Эцэгийн, санваараар адислагдсан агуу төлөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөр болович үнэ цэнэ бүхий үүргүүдтэй байдаг.

Ахлагч М. Рассэлл Баллард
Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын

Дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулж, хүчирхэгжүүлэх эмэгтэйчүүдийн амин чухал үүргийн талаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ойлговол зохих хэд хэдэн үнэнүүд байдаг гэдэгт би итгэдэг. Маш олон талаараа эмэгтэйчүүд нь сүмийн амин чухал хэсэг нь байдаг. Тиймээс Их Эзэний тусламжтайгаар би сүмийн итгэлтэй эмэгтэйчүүд болон залуу эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлмээр байна. Хайрт эгч нар аа, дэлхийн өнцөг булан бүрд амьдарч байгаа та нартаа Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр төлөөлөгчид үнэхээрийн их хайртай бөгөөд та бүхэнд итгэж найддаг гэдгийг маань ойлгоорой.

Энэ дэлхий дээр бид юу хийж байгаа талаар сануулснаар би үгээ эхэлье.

Бид бол Тэнгэрлэг Эцэгийнхээ хайртай сүнсэн хөвгүүд болон охид билээ. Дэлхийн өмнөх оршихуйд бид Түүнтэй хамт амьдарч байсан. “Үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд” (Мосе 1:39) тохиолгон авчрах үүрэг зорилгоо биелүүлэхийн тулд Тэнгэрлэг Эцэг хүүхдүүддээ хамгийн дээд чадавхдаа хүрэхэд нь туслах төлөвлөгөөг бүтээжээ. Эцэгийн маань төлөвлөгөө хүмүүнийг зуурдын байдалд төрж, бие махбодтой болон, соригдон шалгагдах хугацаанд ирснээрээ унаж, Түүнээс хэсэг хугацаанд тусгаарлагдахаар дуудсан юм. Түүний төлөвлөгөө нь хүн төрөлхтөнийг уналтаас гэтэлгэхийн тулд Аврагчийг өгсөн. Их Эзэн Есүс Христийн Цагаатгал нь сайн мэдээний ёслолууд болон ариун гэрээнүүдээр дамжуулан Бурханы дэргэд эргэж очих арга замаар хангадаг. Бид аюул гамшгаар дүүрэн зуурдын оршихуйд амьдрах учраас бидэнд өөрсдийн маань хүчнээс илүү агуу хүч хэрэг болно гэдгийг Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү мэдэж байжээ. Христийн сайн мэдээ болон сургаал нь үүнийг хүлээн авах хүн бүрд мөнх амьдралд хүрэх болон уг аялалд баяр баясгаланг олж авах хүчийг өгдөг.

Зарим хүмүүст сүм дэх болон Бурханы төлөвлөгөөн дэх эмэгтэйчүүдийн үүргийн талаар асуух асуулт байдаг. Би үндэсний болон олон улсын мэдээллийн хэрэгслүүдээр хангалттай олон удаа ярилцлага өгч байсан ба уулзсан ихэнх сэтгүүлчид энэ сэдвээр тодорхой нотолгоогүй хэрнээ баттай бодол санаатай болсон байв. Эмэгтэйчүүд сүмд доод зиндаанд байдаг талаар тэд надаас олон жилийн турш асуудаг байсан. Энэ нь үнэхээр худал зүйл юм.

Энэхүү чухал сэдвийн талаар би та бүхнийг тунгаан бодоосой хэмээн 5 үндсэн санааг санал болгож байна.

1. Мөнх амьдралд хүрэхэд минь бидэнд туслах төлөвлөгөө Бурханд байдаг

Тэнгэрлэг Эцэг маань Өөрийн сүнсэн хөвгүүд, охид болох эрэгтэй, эмэгтэйчүүдийг бүтээсэн. Ингэхлээр хүйс нь мөнхийн зүйл гэсэн үг юм. Түүнийг болон Түүний Хүү, Есүс Христийг дагахаар сонгосон хүн бүхэнд мөнх амьдралын өв залгамжлагчдын хувьд өөрсдийн хувь заяандаа хүрэхэд нь туслах төлөвлөгөөг Тэрээр бүтээжээ.

Хэрэв бидний эцсийн өргөмжлөл нь Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн туйлын чухал зорилго юм бол мөн хэрэв Тэд бидний мэддэгээр бүхнийг мэдэгч, төгс юм бол биднийг хэрхэн бэлтгэж, зааж мөн удирдахыг Тэд хамгийн сайн ойлгодог ба тэгснээр бид өргөмжлөлд хүрэхүйц зохистой байх хамгийн агуу боломжтой байх юм.

Ихэнх хүмүүсийн гэр бүл болон найзууд нь төрөл бүрийн нийгмийн асуудалтай байдаг бөгөөд уг асуудлын талаар маргалдах нь ямар ч шийдвэрт хүргэхгүй, харин ч сөргөлдөөнийг бий болгодог. Хэн нэгний сэтгэлд нийцэхээр хариулах тун хэцүү бөгөөд эмзэг асуудлаарх сүмийн байр суурийн талаар ч мөн зарим асуулт байдаг. Гэвч бид эдгээр нөхцөл байдлуудад Их Эзэнээс юу бодох, юу хийх талаараа эрэлхийлж залбирвал: “Та Есүс Христэд итгэдэг үү, та Түүнийг болон Эцэгийг дагадаг уу?” гэсэн бодол өөрт төрдөг. Сүмийн ихэнх хүмүүс хэзээ нэгэн цагт Их Эзэний асуусан бүх зүйлийг хийж чадах эсэхтээ эргэлзэх үе мэдээж гарна гэдэгт би итгэдэг. Харин бид үнэхээр Их Эзэнд итгэдэг л юм бол “Би Есүс Христэд итгэдэг ба Түүний надаас асуух юуг ч хийхэд бэлэн байна” гэсэн нотолгоо нь бидэнд ирэх болно. Тиймээс бид хичээсээр л байдаг. “Би Есүс Христэд итгэдэг” гэдэг үгс нь ямар хүчирхэг гээч!

Тэнгэр дэх Эцэг маань хамгийн сайн сайхан нь юу болохыг мэдэж байдаг гэдэгт бид итгэхэд бэлэн байснаар бидний гэрчлэл, оюун санааны амар амгалан болон аз жаргал эхэлдэг билээ.

2. Сүм санваарын түлхүүрүүдээр удирдагддаг

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм нь Их Эзэний сүм бөгөөд Түүний сүм нь санваарын эрх мэдэл хийгээд санваарын түлхүүрүүдээр удирдагддаг. “Санваарын түлхүүрүүд бол санваарын удирдагчдад

Түүний санваарыг дэлхий дээр хэрэглэх, удирдах, хянах мөн засаглах Бурханаас олгосон эрх мэдэл юм.”[1]

Санваарын түлхүүртэй хүмүүс нь—чуулгынхаа түлхүүрийг атгадаг дикон, тойргийнхоо түлхүүрийг атгадаг бишоп, эсвэл санваарын бүх түлхүүрийг атгадаг сүмийн ерөнхийлөгчийн аль нь ч гэсэн чухамдаа өөрсдийнх нь удирдлага дор итгэлтэйгээр үйлчилдэг бүх хүмүүст санваарын эрх мэдлийг хэрэгжүүлж мөн санваарын хүчийг ашиглах явдлыг боломжтой болгодог билээ.

Бүх эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд нь санваарын түлхүүртэй тэдгээр хүмүүсийн удирдлага дор үйлчилдэг. Энэ бол Их Эзэн Өөрийн сүмээ удирддаг арга зам юм.

Би 2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээ давтан хэлмээр байна. “Тэнгэрлэг Эцэгийн маань санваараар адислагдсан агуу төлөвлөгөөнд санваарыг ашиглах онцгой үүрэг хариуцлага эрчүүдэд өгөгдсөн ч тэд өөрсдөө санваар биш юм аа. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөр үүрэгтэй боловч эдгээр нь үнэ цэнийн хувьд адил байдаг. Эмэгтэй хүн эр хүнгүйгээр үр хүүхэдтэй болж чадахгүйтэй адил эрэгтэйчүүд эмэгтэй хүнгүйгээр мөнхийн гэр бүлтэй болоход санваарын хүчээ бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй. . . . Мөнхийн хэтийн төлөвийг авч үзэхэд хүүхэд төрүүлэх хүч болон санваарын хүчийг эхнэр, нөхөр хоёр хуваалцдаг.”[2]

Яагаад эмэгтэйчүүд биш харин эрэгтэйчүүд санваарын албанд томилогддог вэ? Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) “Их Эзэний сүмд эрэгтэй хүмүүсийг санваар атгахаар томилсон нь” хэн нэг хүн биш Их Эзэн байсан бөгөөд “Бурханы хаант улс ба сүм болох энэхүү агуу хийгээд гайхамшигт байгуулламгыг төгөлдөржүүлэх чадварыг” эмэгтэй хүнд өгсөн нь мөн л Их Эзэн байсан юм” хэмээн тайлбарласан билээ.[3] Эцэст нь Их Эзэн яагаад Өөрийн сүмийг ийнхүү зохион байгуулснаа илчлээгүй юм.

Сүмийн бүх хичээлийн тэн хагасыг эгч нар заадаг гэдгийг бүү мартаарай. Удирдлагын ихэнх нь мөн эгч нараас бүрддэг. Түүнчлэн үйлчлэлийн олон боломж болон үйл ажиллагаа нь эгч нараар төлөвлөгдөж, удирдагддаг. Тойрог, гадасны зөвлөл болон сүмийн удирдлагын ерөнхий зөвлөл дэх эмэгтэйчүүдийн оролцоо нь хэрэгцээтэй үзэл бодол, мэргэн ухаанаар болон тэнцвэртэй байдлаар хангаж байдаг.

Ямар ч хичээл зүтгэлээр бай, тэнгэрийн бүрэн дүүрэн адислалуудыг авчрахын тулд эмэгтэйчүүдийг хүндэлдэг болон тэдний онцгой сүнслэг бэлгийг нь хүндэтгэдэг эрэгтэйчүүд түүнчлэн эрэгтэйчүүдийг хүндэлдэг болон тэдний атгадаг санваарын түлхүүрүүдийг нь хүндэтгэдэг эмэгтэйчүүд сүмд шаардлагатай байдаг.

3. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь адилхан чухал

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нь сүмийн болон Бурханы мэлмийд адил хэдий ч энэ нь тэд хоорондоо яг адилхан гэсэн үг биш юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бурханлаг бэлгүүд болон үүрэг хариуцлагууд нь мөн чанартаа ялгаатай ч тэдгээрийн ач холбогдол ба нөлөөлөл нь адилхан байдаг. Манай сүмийн сургаалд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй эн тэнцүү хэрнээ өөрөөр үздэг. Бурхан аль ч хүйсийг нэг нь нөгөөгөөсөө илүү дээр эсвэл илүү чухал гэж үздэггүй. Ерөнхийлөгч Хинкли эмэгтэйчүүдэд хандан, “Мөнхийн Эцэг маань. . . та бүхнийг Өөрийн бүтээлийн хамгийн гайхамшигтайгаас нь дорд байхыг хэзээ ч хүсээгүй”[4] хэмээн тунхагласан юм.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нь өөр өөр бэлэг, хүч чадалтай мөн өөр өөр үзэл бодол, хүсэл эрмэлзэлтэй. Бид бие биедээ яагаад хэрэгтэй байдгийн нэг үндсэн шалтгаан нь энэ юм. Гэр бүл бий болгоход эрэгтэй, эмэгтэй хүнийг шаарддаг бол Их Эзэний ажлыг биелүүлэхэд мөн л эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг шаардана. Зөв шударгаар хамтдаа ажилладаг эхнэр, нөхөр хоёр бие биенээ бүрэн нөхөн гүйцэдэг билээ. Бидний амьдрал дахь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг болон зорилгуудыг буруугаар ойлгогдохоос болгоомжилцгооё.

4. Бүх хүн санваарын хүчээр адислагддаг

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс ариун сүмд очиход тэдэнд санваарын хүч буюу нэг ижил хүч өгөгддөг. Санваарын эрх мэдэл нь санваарын түлхүүрүүдээр удирдагддаг ба санваарын түлхүүрүүдийг зөвхөн зохистой эрэгтэйчүүд л атгадаг, харин санваарын хүч болон адислалууд нь Бурханы бүх хүүхдүүдэд боломжтой юм.

Тэнгэр дэх Эцэг маань Өөрийн хүчийг харамгүй өгдөг бөгөөд бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүс амьдралд нь туслах энэхүү хүчийг авах боломжтой юм. Их Эзэнтэй ариун гэрээ хийж, тэдгээр гэрээнүүдээ хүндэлдэг хүн бүр хувийн илчлэлт хүлээн аван, тэнгэр элчүүдийн үйлчлэлээр адислагдаж, Их Эзэнтэй харилцан, сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авч мөн эцэст нь Есүс Христтэй хамт Эцэгт байгаа бүгдийн өв залгамжлагчид болох эрхтэй.

5. Бид сургаалын талаар мэдэж авч мөн гэрчлэлээ хуваалцах хэрэгтэй

Сүмийн эмэгтэйчүүд Христийн сургаалыг мэдэж авч мөн бүх л арга замаар сэргээлтийн тухай гэрчлэлээ хуваалцаж байх нь бидэнд хэрэгтэй байна. Дэлхийн түүхэнд хэзээ ч ийм нарийн түвэгтэй цаг үе байгаагүй билээ. Сатан болон түүний дагалдагчид мянга мянган жилийн турш өөрсдийн арга барилыг төгөлдөржүүлж байгаа бөгөөд тэд хүн төрөлхтний Бурханд болон Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг нь устгах талаар мэргэшсэн юм.

—Эрэгтэй, эмэгтэйчүүд болон залуучууд мөн өсвөр үеийнхэн болон охид, хөвгүүд—бид бүгдэд өмгөөлж хамгаалах мөн дэлхий даяар түгэх Их Эзэн болон Түүний сүм байгаа билээ. Бидэнд эмэгтэйчүүдийн онцгой бөгөөд үр нөлөө бүхий дуу хоолой мөн тэдний итгэл илүү их хэрэгтэй байна. Та бүхэн сургаалаас суралцаж, бидний итгэдэг зүйлсийг ойлгож, тэгснээрээ залуу эмэгтэйчүүдийн аялалын галын дэргэдэх болон гэрчлэлийн цуглаан дээр эсвэл блог болон фэйсбүк дээр аль нь ч бай, та бүхэн бүх зүйлийн үнэний талаар гэрчлэлээ хуваалцаж чадна. Гагцхүү та нар л Бурханы гэрээ хийсэн эмэгтэйчүүд чухам ямар харагдаж мөн юунд итгэдэг гэдгийг дэлхийд харуулж чадна.

Эгч нар аа, та бүхний бусдад нөлөөлөх чадвар онцгой бөгөөд эрэгтэй хүн үүнийг хийж чадахгүй. Бурханы охид та нараас өөр хэн ч Аврагчийг маань илүү хүчтэйгээр эсвэл илүү итгэлтэйгээр хамгаалж чадахгүй, гагцхүү та нарт л энэ агуу дотоод хүч болон итгэл үнэмшил байгаа. Хөрвөсөн эмэгтэйчүүдийн дуу хоолой хэмжээлшгүй үнэ цэнэтэй бөгөөд сүмд та бүхний дуу хоолой хэзээ ч байгаагүй ихээр одоо хэрэгтэй байна.

Бид эв нэгдэлтэй байх ёстой тийм цаг үед амьдарч байгаа гэсэн гэрчлэлээ би үлдээж байна. Бид—эрэгтэй, эмэгтэйчүүд; залуу эрэгтэйчүүд ба залуу эмэгтэйчүүд мөн охид, хөвгүүд хамтдаа зогсох ёстой. Бид Тэнгэрлэг Эцэгийнхээ төлөвлөгөөний төлөө зогсох ёстой. Бид Түүнийг хамгаалах ёстой. Түүнийг бусад нь бүгд эсэргүүцэж байна. Бид Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүдийн хувьд үүнийг зүгээр хараад зогсож болохгүй бөгөөд өөрсдийн дуу хоолойг өргөх зүрх зориггүйгээр, энэ бүхнийг үргэлжлэхийг зөвшөөрч болохгүй.

Та бүхэн сайн мэдээний энгийн үнэнүүдээс суралцан, мэдэж авч, тэдгээрийг боломж гарах бүрдээ хуваалцах зоригтой байхаар Бурхан та нарыг адислах болтугай. ■

2013 оны 8-р сарын 20-нд Бригам Янгийн Их Сургууль дээр болсон онцгой цугларалт дээр хэлсэн үгээс. Хэлсэн үгийг англи хэлээр бүрнээр нь уншихыг хүсвэл speeches.byu.edu хаягаар орно уу.

ЭШЛЭЛҮҮД

1. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 2.1.1.
2. М. Рассэлл Баллард, “Энэ нь Миний ажил болон Алдар Суу бөлгөө,” *Лиахона,* 2013 оны 5-р сар, 19.
3. Гордон Б.Хинкли, “Women of the Church,” *Ensign,* 1996 оны 11-р сар, 70.
4. Гордон Б.Хинкли, “Stand Strong against the Wiles of the World,” *Ensign,* 1995 оны 11-р сар, 98.

ҮЙЛЧЛЭХЭД БЭЛТГЭЖ,

БЭЛТГЭХИЙН ТУЛД ҮЙЛЧЛЭХ НЬ

Одоо болон ирээдүйд Бурханд та нараар хийлгэх ажил байгаа учраас Тэрээр та нарт Аароны санваарыг өгсөн.

Дэвид Л.Бэк
Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

Жонатан бол дөрвөн жилийн өмнө сүмд нэгдсэн миний нэг найз билээ. Тэрээр гэр бүлээсээ ганцаархнаа сүмийн гишүүн юм. Аароны санваар хүлээн авсныхаа дараа тэр урьдынхаасаа илүү ихээр бусдад үйлчилж эхлэв. Үйлчлэхийн тулд их зүйл сурах хэрэгтэй гэдгээ Жонатан мэдэж байлаа. Түүнчлэн зохистой хийгээд илүү найдвар хүлээхүйц байхыг хүссэн учраас тэрээр сайн мэдээг судлан, залбирч, ням гаргийн цуглаануудад мөн семинарт оролцож байв. Зарлигуудыг болон сүмийн жишгүүдийг дагахаар тэр ихэд хичээж байлаа. Гэрийн агуу багш байх зэрэг санваарын үүргүүдээ ч тэрээр хичээнгүйлэн гүйцэтгэж байв. *Бурханы өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь* ном нь түүнд тэдгээр үүргүүдийг ойлгож мөн хэрхэн гүйцэтгэхэд нь тусалсан юм.

Жонатаны энэхүү итгэлтэй санваарын үйлчлэл нь түүнд сүнслэг хүч чадлыг өгсөн юм. Энэ нь түүнийг хилэнцэт нөлөөнөөс хамгаалж байв. Мөн тэрээр ирээдүйдээ бэлтгэн, үйлчилж байхдаа үлэмж их өсөж хөгжсөн юм. Өнгөрсөн жил тэрээр Мелкизедек санваар болон ариун сүмийн хишгээ хүлээн авсан билээ. Тэр одоо Бразилд бүрэн цагийн номлолд үйлчилж байна.

Аароны санваарыг ихэвчлэн "бэлтгэл санваар" хэмээн нэрлэдэг. Одоо болон ирээдүйд Бурханд та нараар хийлгэх ажил байгаа учраас Тэрээр та нарт Аароны санваарыг өгсөн. Аароны санваар дахь итгэлтэй үйлчлэл тань ирээдүйд үйлчлэх илүү агуу боломжуудад та нарыг бэлтгэдэг. Яг л Жонатан шиг та нар "Мелкизедек санваар болон ариун сүмийн адислалуудыг хүлээн авч, бүрэн цагийн номлолд үйлчлэн, хайраар дүүрэн эцэг, эх байж мөн Их Эзэнд амьдралынхаа туршид үйлчлэх"-д бэлтгэж байгаа билээ (*Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [2004], 4).

Та нар Тэнгэрлэг Эцэгийн та нарт зориулан бэлтгэсэн гайхамшигт боломжуудыг нэг бүрчлэн мэдэхгүй байж болно, гэхдээ Аароны санваартны хувьд та нар хийх дараах зүйлсээ санаж явбал эдгээртэй тулгарахдаа бэлтгэгдсэн байх болно гэдэгт би итгэлтэй байна.

Есүс Христийг дага

Санваартны хувьд та Есүс Христийн төлөөлөгч билээ. Энэ нь танаас Түүнийг дагаж, Түүний хийх зүйлсийг хийхийг хүссэн гэсэн үг юм. Тэр юу хийх байсан бэ? Нөхцөл байдал бүрд Тэрээр Өөрийн амьдралыг үйлчлэхэд болон бусдыг адислахад зориулсан юм. Та ч бас тийн үйлдэх хэрэгтэй. Бусдад үйлчлэхэд өөрийгөө зориул, тэгээд өсч мөн хөгж, тэгснээр танд өөрөөсөө өгөх зүйл нэмэгдэнэ! Есүс өсвөр насандаа хэрхэн өссөнийг санагтун: Түүний "бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ." (Лук 2:52).

Аврагчийг дагахын нэгээхэн хэсэг нь өсвөр насандаа мэргэн ухаан болон бие махбодын хувьд эрүүл чийрэг болох явдал юм. Энэ нь та нараас шаргуу ажиллаж, үргэлж өөрсдийн чадлын хэрээр хийхийг шаардаг (С ба Г 4:2-ыг үзнэ үү). Та нар



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ТАЯ МОРЛИ

ААРОНЫ САНВААРТНУУДАД:

Дараах зүйлсээр дамжуулан Есүс Христийг дага

- Өдөр бүр залбирах мөн сайн мэдээнээс суралцах
- дуулгавартай байдал
- Бурханы хүслийг эрэлхийлэх

Санваарын томилгоог гүйцэтгэх, жишээ нь

- Ариун ёслолыг адислах
- Бусдад баптисм хүртээх

Дараах зүйлсийг хийж, байнга үйлчил

- Чуулгын гишүүдийг болон гэр бүлийг хүчирхэгжүүлэх
- идэвх султай гишүүдийг аврах
- гачигдсан хүмүүст үйлчлэх

БИ ДАРААХ ЗҮЙЛҮҮДЭД ХЭРХЭН БЭЛТГЭХ ВЭ:

Мелкизедек санваар хүлээн авах

_____

_____

_____

Ариун сүмийн адислалуудыг хүлээн авах авах

_____

_____

_____

Номлолд үйлчлэх

_____

_____

_____

Нөхөр болон эцэг хүн болох

_____

_____

_____

өдөр бүр залбирч, сайн мэдээнээс суралцан, дуулгавартай байдал болон үйлчлэлээр дамжуулан Бурханд ойртож, Түүний тааллыг олдог. Та нар гэр бүлдээ найрсаг хандаж мөн үнэнч байж, Христтэй адил бүх хүмүүстэй найз байснаар мөн бусдын ач тусыг олж авдаг.

Есүс үргэлж Эцэгийн хүслийг гүйцэлдүүлж байсныг санаарай. Та нар бүх л өдрийн турш үйлчлэл хийхдээ Бурханы хүслийг эрэлхийлж, хүлээн авсан сүнслэг нөлөөллийнхөө дагуу үйлдэхдээ Христийг дагадаг.

Санваарын ёслолуудыг гүйцэтгэ

Санваарын ёслолууд нь Бурханы бүх хүүхдүүдэд зайлшгүй шаардлагатай бөгөөд Түүний хөвгүүд болон охидыг эн тэнцүү адисалдаг. Та дикон болсон тэр мөчөөс эхлэн ариун ёслолыг түгээснээрээ санваарын ёслолыг гүйцэтгэхэд тусалдаг. Мөн та ариун ёслолыг бэлтгэж, адислан, баптисм хүртээж түүнчлэн Аароны санваарын томилгоонд оролцсоноор цаашдаа санваарын ёслолуудыг гүйцэтгэх болно.

Та ариун нандин ёслолуудад оролцохдоо цэвэр ариун байх ёстой. Таны ёс суртахууны цэвэр ариун байдал нь гүйцэтгэх ёслолд тань агуу сүнслэг хүчийг нэмж өгч чадна. Их Эзэний ариун ёслолын ариун савнуудыг авч явахуйц зохистой байхыг бүхий л арга замаар эрэлхийл (С ба Г 38:42-ыг үзнэ үү). Хэрэв үүнийг хийвэл та салбар эсвэл тойргийнхоо өмнө Есүс Христийн үнэн төлөөлөгч болон зогсож чадна. Шинэчлэгдэхэд нь тэдэнд тусалж буй таны гэрээнүүдээ сахих шийдвэр төгс байдал тэднийг адислах болно.

Байнга үйлчил

Аароны санваартны хувьд та үйлчилдэг. Бүхий л цаг үед гэр бүл, найзууд, чуулгын гишүүддээ болон бусдад үйлчлэх боломжуудыг эрэлхийл. Таны санваараар хийдэг бүх зүйл бусдад бие махбодоор болон сүнслэг байдлаар үйлчлэхэд тусална. Жишээ нь, та гэрийн багшаар очдог гэр бүлдээ тусалснаар бишопдоо эсвэл салбарын ерөнхийлөгчдөө мөн тусалдаг ба бусдын хэрэгцээг хэрхэн тодорхойлж, санаа тавих талаар суралцдаг. Түүнчлэн та чуулгынхаа гишүүдийг хүчирхэгжүүлэх, идэвх султай гишүүдийг аврах, ядуу болон гачигдсан хүмүүст зориулж мацгийн өргөл цуглуулах болон өвчтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст биеийн хүчний ажил хийж өгөх мөн Христийн тухай болон Түүний сургаалын талаар зааж, гэрчлэх, цөхөрсөн тэдний ачааг хөнгөвчлөх зэргээр бусдад үйлчилдэг.

Та чуулгынхаа цуглаанд болон гэр бүлийн үдшээр гэр бүлдээ хичээл зааснаар мөн үйлчилдэг. Та гэртээ болон чуулгадаа, сургууль дээрээ болон бүрэн цагийн номлогчидтой хамт байхдаа мөн байгаа газар бүрдээ хүмүүсийг Христэд ирэхийг урьснаар бас бусдад үйлчилж байдаг.
(С ба Г 50:29-ийг үзнэ үү)

Таны ирээдүй

Мелкизедек санваартан, номлогч, нөхөр мөн эцэг хүний хувьд ирээдүйд танаас юу шаардагдах талаар эцэг, эхтэйгээ болон зөвлөгчтэйгөө ярилц. Өгөгдсөн зайд эдгээр агуу үүрэг хариуцлагуудаас заримыг мөн Аароны санваарт үйлчлэхдээ тэдгээрт хэрхэн бэлтгэх талаар тэмдэглэл бич. Энэ нь одоохондоо дааж давшгүй мэт санагдаж магадгүй, гэхдээ бэлтгэх хамгийн сайн арга бол зүгээр л Тэнгэрлэг Эцэгийн өнөөдөр танаас хийхийг хүссэн тэр зүйлийг л хийх явдал юм гэдгийг санаарай. Одоо үйлчилж, алдар суут ирээдүйнхээ төлөө бэлтгэхдээ та бүхэн аз жаргалыг олох болтугай. ■

БҮХ ХҮМҮҮСИЙГ АДИСЛАХ ХҮЧ

Санваарын ёслолууд болон гэрээнүүд нь Бурханы бүх хүүхдүүдэд—эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүст боломжтой хэмээн сүмийн удирдагчид бидэнд заадаг билээ.



"Санваар нь бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүс ба хүүхдүүдийн адислал болон авралын төлөө өгөгдсөн Бурханы хүч ба эрх мэдэл юм. . . .

Баптисм хүртэн, Ариун Сүнсийг хүлээн авч, бас ариун ёслолоос тогтмол хүртдэг зөв зохистой хүн бүрд Бурханаас онцгой адислалууд ирдэг билээ. Ариун сүм нь мөнх амьдралын амлалттай хамт гүн гүнзгий ойлголтууд мөн хүчийг авчирдаг [С ба Г 138:37, 51-ийг үзнэ үү].

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн, "Санваар дахь хүч," *Лиахона,* 2013 оны 11-р сар, 92.



"Санваарын эдгээр ёслолууд болон гэрээнүүд нь Бурханы амласан адислалуудыг бүрнээр нь авах боломжийг бидэнд олгодог. Мөн эдгээр адислалууд нь Аврагчийн Цагаатгалаар бидэнд боломжтой болсон билээ. Эдгээр нь Бурханы охид, хөвгүүдийг Бурханы хүчээр зэвсэглэдэг бөгөөд мөнхийн амьдралтай болж, Бурханы дэргэд эргэж очин, Түүнтэй хамт мөнхийн гэр бүлд амьдрах боломжийг бидэнд олгодог."

Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Кэрол М.Стэфэнс, "Бид өөрсдөөө байгаа зүйлээ мэддэг үү?" *Лиахона,* 2013 оны 11-р сар, 12.

"Тэнгэрлэг Эцэг Өөрийн бүх охид, хөвгүүдэд санваарын адислалуудыг хүлээн авч мөн санваарын хүчээр хүчирхэгжих арга замыг өгсөн гэдгийг бид ойлгох нь чухал. Өөрийн сүнсэн хүүхдүүдэд зориулсан Бурханы төлөвлөгөөний чухал хэсэг нь "Учрыг болгоогтун, үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу—бөлгөө" хэмээсэн Түүний өөрийн тунхаглал юм (Мосе 1:39)."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч М. Рассэлл Баллард, "Энэ нь Миний ажил болон алдар суу бөлгөө" *Лиахона,* 2013 оны 5-р сар, 19.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ГЭИЛ АРМСТРОНГ

САНВААРЫН АДИСЛАЛУУДЫГ
ГЭР ОРОНДОО АВЧРАХ НЬ

Бонни Л.Оскарсон
Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч

Та гэрээнүүдээ сахиснаар гэр орон, гэр бүлээ адислах санваарын хүч танд байх болно.

Та залуу эрэгтэй эсвэл залуу эмэгтэйн хувьд гэр бүлийн нөхцөл байдал тань ямар вэ гэдгээс үл хамааран гэр орон, гэр бүлээ хүчирхэгжүүлэхийн тулд баптисм хүртэх үедээ хийсэн гэрээнийхээ хүчинд хэрхэн тулгуурлаж болох вэ? Бид өөрсдийн хамгийн сайн бөгөөд урам хайрласан үйлчлэлийг гэр орондоо хийх замаар Их Эзэний төлөвлөгөөн дэх гэр бүлийн үүрэг, ач холбогдлыг ойлгох нь хийсэн амлалтуудаа хүндэтгэлтэй хандахад бидэнд сүнслэгээр нөлөөлдөг билээ. Бид хамгийн ойр дотны хүмүүсээ хүчирхэгжүүлж, тэдэнд үйлчлэхийн тулд гэрээнүүдийхээ хүчинд тулгуурлах зарим арга замын тухай авч үзэцгээе.

Чи юу гэж хариулах вэ?

Даваа гарагийн орой. Чи уул овоо шиг их гэрийн даалгавар хийх хэрэгтэй байлаа. Аав чинь гэрийнхнээ гэр бүлийн үдэштээ цуглахад дуудаж байдаг. Чи яах вэ?

Сонголт А: “Өө, аав аа, өнөө орой надад цаг алга! Хичээлээ хийх хэрэгтэй байна!” гэж чи хариулна.

Сонголт Б: Чи тэр даруй дүү нараа цуглахад нь тусалж, залбирал, дуу болон захиаст баяртайгаар оролцоно.

Санваарын удирдлага гэрт байгаа үед

Гэр бүлийн үдэш, гэр бүлийн залбирал болон гэр бүлээрээ судар судлахад идэвхтэй оролцох замаар эцэг, эхээ дэмжих нь танай гэр дэх санваарын удирдлагыг хүчирхэгжүүлэх нэг арга зам мөн. Мөн доор дурдсан бусад арга замууд байдаг:

- Аав, ээжийнхээ төлөө залбир. (Тэд ч бас мэдээж, өдөр бүр чиний төлөө залбирдаг.)
- Аав, ээжийгээ сүмийн дуудлагуудад нь дэмжиж, ялангуяа тэд онцгой ажил үүрэг гүйцэтгэж, завгүй байгаа үед нь гэр орныхоо ажилд туслахыг санал болгож бай.
- Гэрийн багш нарыг ирэхэд тэднийг баяртайгаар угтаж авахад нь эцэг, эхдээ туслахын хамт тэдний захиасыг анхааралтай сонсож бай.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СУДИ МАККОЛУМ

- Хэрэв танай бүсэд ариун сүм байдаг бол эцэг, эх тань ариун сүмд орж, санваарын ёслолуудад оролцох үеэр дүү нараа харахыг санал болго.

Танай гэр оронд Сүнсийг урих болон хамт байлгах үүрэг хариуцлага нь зөвхөн эцэг, эхийнх чинь биш гэдгийг сана. Өөрийн үйлдэл, зан харьцаагаар дамжуулан Сүнсийг урихын тулд чиний хийж болох маш их зүйл бий. Гэр орондоо Сүнсний нөлөөг урихын тулд чи өөрийн үүргийг биелүүлдэг үү?

Санваарын удирдлага гэр оронд байхгүй үед

Гэр бүлүүд бүгд адилхан байдаггүй эсвэс яг адил байдлаар үүргээ биелүүлдэггүй. Чи эцэг юм уу эхийнх нь аль нэг нь л байдаг гэр бүлд эсвэл гэр орныг чинь тэргүүлэх санваартан байдаггүй гэр бүлд амьдардаг байж болно. Гэсэн ч өөрийгөө болон гэр бүлээ хүчирхэгжүүлэхийн тулд санваарын хүчийг урих олон арга зам бий. Бид бүгд өөрсдийн нөхцөл байдлаас үл хамааран дараах зүйлсийг хийх хэрэгтэй:

- Хувиараа залбирч, судраас судлан, мацаг барьж бай. Эдгээр хичээл зүтгэл нь сүнслэг байдлын хувьд хүчирхэг болоход тань мөн Сүнсийг өөрийн амьдралд болон өөрийнхөө нөлөөлдөг зүйлсэд урихад тань туслах болно.
- Дуудлагаа эсвэл сүмийн ажил үүргээ эрхэмлэн биелүүлэхэд цаг гаргаж, ням гаргийн хичээлүүдэд бэлтгэлтэй бай. Ингэх нь чамд өөртөө итгэлтэй байхад чинь тусалж, санваарын хөтөлбөрүүдийг дэмждэгийг чинь харуулах болно.
- Гэр бүлийнхээ бүх гишүүдийг хүндэлж, тэдний үр өгөөжтэй үйл ажиллагаануудыг дэмж. Эдгээр сонголтууд гэр бүлийг чинь хүчирхэгжүүлэхэд тусална.
- Сүмийн хичээлүүдээс болон чуулгуудаас сурсан зүйлээ гэр бүлтэйгээ хуваалцаж, амьдралд хэрэгжүүл. Энэ бол сайн мэдээний сургаалуудыг гэр орондоо авчрах нэг арга зам мөн.
- Өөрийн нинжин сэтгэлийн энгийн үйлдлүүдээр дамжуулан эргэн тойрныхоо хүмүүст үйлчлэх арга замуудыг ол.
- Гэрийн ажлаа хийхэд эсвэс ах, эгч, дүү нартаа тусал.
- Гэрийнхэндээ Христийнхтэй адил хайрыг үзүүл. Энэ нь чиний хийж чадах өөр ямар ч зүйлээс илүүгээр хүчирхэг гэр бүлийг төлөвшүүлэхэд чухал нөлөө үзүүлэх болно.

Гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандах нь

Бид гэр бүлдээ үйлчилж, гэр бүлээ хайрлан, хүчирхэгжүүлснээр Есүс Христийн гэрчлэгч байж, түүний зарлигуудыг сахин, эргэн тойрныхоо хүмүүсийг хүчирхэгжүүлэхээр баптисмынхаа үеэр хийсэн гэрээнүүддээ үнэнч байдаг. Бид гэр орон, гэр бүлдээ адислал байж, гэр бүлийнхэндээ туслахын тулд санваарын хүч чадалд тулгуурлаж болно. *Санваар, үйлчлэл, гэр орон* гэдэг үгс бидний оюун санаанд мөнхөд холбоотой байх ёстой. Бид авралын ажилд оролцох арга замуудыг эрж хайхдаа гэр бүлийн гишүүдээ нэгдүгээрт тавих ёстой. Бид гэр бүлээ хүчирхэгжүүлснээр сүмээ, нийгэм хамт олноо мөн дэлхийг хүчирхэгжүүлдэг. ■

"Гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг."

"Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг," *Лиахона*, 2010 оны 11-р сар, 129.

"Таны хийх Их Эзэний хамгийн чухал ажил гэр оронд тань байх болно."

***Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Харолд Б.Лий* (2000), 134.**

ЗОХИСТОЙ БАЙДЛААС
ИРДЭГ ИТГЭЛ ҮНЭМШИЛ

Би нэгэн төрлийн онцгой итгэл үнэмшлийг хэрхэн олж авах талаар зориуд ярихыг хүсэж байна.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын **ахлагч Жэффри Р.Холланд**

Миний захиас та нарт одоо төдийгүй насан туршид тань найдвар ба урам зориг өгөх болно. Дэлхий дээр хангалттай олон асуудал байгаа бөгөөд бүхий л цаг үед түвэгтэй асуудлууд үргэлж байсаар ирсэн юм. Тэдгээрийн талаар сэтгэл түгшин зовох юм уу санаагаар унах хэрэггүй. Ирэх он жилүүд гайхалтай боломжуудаар болон агуу адислалуудаар дүүрэн байх болно. Бидний амьдралыг баялаг агуулгатай болгодог шинжлэх ухаан, технологи, эрүүл мэнд ба харилцаа холбоо зэрэг бүх салбаруудад дэвшил гарсаар байх болно. Та нар энэ дэлхийн хамгийн агуу цаг үед амьдарч байгаа бөгөөд түүхийн аль ч үед байгаагүй илүү олон адислал дэлхий даяар улам олон хүнд ирсээр байна. Таны эмээ та нарын насан дээр цахим таблетын талаар ямар ч төсөөлөлгүй байсныг, өвөө тань мессеж яаж бичиж, илгээхийг одоо болтол мэддэггүйг санаарай. Тиймээс аз жаргалтай, эрүүл энх, өөдрөг өрнүүн байцгаа.

Миний саяхан уншсан нэгэн өгүүлэлд өнөөгийн залуу хүмүүсийн дунд хамгийн түгээмэл тохиолддог өвчин бол чихрийн шижин юм уу зүрхний өвчин эсвэл хорт хавдар биш хэмээн өгүүлсэн байв. (Эдгээр өвчнүүд та нарт бус, харин миний насны хүмүүст тохиолддог юм.) Харин өсвөр үеийнхэнд болон 20 дөнгөж гарсан залууст хамгийн их тохиолддог өвчин бол өөртөө эргэлзэх, ирээдүйгээсээ айх болон өөрийгөө дутуу үнэлэх мөн өөртөө болон хүрээлэн буй орчиндоо итгэлгүй хандах явдал мөн хэмээн тэмдэглэсэн байлаа.

Би хэдийгээр та нараас насаар ахмад боловч эдгээр санаа зовоосон зүйлүүдийг ойлгодог шүү. Учир нь би залуу байхдаа олон ч нөхцөл байдалд өөртөө итгэх итгэл муутай байдаг байсан. Надад сайн дүн авч тэтгэлгээр сурах найдлага байсан ч бусад хүмүүс энэ тал дээр яагаад илүү амжилттай байдаг юм бол хэмээн гайхдаг байснаа санаж байна. Олон жилийн турш ахлах болон их сургуулийн спортын тэмцээнүүдэд оролцож, амжилтад хүрэхийн тулд итгэлтэйгээр тоглож, шийдвэрлэх тоглолтуудад ялалт байгуулахыг эсвэл өдрийн бодол, шөнийн зүүд болсон цомыг багтаа авчрахыг юу юунаас илүү их хүсдэг байснаа би санаж байна. Ялангуяа охидын тухайд өөртөө итгэлтэй байж чаддаггүй байснаа мөн санадаг. Энэ нь залуу эрэгтэйчүүдийн санааг багагүй зовоодог зүйл юм. Холланд эгч надад боломж олгосонд би маш их талархалтай байна. Тийм ээ, би та нарын санаж буй бүх зүйлийг—өөрийнхөө гадаад төрхөнд сэтгэл хангалуун бус байх болон бусдаар хүлээн

зөвшөөрөгдөх эсвэл ирээдүй надад зориулж юу бэлтгэсэн бол гэх мэтийн зүйлсэд эргэлздэг байснаа санаж байна.

Залуу хүнд эргэлзээ болоод өөртөө үл итгэх байдлыг авчирдаг бүх асуудлыг ярих нь миний зорилго биш, харин бидний амьдралын бүх л талуудад, ялангуяа өөрийгөө үнэлэх бидний үнэлэмжид мөн ирээдүйг угтан харах бидний үзэл бодолд гайхамшгуудыг бүтээж, өөртөө итгэлтэй болгож чаддаг нэгэн онцгой итгэл үнэмшлийн тухай ярихыг би хүсч байна. Үүнийг тайлбарлахын тулд би нэгэн түүх ярья.

Хувийн зохистой байдлын үнэ цэнэ

Олон жилийн өмнө би ерөнхий эрх мэдэлтнээр дуудагдахаасаа өмнө залуучуудын нэгэн чуулганд оролцож, үг хэлж билээ. Уг чуулган гэрчлэлийн цуглаанаар өндөрлөв. Энэ үеэр нэгэн царайлаг, залуухан буцаж ирсэн номлогч гэрчлэлээ хуваалцахаар бослоо. Тэрээр буцаж ирсэн номлогч ямархуу харагддаг билээ—тийм л царайлаг, цэвэр цэмцгэр, өөртөө итгэлтэй харагдаж байлаа.

Ярьж эхлэнгүүт түүний нүдэнд нулимс цийлэгнэж, гайхалтай сайн хожмын үеийн гэгээнтэн залуусын бүлэгт байсандаа талархаж, тэр үеийн амьдралдаа сэтгэл хангалуун явдгаа хэлсэн юм. Гэвч энэхүү мэдрэмж нь хэдэн жилийн өмнө түүнд тохиолдсон нэгэн туршлагаар, амьдралыг нь үүрд мөнхөд өөрчилсөн тэрхүү үйл явдлын ачаар түүнд ирсэн байна.

Тэгээд тэрээр 18 настайдаа, ахлагчийн албанд томилогдоод удаагүй байхдаа нэгэн болзоонд яваад ирсэн тухайгаа ярилаа. Энэ болзооны үеэр тийм ч таатай бус нэг явдал болсон байна. Тэрээр үүнийг дэлгэрэнгүй яриагүй бөгөөд олны өмнө тийнхүү ярих хэрэг ч байгаагүй юм. Тэр үед яг юу болсныг би өнөөг хүртэл мэдээгүй ч энэ нь түүний сүнсэнд болон өөрийгөө үнэлэх үнэлэмжид нь хүчтэй нөлөөлсөн зүйл байсан нь тодорхой юм.

Тэрээр гэрийнхээ урд талын зам дээр машин дотроо сууж, болсон явдлыг эргэцүүлэн бодоод хийсэн зүйлийнхээ төлөө жинхэнэ харууслыг мэдэрч байтал сүмийн гишүүн бус ээж нь гэрээсээ маш их сандарсан байдалтай гарч, машин руу нь гүйж ирээд эрэгтэй дүү нь гэртээ унахдаа толгойгоороо ямар нэг юм хүчтэй мөргөж, ухаан алдсан тухай хэлжээ. Гишүүн бус аав нь тэр даруй түргэн тусламж дуудсан байсан ч хараахан ирээгүй л байв.

“Ирээд ямар нэгэн юм хийгээч дээ. Танай сүмд ийм үед хийдэг зүйл байдаггүй юм уу? Чамд тэдний санваар байгаа шүү дээ. Орж ирээд ямар нэг юм хийгээч” гэж ээж нь хашгирчээ.

Ээж нь тэр үед сүмийн тухай тийм их зүйл мэддэггүй ч харин санваарын адислалуудын талаар бага сага мэддэг байжээ. Гэвч хайртай хүнд нь өөрийнх нь итгэл,

Тэрээр гэрийнхээ урд талын зам дээр машин дотроо сууж, болсон явдлыг эргэцүүлэн бодоод хийсэн зүйлийнхээ төлөө жинхэнэ харууслыг мэдэрч байтал сүмийн гишүүн бус ээж нь гэрээсээ маш их сандарсан байдалтай гарч, машин руу нь гүйж ирэв.

"Би тэр шөнөөс хойш өөртөө итгэлтэйгээр Их Эзэнд хандахад мөн хэрэгтэй үед Түүний тусламжийг авахад саад болох ямар ч зүйлийг хийгээгүй" гэж тэр хэлэв.

хүч нөлөө хэрэгтэй болчихоод байхад сайхь залуу яаж ч чадсангүй. Тэрээр өөрт нь төрсөн таагүй мэдрэмж болон үйлдсэн буруу зүйлийнхээ улмаас Их Эзэнд хандаж, хэрэгтэй байгаа адислалыг гуйх боломжгүй болсон байлаа.

Залуу машинаасаа үсрэн гараад хоёр, гурван жилийн өмнө баптисм хүртсэнээс хойш өөртэй нь нөхөрлөж ирсэн тойргийнхоо нэгэн зохистой, ахимаг насны эрийн гэр рүү гүйсэн ажээ. Залуу юу болсныг тайлбарласнаар нөгөөх хүн түргэн тусламж ирэхээс өмнө түүнтэй хамт тэднийд иржээ. Гэрчлэлийн цуглаан дээр яригдсан энэхүү түүхийн төгсгөл тун сайхан болсон бөгөөд настай эр тэр даруй санваарын гайхалтай, хүчтэй адислалыг өгч, бэртсэн хүүхдийн биеийг хэвийн байдалд оруулж, амраагаад явсан байна. Эмнэлэгт очиж, бүрэн үзлэг хийсний дараа ямар нэг ноцтой гэмтэл бэртэлт байхгүйг тогтоожээ. Уг гэр бүлийн хувьд тэднийг сандаргасан айдастай үе ийнхүү өнгөрсөн юм.

Миний ярьж буй буцаж ирсэн номлогч залуу: "Тэр орой надад тохиолдсон зүйлийг биеэр амсаагүй ямар ч хүн миний мэдэрсэн ичгүүрийг болон зохисгүй байдлаасаа болж санваараа ашиглаж чадахгүйд хүрсэн харуслыг минь хэзээ ч ойлгохгүй. Миний эрэгтэй дүүд мөн айж тэвдэн, надаас ихийг хүсэн хүлээх сүмийн гишүүн бус аав, ээж хоёрт маань гагцхүү миний тусламж хэрэгтэй байсан учраас л энэ нь надад сэтгэлийн илүү их шаналгаатай дурсамж болон үлдсэн юм. Гэвч би өнөөдөр та нарын өмнө зогсох энэхэн мөчид та бүхэнд нэг л зүйлийг амлаж чадна. Би төгс биш боловч тэр өдрөөс хойш өөртөө итгэлтэйгээр Их Эзэнд хандахад мөн хэрэгтэй үед Түүний тусламжийг авахад саад болох ямар ч зүйлийг хийгээгүй. Хувийн зохистой байдал бол бидний амьдардаг энэ дэлхий дээрх тулаан бөгөөд би энэ тулаанд ялж байна. Би өөрийн үйлдсэн гэм буруугийн мэдрэмжийг амьдралдаа нэг л удаа мэдэрсэн бөгөөд үүнийг дахин хэзээ ч мэдрэхгүйн тулд ямар ч зүйлийг хийх болно. Би энэ тал дээр *бүх зүйлийг* хийж чадна" хэмээн хэлсэн юм.

Тэр гэрчлэлээ хуваалцаж дуусаад суув. Түүний дүр төрх одоо ч надад харагдсаар байна. Бидний орчин ямар уур амьсгалтай болсон байсныг ч бас санаж байна. Түүнийг үг хэлсний дараа өрөөнд нам гүм болж, тэнд байсан бүх хүн дотроо илүү ихийг эргэцүүлж, Их Эзэнээр өгөгдсөн дараах хүчирхэг үгсийн дагуу амьдрах илүү шийдвэр төгс болсон байсныг би санаж байна:

"Бодол санааг чинь ариун журам зогсолтгүй чимэн гоёг, *тийнхүү итгэлтэй байдал чинь Бурханы оршихуйд хүчтэй болох болно,* мөн санваарын номлол тэнгэрээс буух шүүдэр лугаа адил чиний сүнсэн дээр намуухан буух болно.

Ариун Сүнс чиний байнгын хамтрагч мөн чиний очирт таяг, зөв шударга ёс хийгээд үнэний хувиршгүй очирт таяг байх болно" (С ба Г 121:45–46; налуу бичлэг нэмэгдсэн).

Бурханы Сүнсийг мэдрэх нь

Хайрт залуу найз нар минь, гайхалтай сайхан амьдарцгаа. Хамгийн сайн зүйлийг бодож, хамгийн сайхан зүйлд найдаж, ирээдүйдээ итгэж амьдарцгаа. Та нарыг агуу амьдрал хүлээж байна. Тэнгэрлэг Эцэг тань та нарт хайртай. Хэрэв та нар ямар нэгэн алдаа гаргасан бол яг дээрх залууд тохиолдсоны адил алдаагаа наманчилснаар уучлагдаж чадна. Та бүхэнд амьдралаас хүсэн хүлээх, найдах бас итгэх зүйл их байна. Ухамсрын амар амгаланг мэдрүүлэх дурсамжуудтай байх нь Бурханы Сүнсийг нэн хувийн арга замаар мэдрэх боломжийг бидэнд олгодог. Би та нарыг тэрхүү Сүнсийг мэдэрч, Бурханы оршихуйд тэрхүү итгэлтэй байдлыг үргэлж мэдрээсэй хэмээн хүсч байна. Сайн сайхан бодлууд бидний үйлдлүүдийг өнөөдөр, маргааш болон үүрд цэвэр ариун байлгах болтугай. ■

2006 оны 12 дугаар сарын 31-нд болсон өсвөр үеийнхэнд зориулсан галын дэргэдэх ярилцлага дээр хэлсэн үгээс.

ХААЛГА ба ЗАМ

Санваарын ёслолууд болон гэрээнүүд биднийг мөнх амьдралын зам дээр гаргаж, яг одоо бидэнд хэрэгтэй байгаа хүч чадлаар биднийг адисалдаг.

Бид бүгд мөнх амьдралыг эрэлхийлдэг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, бид Тэнгэрлэг Эцэгийнхээ дэргэд гэр бүлтэйгээ амьдарч чадах селестиел хаант улсын хамгийн дээд зэрэглэлд аврагдаж, өргөмжлөгдөх болно гэсэн үг.

Нэмж хэлэхэд, Есүс Христэд итгэх итгэл, наманчлал мөн санваарын ёслолууд болон гэрээнүүд нь мөнх амьдрал өөд хөтөлдөг зам дээр гарах боломжийг бидэнд олгодог. Та сүмийн гэр бүлд төрсөн юм уу хожим хөрвөсөн эсвэл та бүх амьдралынхаа туршид идэвхтэй байгаа эсэх мөн сүмийн үйл ажиллагаанд саяхан эргэж ирсэн эсвэл таны энэ зам дээр хэзээ гарсан болон одоо энэ зам дээр хаана байгаа тань хамаагүй бөгөөд харин та гэрээнүүддээ болон тэдгээрийг хүлээн авч сахихад анхаарлаа төвлөрүүлбэл замын дагуу өсч хөгжиж чадна.

Санваарын ёслолууд болон гэрээнүүд нь зөвхөн алдар суут ирээдүйн амлалтыг санал болгодоггүйг мэдэх нь чухал юм. Эдгээр нь замыг дагаж, зөв шударга байдалд эцсээ хүртэл тэвчихийн тулд яг одоо бидэнд хэрэгтэй байгаа хүч чадал, тайтгарал ба дэмжлэгийг өгдөг. ■

МӨНХ АМЬДРАЛ ӨӨД ХӨТӨЛДӨГ ЗАМ (ЭЦСЭЭ ХҮРТЭЛ ТЭВЧИХ)

2 Нифай 31-р бүлгийг үзнэ үү

БАПТИСМ

Бид ариун ёслолоор баптисмын гэрээгээ долоо хоног бүр шинэчилдэг

АРИУН СҮНСНИЙ БЭЛЭГ

"Сүм дэх санваарын эрх мэдлээр **гэр бүлүүдийг хамтад нь** холбож, бидний хүн нэг бүрийг селестиел хаант улсад **Бурхан Эцэг, Есүс Христ хоёрт эргэж очиход** тэнцэхүйц болоход шаардлагатай ариун нандин ёслолууд болон гэрээнүүдийг хийдэг. Эдгээр ёслолууд нь Их Эзэнтэй хийдэг гэрээнүүд учраас амар амгаланг авчирдаг билээ."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Квинтин Л.Кук, "Хувь хүний амар амгалан: зөв шударга байдлын шагнал," *Лиахона*, 2013 оны 5-р сар, 34.

АМИН ЧУХАЛ ЁСЛОЛУУД БА ГЭРЭЭНҮҮД

ШИНЭЧЛЭГЧ БА ХҮЧИРХЭГЖҮҮЛЭГЧ ЁСЛОЛУУД

Патриархын адислал бол хувь хүнд зориулсан удирдамж ба амлагдсан адислалууд мөн.



САНВААР ХҮРТЭЭХ БОЛОН САНВААРТ ТОМИЛОХ НЬ (ЗАЛУУ ЭРЭГТЭЙЧҮҮДЭД)

АРИУН СҮМИЙН ХИШИГ

Өвчтөнд өгдөг адислалууд—тусламж ба эдгээлт

Хэрэгцээтэй үед өгдөг Эцэгийн адислалууд мөн тайтгарлын бусад адислалууд ба зөвлөгөө

ЗАМЫН ДАГУУХ ТУСЛАМЖУУД

Судрууд—Бурхан болон Түүний хүмүүсийн хоорондбайгуулсан гэрээний хэсэг болж хүлээн авагдсан удирдамж ба заавар юм (С ба Г 84:57-г үзнэ үү)

Залбирал—"[Их Эзэн] бидэнд 'үргэлж Түүнийг санах гэрээг санал болгож, бид Түүнд итгэл найдвараа тавих нь бидний цорын ганц аюулгүй байдал учраас 'үргэлж залбирч байхыг' анхааруулсан юм" (Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, "Always (Үргэлж)," *Ensign*, 1999 оны 10-р сар, 9-р хуудас).

Үйлчлэл—бид Бурханд болон Түүний хүүхдүүдэд үйлчилснээр, түүний дотор дуудлагуудаа биелүүлж, ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажил хийснээр, сайн мэдээг хуваалцаж, бүрэн цагийн номлолын үйлчлэл хийснээр гэрээнүүдээ биелүүлж байгаа явдал мөн

Наманчлал—бид зөв замаас гажсан үед заримдаа санваарын удирдагчдаас тусламж аван гэрээнүүдээ санаж, Аврагчид улам ойртох үйл явц мөн



АРИУН СҮМИЙН ЛАЦДАН ХОЛБОЛТ

"Сайн мэдээний гэрээ, зарлигууд болон ёслолуудын зам дээр байх нь биднийг **хамгаалж** мөн энэ дэлхийд Бурханы ажлыг хийхэд биднийг **бэлтгэдэг**."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Робэрт Д.Хэйлс, "Ариун газруудад бат зогсоцгооё," *Лиахона*, 2013 оны 5-р сар, 49.

" Та нар санваарын ёслолуудад зохистой оролцох үед Их Эзэн та нарт агуу **хүч чадал, амар амгалан болон мөнх амьдралын найдварыг өгөх болно."**

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн, "Санваар дахь хүч," *Лиахона*, 2013 оны 11-р сар, 95.

МӨНХ АМЬДРАЛ (ГЭР БҮЛҮҮД БҮХИЙ СЕЛЕСТИЕЛ ХААНТ УЛС)

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ БРАЙН БИЙЧ

“Сайн мэдээний сургаалуудад харшилдаг үр хөндөх гэх мэт сэдэв сургууль дээр яригдвал би юу хэлэх хэрэгтэй вэ?”

Тухайн нөхцөл байдлаас хамаараад хариулах эсвэл хариулахгүй байх олон арга зам байдаг. Нэгдүгээрт, ямар нэг зүйл хэлбэл эсвэл хэлэхгүй бол юу болохыг сайтар бод. Хэрэв чи юу ч хэлэхгүй бол энэ нь буруу гэдэг нь өөрийн чинь мэдэх ямар нэг зүйлийг хүлээн зөвшөөрч байна гэж бусдыг бодоход хүргэхээр байвал зөвшөөрөхгүй байгаагаа мэдэгдэх энгийн ямар нэг арга замыг олох хэрэгтэй. Хэрэв өөрийн чинь тайлбар гагцхүү маргаанд хүргэхээр байвал санаа бодлоо илэрхийлэх өөр тохиолдлыг олж болно. Гэхдээ, хэрэв танай ангийнхан бие биедээ хүндэтгэлтэй ханддаг бөгөөд багш чинь санаа бодлоо хэлэхийг чамаас хүссэн бол чи сүнсний удирдамжийн төлөө залбирч, итгэл бишрэлийнхээ тухай тайлбарлаж болно.

Хэрэв танай анги аль нэг сэдвээр ярилцлага хийх гэж байгааг мэдвэл чи урьдаас бэлтгэж болно. Уг сэдвээр судруудыг болон Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг мөн *Итгэлдээ үнэнч байх нь, Сайн мэдээний зарчмууд* эсвэл *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлуудыг үз. Чи бас гэр бүлийн үдшээр уг сэдвийг тайлбарлах дадлага хийж болно. Тэгээд бэлэн болсон үедээ багшдаа эсвэл ангийнхандаа ярь.

Хэрхэн хариулах нь *юу* гэж хэлснээс чинь дутахгүй чухал юм. Хүндэтгэлтэй байж, сүмийн үг хэллэгийг хэрэглэхгүй байхыг хичээ. “Манай тойргийн Залуу эмэгтэйчүүдийн зөвлөгч надад заахдаа . . .” гэж чамайг хэлэнгүүт ангийнхан чинь чиний үгсийг ойлгохоо больж эхэлнэ.

Өөрийн чинь хувьд хамгийн чухал зүйл гэвэл ангидаа сонсох эсвэл уншиж болох алдаатай зүйлсэд мэхлэгдэхгүйн тулд сүмийн заадаг зүйлсийг болон Ариун Сүнс өөрт чинь юу хэлж байгааг мэдэх явдал мөн.

Буруу сургаалыг залруул

Бид бол номлолын ажлыг хөхиүлэн дэмждэг бөгөөд номлохоор дуудагддаг сүмийн гишүүд билээ. Тиймээс бид буруу сургаал дэлгэрэхийг хүлээн зөвшөөрч болохгүй. Ийм нөхцөлд бид аливаа буруу сургаалыг залруулахын тулд саналаа илэрхийлж, ярилцаж буй сэдвээрх сэргээгдсэн сайн мэдээний үзэл баримтлалыг ойлгоход нь хүмүүст туслах ёстой.

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс, Касай-Оксидэнтэл муж, Дэвид М., нас 16

Эелдэг бай

Бодол санаагаа эелдэг байдлаар хуваалцахын хамт яагаад үүнд итгэдгээ нотлох ёстой гэж би боддог. Бусад хүмүүс надтай санал нийлэх албагүй, харин тэд аль нэг сэдвээр миний юунд итгэдгийг мөн үзэл бодлыг минь ойлгох хэрэгтэй гэж би боддог.

АНУ, Орегон, Сабрина С., нас 16

Бусдад хүндэтгэлтэй ханд

Бидний санаа бодлыг бусад хүмүүс сонсох нь чухал ч гэсэн бид бас бусдын итгэл бишрэлд хүндэтгэлтэй хандах нь туйлын чухал юм. Бусадтай бүү марга. Маргах нь дайсагнал ба үл ойлголцлыг бий болгоно. Хэрэв манай шашны эсрэг бодол санаа гарч ирвэл тайван, хүндэтгэлтэй байж, сайтар эргэцүүлэн бод. Мөн Сүнсийг сонсохоо бүү март. Бид ойлгодоггүй, харин Бурхан ойлгодог зүйлс байдаг. Бид Түүний Сүнсийг анхааралтай сонсож, түүнээс суралцах хэрэгтэй.

АНУ, Юта, Ханна М., нас 18

Эдгээр хариултууд нь тусламж болон ойлголтуудыг өгөх зорилготой бөгөөд сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.

Сүмийн заадаг зүйлсийн талаар хуваалц

Би ийм асуултуудад чадлынхаа хэрээр хамгийн сайн хариулахыг хичээдэг. Яагаад гэвэл, хэрэв би тэдэнд хэлж өгөхгүй бол найз нар маань, бас манай багш нар тухайн сэдвээрх сүмийн байр суурийг мэдэхгүй шүү дээ. Тэд цаашдаа манай сүмийн тухай мэддэг болж, үүний ачаар чиний сүнслэг байдал өсөн нэмэгдэнэ. "Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, Тэнгэр дэх Эцэгийг тань алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг" (Матай 5:16) хэмээн сударт өгүүлснийг санагтун.

Англи, Манчестер, Жошуа М., нас 16

Юу зөв болох талаар бодоход нь бусдад тусал

Санаа бодлоо хуваалцахад шударга бай. Үр хөндөлт гэх мэт олон сэдвийг сургууль дээр өргөн хүрээнд ярилцдаг. Тиймээс санаа бодлоо хэлэхдээ ичиж зовох хэрэггүй. Энэ бол бидний хувьд сайн мэдээг болон өөрсдийн итгэдэг жишгүүдийг хуваалцах сайхан боломж юм. Хэрэв чи итгэл бишрэлийнхээ талаар хуваалцвал юу зөв болохыг бодоход нь хүмүүст тусалж чадна.

Умард Каролин, Мэдисон Р., нас 14

Хэнийг төлөөлдгөө сана

Эдгээр нөхцөлүүдэд бусад хүмүүсийн ярилцаж байгаа сэдвээр өөртэй чинь адил үзэл бодолтой байх албагүйг санахыг хичээ. Ихэрхэг эсвэл албадан тулгах байдалтай байж болохгүй ч итгэл бишрэлээ хамгаалахаас бүү ай. Чи Христийг төлөөлдгөө сана.

АНУ, Вайоминг, Мэйдлин К., нас 16

Сүмийн байр суурийг мэддэг бай

Зөрчилтэй сэдвүүдээр ярилцсан нөхцөл байдал надад олон удаа тохиолдсон. Ийм үед юуны түрүүнд бусдын итгэл бишрэлд хүндэтгэлтэй хандах ёстой байдаг. Ангийнхан чинь чамд хүндэтгэлтэй хандахыг чи ч гэсэн хүсдэг шүү дээ. Хэрэв ярианы сэдэв сүмтэй шууд зөрчилдөөгүй бол санаа бодлоо чөлөөтэй хэл. Хариултдаа сүмийг дурдах шаардлагагүй. Гэсэн хэдий ч ярилцаж байгаа асуудлаарх сүмийн байр суурийг мэддэг байхад анхаар.

АНУ, Мэрилэнд, Жозэф З., нас 18

Маргаанаас зайлсхий

Би өөрийн дагадаг сүмийн зарчмуудыг болон сургаалуудыг хамгаалан, бусдын санаа бодолд хүндэтгэлтэйгээр хандаж, өөрийн бодол санааг тайлбарлах болно. Би маргалдахгүй, яагаад гэвэл энэ нь Сүнсийг холдуулдаг. Сүнс нь бусдад эерэг арга замаар нөлөөлж чадна.

Аргентин, Буэнос Айрэс, Дайэна В., нас 15

ГУЙВШГҮЙ БАТ БӨХ БАЙ

"Учир шалтгаан, нөхөрсгөөр итгүүлэх болон үнэн зөв мэдээ баримтаар дамжуулан байр суурыа тайлбарлах нь бидний үүрэг мөн. Өнөө үеийн ёс суртахууны асуудлууд болон сайн мэдээний мөнхийн зарчмуудын талаар гуйвшгүй бат бөх, чанд хатуу байх боловч хүмүүс, байгууллагатай маргахгүй байх нь бидний үүрэг мөн. Маргаан хүмүүсийн хооронд хана хэрэм босгож, саад бэрхшээл учруулдаг. Хүмүүс бие биетэйгээ илэн далангүй харилцаж, сэтгэлээ нээхэд хайр тусалдаг."

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Марвин Ж.Аштон (1915–1994), "No Time for Contention (Зөрчилдөх цаг байхгүй)," *Ensign,* 1978 оны 5-р сар, 8.

ДАРААГИЙН АСУУЛТ

"Би өөртөө тохиолдсон асуудал болон санаа зовоосон зүйлийнхээ талаар бишоптойгоо ярилцахын тулд хэрхэн тайван байж болох вэ?"

Хариултаа, хэрэв хүсвэл өндөр нягтшилтай гэрэл зургийн хамт 2014 оны 5-р сарын 15-ны дотор liahona@ldschurch.org-аар эсвэл шуудангаар илгээнэ үү (хаягийг 3-р хуудсаас үзнэ үү).

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.

Имэйл юм уу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог эсвэл салбар, (4) гадас эсвэл дүүрэг, (5) таны хариултыг болон гэрэл зургаа нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр гаргасан өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг, эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (имэйл байж болно).

НЯМ ГАРГИЙН ХИЧЭЭЛҮҮД

Энэ сарын сэдэв:
Урвалт ба сэргээлт

ЗӨВ ҮҮ, БУРУУ юу?

Зарим үед алдаанаасаа үнэнийг мэдэх нь хэцүү ч Бурханы үнэнийг Сатаны худал хуурмаг зүйлээс ялган танихад туслах хүчирхэг бэлгийг Тэнгэрлэг Эцэг бидэнд өгсөн юм.

Дэвид А.Эдвардс
Сүмийн сэтгүүлүүд

Хэрэв та зөв үү, буруу юу гэсэн асуултад хариулах сорилго өмнө нь хийж байсан бол зарим үед худал хуурмаг зүйлийг ялган таних нь хэцүү байдгийг мэднэ. Үүн лүгээ адил итгэл бишрэлийн болон өдөр тутмын амьдралын томоохон асуудлуудад юу нь зөв, юу нь буруу болохыг ялган таних чадвартай байх нь туйлын чухал юм. Гэтэл энэ нь үргэлж амар хялбар байдаггүй.

Гэвч бид бэлтгэгдээгүй сорилго өгөгчид шиг айх хэрэггүй. Тэнгэрлэг Эцэг маань Түүний үнэнүүдийг дайсны худал хуурмаг зүйлсээс ялган танихад туслах олон бэлгээр биднийг адисалсан билээ.

Янз бүрийн худал хуурмаг зүйлс

Нэгдүгээрт, зөвөөс бурууг ялган таних бяцхан тааврыг таацгаана уу:

1

Сар ногоон өнгөтэй.

○ ЗӨВ ○ БУРУУ

2

Саран дээр хөл тавьсан анхны хүн, Аполлон 12 сансрын хөлгийн нисгэгч Нийл Армстронг энэхүү үйл явдлыг "хүн төрөлхтний аварга үсрэлт" хэмээн нэрлэжээ.

○ ЗӨВ ○ БУРУУ

3 АНУ-ын Үндэсний агаарын ба сансрын нислэгийн газрын (НАСА) хөтөлбөрөөр 1969 онд Ангараг гарагт хүрч чадаагүйн улмаас тэд саран дээр буусан юм.

○ ЗӨВ ○ БУРУУ

4 Нарны салхи, цацраг туяа, сансрын цацраг туяа болон бусад саад тотгор нь саран дээр хүн буухыг боломжгүй болгодгоос гадна сарны гадаргын гэрэл зургууд өөрчлөгддөг бөгөөд анхдагч эх сурвалжийн зарим нарийн мэдээ баримт зөрчилтэй байгаа учраас АНУ-ын засгийн газар энэ асуудлыг цогцоор нь зохион байгуулах ёстой.

○ ЗӨВ ○ БУРУУ

Орчин үеийн худал хуурмаг зүйлс

Энэ нь өөрийн тань бодол санаа, итгэл бишрэл, сонголтууд болон зан авирт нөлөөлдөг зүйлстэй эсвэлс мөнхийн чухал үр дагавар бүхий зүйлстэй холбогдсон үед янз бүрийн худал хуурмаг зүйлийг өөртөө ашигтай гэж үзвэл "худал бүхний эцэг" (2 Нифай 9:9) Сатан биднийг мэхлэхийн тулд аль нэг аргаар ашиглах болно. Өнөөдөр Сатан хэрхэн залилан мэхэлдэг хийгээд бид үнэнийг үндэс болгон үүнд хэрхэн хариулж болох тухай зарим жишээг доор харуулав.

Асуулт бүрийн хариулт нь *буруу* бөгөөд эдгээр асуултууд нь та нарт тулгарч мэдэх зарим худал хуурмаг зүйлсийн үндсэн хэв шинжийг төлөөлж байгаа юм.

1 дэх асуулт нь *улаан цайм худал зүйл,* илэрхий алдаа юм. 2 дахь асуултын *зарим нь үнэн ч* заль мэх юм, учир нь энэ нь нэг эсвэл түүнээс олон үнэнийг худал зүйлтэй хольж хутгасан байна (Аполлон 12 биш, Аполлон 11—энэ чинь таныг маллаж буй хэрэг!). 3 дахь асуулт нь бас л *илэрхий худал зүйл,* эсвэлс зөвхөн хоёр хувилбар л эдгээр сонголтууд бодитой биш гэдгийг харуулж байна (жишээ нь, НАСА аль нэг газар руу сансрын нислэг хийхгүй байх шийдвэр гаргаж чадахгүй). 4 дэх асуулт нь *"учир шалтгааны" хувьд нэлээд үндэслэлтэй сонсогдож буй маргаантай асуудал болов*ч алдаатай дүгнэлт рүү хөтлөх буруу нотолгоо юм.

Энгийн худал зүйл

Хуурмаг санаа:
Порнограф бол хэвийн зүйл бөгөөд хэнд ч хор хүргэхгүй.

Энгийн худал зүйл юу руу хөтөлдөг вэ (том худал зүйл рүү):
Порнографыг эргэлзэлгүйгээр үз.

Үнэн:
Порнограф бэлгийн харьцааны талаарх бидний үзэл бодлыг мушгин гуйвуулдаг, донтуулагч нөлөөтэй, бидний сүнслэг байдалд асар их хор уршигтай бөгөөд хүмүүс хоорондын харилцааг эвдэн бусниулдаг.

Хагас үнэн

Хуурмаг санаа:
Хүн бүр давтагдашгүй өвөрмөц бөгөөд сонголтынхоо дагуу амьдарч чадна, иймээс та өөрийнхөө талаар юу гэж боддог болон өөрийгөө хэрхэн илэрхийлдэг нь таны амьдрал дахь хамгийн чухал зүйл юм.

Хуурмаг санаа юу руу хөтөлдөг вэ? (Бүр том худал зүйл рүү)
Та хэрхэн амьдрах ёстойгоо Бурханаар эсвэл сүмээр хэлүүлэх ёсгүй, иймээс хэрэв өөрт чинь л сайхан санагдвал хийхийг хүсдэг зүйлээ эргэлзэлгүйгээр хий.

Үнэн:
Бидний хүн нэг бүр Тэнгэрлэг Эцэгийн давтагдашгүй өвөрмөц хүүхэд. Тэрбээр биднийг хамгийн сайн хүн болгохын тулд чадах бүхнээ хийж, Түүнтэй адилхан болоосой гэж хүсдэг. Түүний зарлигуудад дуулгавартай байх нь төгс баяр баяслыг олж авахад бидэнд тусалдаг.

ГЭРЭЛ ЗУРГУУДЫГ ISTOCK/THINKSTOCK

Хоорондоо авцалдаагүй худал зүйлс (зөвхөн хоёр сонголт)

Хуурмаг санаа:
Сүм амьдралын тодорхой хэв маягийн эсрэг номлодог. Тиймээс сүм хүлцэн тэвчдэггүй. Сүм хүмүүсийг хайрладаггүй, харин үзэн яддаг.

Хуурмаг санаа юу руу хөтөлдөг вэ? (Бүр том худал зүйл рүү):
Сүм нь бусдыг хүлцэн тэвчдэггүй бөгөөд үзэн яддаг учраас түүнийг шүүмжлэх, доог тохуу хийх, хараан зүхэж яллах нь зүй ёсны хэрэг юм. Иймд чи түүнээс харилцаагаа таслах ёстой.

Үнэн:
Өөр хэн нэгний амьдралын хэв маягийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь үзэн ядалт ба үл тэвчих явдал биш. Бид хүн болгонд, түүний дотор амьдралын хэв маяг нь Бурханы хуулиудад харшилдаг хүмүүст өрөвч нинжин сэтгэл, хайр хүндэтгэлээр хандахын сацуу Бурхан болон Түүний зарлигуудад үнэнч байдаг билээ.

"Учир шалтгааны үндэслэлтэй" маргаан

Хуурмаг санаа:
Мормоны Номон дахь зарим зүйлийг өнөөгийн шинжлэх ухаан няцаадаг бөгөөд уг ном орчуулагдсан тухай түүх үнэнд үл нийцдэг. Иймээс Иосеф Смит үүнийг санаанаасаа зохиосон эсвэл хаа нэгтэйгээс хуулбарласан байх ёстой.

Хуурмаг санаа юу руу хөтөлдөг вэ? (Бүр том худал зүйл рүү):
Мормоны Ном худал, Иосеф Смит бошиглогч биш, иймд сүмээс харилцаагаа тасал.

Үнэн:
Мормоны Номон дахь олон зүйлийг шинжлэх ухаан нотолсон бөгөөд үүний эсрэг "нотолгоо" гэгч нь явуургүй юм. Харин үүний хамгийн чухал нотолгоо бол уг ном үнэн, Иосеф Смит үнэн бошиглогч байсан гэдгийг танд хэлж өгдөг Ариун Сүнсний гэрчлэл юм.

Үнэнийг хэрхэн мэдэх вэ?

Илүү бүрэн дүүрэн үнэнийг хаанаас олох вэ? Бид худал хуурмаг зүйлсээр хэрхэн мэхлэгдэхгүй байж болох вэ? Үнэнийг алдаанаас ялган таних нэлээд хэдэн хүчирхэг бэлгийг Тэнгэрлэг Эцэг бидэнд өгснийг доор өгүүлэв.

- ***Христийн гэрэл.*** "Христийн гэрэл . . . дэлхий даяарх зөв санаа бодолтой хүмүүст үнэнийг алдаанаас, зөвийг буруугаас ялган танихад өдөөдөг. Энэ нь таны ухамсрыг идэвхжүүлнэ."[1]
- ***Ариун Сүнс.*** "Үнэний Сүнс . . . та нарыг бүх үнэн уруу удирдана" (Иохан 16:13).
- ***Судрууд.*** "Бурхан алдаатай үзэл бодол, буруу сургаалууд болон гэм нүглийг сүйрүүлэгч үр дагаврыг нь хамт илчлэхийн тулд судрыг ашигладаг."[2] Энэ талаар Мормоны Ном онцгой ач холбогдолтой юм, учир нь энэ ном "Христийн дайснуудыг илчилж, буруу сургаалуудыг бүрмөсөн үгүйсгэж, маргаан тэмцлийг намжаадаг". (2 Нифай 3:12-ыг үзнэ үү.)"[3]
- ***Өнөө үеийн бошиглогчид.*** "[Бошиглогчийн] үүрэг хариуцлага бол Бурханы таалал хийгээд жинхэнэ зан чанарыг хүн төрөлхтөнд мэдүүлэх явдал мөн. . . . Бошиглогч нүглийг зэмлэн буруушааж, түүний үр дагаврыг угтан хэлдэг."[4]
- ***Боловсрол.*** "Тэгээнтэн хүн . . . судлахаар мөн тэрчлэн итгэлээр ялангуяа судруудыг судалснаар дамжуулан сурал-цахыг эрэлхийлдэг. (С ба Г 88:118-ыг үзнэ үү.)[5]

Дээр өгүүлсэн өөр өөр санаа-нуудтай тулгарсан үед *зөв* үү, *буруу* юу гэсэн асуултад хариулах нь үргэлж хялбар биш байж мэдэх ч энэхүү сорилгыг амжилттай давахад Тэнгэрлэг Эцэгийн танд өгсөн бэлгүүд туслах болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Ричард Г.Скотт, "Peace of Conscience and Peace of Mind," *Лиахона,* 2004 оны 11-р сар, 15.
2. Д. Тодд Кристоффэрсон, "Судрын адислал," *Лиахона,* 2010 оны 5-р сар, 33–34.
3. Эзра Тафт Бэнсон (1899–1994), "The Book of Mormon Is the Word of God," *Ensign,* 1975 оны 5-р сар, 64.
4. Судруудын удирдамж, "Бошиглогч," scriptures.lds.org.
5. Рассэлл М.Нэлсон, "Thus Shall My Church Be Called," *Ensign,* 1990 оны 5-р сар, 16.

ХАМТДАА ЯРИЛЦ

Ням гарагт тунгаан бодох зүйлс

- Тэнгэрлэг Эцэг үнэнийг танин мэдэхэд тань хэрхэн тусалсан бэ?
- Та алдааны эсрэг хэрхэн тэмцэж болох вэ?
- Үнэнийг мэдэхэд нь та бусдыг хэрхэн дэмжиж болох вэ?

Таны хийж болох зүйлс

- Сэргээгдсэн сайн мэдээ үнэн гэдэгт хэрхэн итгэсэн тухайгаа сүм дээр хуваалц.
- Аль нэг үнэний тухай болон үүнийг хэрхэн мэдсэн тухайгаа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хуваалц.

Далын ахлагч
Энрикэ Р.Фалабэлла

“Өвөө, энэ чинь маш амархан!”

“Та нар Судруудыг судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ” (Иохан 5:39).

Би Мормоны Номонд бас өөрийн Аврагч, Есүс Христэд хайртай. Нэг өдөр би саяхан уншиж сурсан ач охин Ракүэлдаа “Чи Мормоны Ном унших зорилго тавих талаар юу бодож байна вэ?” гэж асуухад

Тэр “Гэхдээ өвөө, энэ хэцүү шүү дээ. Энэ их том ном” хэмээн хариулсан юм.

Тэгээд би түүнээс надад нэг хуудас уншиж өгөхийг гуйлаа. Би секунд хэмжигч гаргаад минут харлаа. Би түүнд “Чи дөнгөж 3 минутад л уншлаа.

Бид Мормоны Номыг испани хэл дээр уншдаг бөгөөд испани хэл дээрх Мормоны Ном 642 хуудастай, тэгэхээр чамд 1926 минут хэрэгтэй юм байна” гэсэн юм.

Энэ тоо нь түүнийг бүр их айлгаж болох байсан ч би тоог 60 минутад хувааж, түүнд Мормоны Номыг уншихад дөнгөж 32 цаг хэрэгтэй юм байна гэдгийг хэлсэн юм. Энэ бол нэг өдөр хагасаас ч бага хугацаа.

Тэгэхэд ач охин маань надад “Өө, тэгвэл их амархан юм байна, өвөө!” гэж хэлж билээ.

Мормоны Номыг уншихад Рэквиэл, түүний ах Эстэбэн, манай бусад ач, зээ нарт бага зэрэг илүү хугацаа шаардлагатай байлаа. Энэ нь уг номыг унших үед залбирах болон уншсан зүйлийнхээ талаар бодоход тэдэнд цаг хэрэгтэй байснаас тэр юм.

Бид бүгд Рэквиэл, Эстэбэн нар шиг судруудад дуртай болж чадна. Тэгвэл бидний хүн нэг бүр “Таны үг амтлахад минь ямар чихэрлэг вэ? Миний аманд зөгийн балаас ч илүү чихэрлэг!” (Дуулал 119:103) хэмээн дуу алдах болно. ■

2013 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгээс.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ХЭЙМС Л. ЖОНСОН



Кэрол М.Стэфэнс
Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх

ПОРТЭРЫН

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ МАТТ СМИТ

Хадам аав маань насан өөд болоход манай гэр бүлийнхэн цугларч, хүндэтгэл үзүүлэхээр ирсэн хүмүүстэй мэндэлж байлаа. Оройжингоо би гэр бүлийнхэн болон найзуудтайгаа уулзах үедээ 10 настай ач хүү Портэр минь "грэнни" гэж дууддаг—хадам ээжийн хажууханд байхыг үе үе ажигласан юм. Заримдаа тэр ард нь зогсож, заримдаа түүнийг ажиглаад зогсож байв. Нэг удаа би түүнийг хадам ээжтэй минь хөтлөлцөн зогсож байхыг ч харсан. Мөн би түүнийг хадам ээжийн гарыг аттаж, тэвэрч мөн түүний хажууд зогсохыг нь харж байлаа.

Түүнээс хойш хэдэн өдрийн турш би уг явдлын талаар мартаж чадахгүй байлаа. Өөрийнхөө ажигласан зүйлийн талаар Портэрт захиа илгээх бодол надад төрөв. Би түүн рүү имэйл явуулж, өөрийн харж мэдэрсэн зүйлийн тухай бичсэн. Баптисмаар хийсэн **гэрээнийх нь** тухай Портэрт сануулж, Мозаягийн 18-р бүлэг дэх Алмагийн

"Та нар Бурханы хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, үүрэлцэхэд бэлэн байв;

"Тийм ээ, мөн гашуудах тэдний хамт гашуудахад; тийм ээ, тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад, мөн ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлний учир, . . . мөнх амьдралыг авч болохын тулд буюу—

". . . Хэрэв энэ нь та нарын зүрхний хүслэн байх аваас, тэр өөрийн Сүнсийг та нар дээр илүү элбэгээр юүлж болохын тулд, та нар түүнд үйлчилж мөн түүний зарлигуудыг дагана хэмээн **гэрээ** байгуулснаа түүний өмнө гэрчилж,

АМЛАЛТ

Гэрээ бол Тэнгэрлэг Эцэг та хоёрын бие биедээ өгсөн амлалт юм.

Их Эзэний нэрээр баптисм хүртэхэд юу нь та нарт болохгүй байх билээ?" гэсэн үгсээс эш татсан юм (8–10-р шүлгүүд).

Баптисм хүртэхийг хүсэж байсан тэд үргэлжид—бүх л амьдралынхаа туршид бусдад үйлчилснээр Их Эзэнд үйлчлэх хүсэлтэй байх хэрэгтэй гэж Алма тэдэнд зааж байсныг би Портэрт тайлбарласан! Тэгээд би: "Чи өөрөө мэдсэн үү, үгүй юу мэдэхгүй, гэхдээ Грэннид санаа тавьж мөн хайраа харуулсан явдал чинь **гэрээгээ** сахиж байгаа хэрэг юм шүү. Бид өдөр бүр нэг нэгэндээ найрсаг хандан, хайраа үзүүлж мөн халамжилснаар **гэрээгээ** сахидаг. **Гэрээгээ** сахигч байгаагийн чинь төлөө би чамаар бахархаж байгаагаа хэлмээр байсан юм! Баптисм хүртэхдээ хийсэн **гэрээгээ** сахих юм бол чи санваарыг хүртэх бэлтгэлтэй байх болно. Энэхүү нэмэлт **гэрээ нь** чамд бусдыг адисалж, тэдэнд үйлчлэх илүү олон боломжийг олгох бөгөөд ариун сүмийн **гэрээнд** бэлтгэхэд чинь туслах болно. Надад маш сайн үлгэр жишээ үзүүлсэнд баярлалаа! **Гэрээг** сахигч байх нь ямар байдгийг харуулсанд чинь баярлалаа!" гэж бичсэн юм.

Портэр хариуд нь "Эмээ, захиа бичсэнд баярлалаа. Би Грэннигт эврэх бүрдээ **гэрээгээ** сахиж байна гэдгээ мэдээгүй ч зүрх сэтгэлдээ халуун дулааныг мэдэрч мөн маш сайхан санагдаж байсан шүү. Энэ бол зүрх сэтгэлд минь байсан Ариун Сүнс гэдгийг би мэднэ" гэж бичсэн байлаа.

Ариун Сүнсний бэлгээр дамжин ирдэг амлалт болох "түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгана" [С ба Г 20:77] гэсэн амлалттай Портэр **гэрээ** сахихыг холбож ойлгосныг хараад би зүрх сэтгэлдээ бас халуун дулааныг мэдэрч байсан. ■

"Бидэнд баярлах агуу шалтгаан буй," Лиахона, *2013 оны 11-р сар, 115–116.*

ГЭРЭЭНҮҮДЭЭ САХИГЧ БАЙ!

Би баптисм хүртэхдээ . . .

бусдад хайраа харуулж, эелдэг байхаар,
уйтгар гунигт автсан хүмүүсийг тайтгаруулж байхаар,
Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг сахиж байхаар,
мөн Тэнгэрлэг Эцэгийн тухай бусдад ярьж
байхаар амласан юм.

Тэнгэрлэг Эцэг үүний хариуд . . .

Ариун Сүнс надтай үргэлж хамт байх болно
гэдгийг амласан юм!
Гарын үсэг,

_____

Хүүхдийн хэсгийн энэ сарын сэдвийн талаар илүү ихийг мэд!

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний төвд гэр бүл байдаг

Жан Тэйлор

Миша шоогоор цамхаг барих дуртай байлаа. Гэхдээ зарим үед шоонууд нь нурж унахад тэр уцаарлан дургүйцдэг байж. Тэгээд тэр нэгэн нууцыг мэдсэн гэнэ. Миша цамхгийнхаа сууринд аль болох олон шоо тавьснаар цамхаг нь илүү бат бөх суурьтай болжээ. Тэр тэвчээртэй байж, олон дахин дадлага хийсний эцэст амархан нурж унадаггүй цамхаг барьж сурсан юм.

Миша бат бөх цамхаг барьж сурсантай адил бид илүү хүчирхэг гэр бүлийг төлөвшүүлж чадна. Гэр бүлүүд бол бидэнд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний маш чухал хэсэг юм. Бид төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хөвгүүд, охид болон амьдарч байсан билээ. Биднийг дэлхийд ирэх болсон үед Тэр биднийг гэр бүлүүдэд ирэхээр болгосон юм. Тэр биднийг хамгаалж, бидэнд зааж сурган, Түүнд эргэж очиход нь бидэнд туслахыг гэр бүлүүдээс хүссэн юм.

Бид гэр бүлийнхээ суурийг улам хүчирхэг болгохын төлөө ажиллаж чадна. Бид бие биедээ үйлчилж мөн тусалж болно. Мөн бие биеэ анхааралтай сонсож, бие биетэйгээ эелдэг харьцаж чадна. Хамтдаа залбирч, хамт судар судалж болно. Бид хамтдаа ажиллаж, сонирхдог зүйлсээ хамтран хийж болно. Мөн бид тэвчээртэй байж, дадлага хийснээр бат бөх гэр бүлийг төлөвшүүлж чадна. ■

ДУУ БА СУДАР

- "Families Can Be Together Forever (Гэр бүлүүд үүрд хамт байж чадна)," (*Children's Songbook,* 188-р хуудас)
- Лук 6:47–49

ГЭР БҮЛЭЭРЭЭ ЯРИЛЦАХ САНААНУУД

Лук 6:47–49-ийг гэр бүлээрээ унш. Тэгээд эдгээр шүлгүүд гэр бүлийн талаар юу зааж байгааг ярилцаж болно. Сорилт бэрхшээл тулгарсан үед танай гэр бүлийнхэн бие биедээ хэрхэн тусалдаг вэ? Гэр бүлдээ илүү хүчирхэг суурь тавихын тулд чи юу хийж болох вэ?

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ЖЭННИФЭР ЭЙКЭЛБЭРГЭР

Гэр бүлийн залбирал

Хамтдаа оройн хоол идэх

Гэр бүлийн үдэш

Хамт залбирах

Гэр бүлээрээ судраас судлах

Өвчтэй хэн нэгнийг эргэж очих

Номлогчид захидал бичих

Өвөг дээдсийнхээ тухай түүхүүдийг мэдэх

ГЭР БҮЛЭЭ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ НЬ

Чи гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд туслахын тулд зурагт хуудас хийж болно!

- Насанд хүрсэн хүний туслалцаатайгаар шоонуудыг хайчилж ав. Гэр бүлийнхээ хийж хэвшсэн зүйлүүдийг харуулж байгаа шоонуудыг цаасан дээр наа. Эдгээр шоонууд танай гэр бүлийн суурийг төлөөлөх болно.
- Өөрийнхөө гэр бүлийн хийхийг хүсдэг юм уу илүү сайжруулах хэрэгтэй байгаа ямар нэг зүйлийг харуулсан өөр нэг шоог сонго. Энэ зорилгыг биелүүлсний дараа үүнийг өөрийн цамхаг дээр нэм. Хүн бүхэн харж чадах газарт зурагт хуудсыг байрлуулж, гэр бүлээ хүчирхэгжүүлэх шоонуудыг цаашид үргэлжлүүлэн нэм.

Хоосон шоонуудад өөрийнхөө санаануудаас заримыг бич.

ӨӨДРӨГ САЙХАН САНАА

Баптисм бол шавь болох аялалын эхлэх цэг мөн.

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх
2013 оны 10-р сарын Ерөнхий чуулганаас

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ СКОТТ ГРИЙР

Далын ахлагч
Тэрэнс М.Винсон

Өөрт чинь хийхэд хамгийн хэцүү ямар зүйлс байдаг вэ?

Хэцүү зүйлсийг хийхдээ чи
Тэнгэрлэг Эцэгээс хэрхэн тусламж гуйдаг вэ?

Чи өөр хэнээс тусламж хүсч болох вэ?



Том чулууг зайлуулсан нь

Нэгэн жаахан хөвгүүн машинаараа тоглохоор байшингийнхаа ар дахь шороог тэгшлэхийг оролдож байлаа. Гэтэл зам дээр нь нэг том чулуу тээг болоод байж гэнэ. Уг чулууг бүх л чадлаараа түлхэж, чангаасан ч, бүр хэчнээн их зүтгэл гаргасан ч огт хөдөлсөнгүй.

Аав нь түүнийг хэсэг хугацаанд харж байснаа түүн дээр ирж, "Иймэрхүү том чулууг зайлуулахын тулд чи бүх хүчээ дайчлах хэрэгтэй" гэж хэлжээ.

Хөвгүүн "Би бүх л хүчээ дайчилсан шүү дээ" гэв.

Харин аав нь "Үгүй ээ, чи тэгээгүй. Чи миний тусламжийг аваагүй байна шүү дээ" хэмээн түүнд хэлжээ.

Тэр хоёр хамтдаа нөгөө чулууг амархан холдуулж чаджээ.

Их Эзэн . . . биднийг асуудлаа өөрсдөө шийдвэрлэхдээ Түүнд тулгуурлаасай хэмээн хүсдэг юм. Тэгснээр бид Түүний хайрыг байнга, хүчирхэгээр мөн тун тодорхой мэдэрч чадна. Тэгснээр бид Түүнтэй нэгддэг бөгөөд Түүн шиг болж чадна. ■

"Бурханд илүү ойртох нь" өгүүллээс Лиахона, 2013 оны 11-р сар, 105.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ГАЙ ФРЭНСИС

Би Филиппиний Дриа байна

*Мабухай, Кайбиган!**

Ами Жэйн Лийвиттэй хийсэн ярилцлагаас

Чи арал дээр амьдрах талаар хэзээ нэгэн цагт мөрөөдөж байсан уу? Энэ бол Александриа, гэхдээ түүний гэрийнхэн болон найз нар нь түүнийг товчоор Дриа гэж дууддаг. Тэр Филиппиний Сэбү арал дээр аав, ээж, хоёр эгчтэйгээ амьдардаг. Түүнд бас нэг ах байсан ч тэр Дриаг төрөхөөс өмнө нас барсан ажээ. “Ах минь манай гэр бүлийн гишүүн хэвээр байгааг би мэднэ. Гэр бүлүүд үүрд орших учраас би нэгэн өдөр ахтайгаа уулзах болно” гэж тэр хэллээ. ■

** Тагалог хэлээр “Сайн байна уу, найз нар аа!”*

Миний дуртай зүйлсийн нэг бол бүжиг. Би балетын бүжигчин. Ирэх жил би бүжгийн дараагийн түвшин буюу дунд шатны зэрэглэлд дэвшинэ гэж найдаж байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл би бүжгийн тусгай гутал өмсдөг болно гэсэн үг. Энэ гутал өлмий дээрээ бүжиглэхэд надад туслах болно.

Филиппин 7000 гаруй аралтай. Тиймээс нүд хужирлах үзэсгэлэнт газар олон бий. Манай гэр далайн эргийн наран шарлагын газарт ойрхон байдаг. Иймээс би далайн эрэг дээр тоглох дуртай. Миний дуртай зүйлсийн нэг бол усанд сэлэх. Би усанд яаж сэлэхийг бүр өөртөө заасан гээд бод л доо!

ЦУНХНИЙ ЗУРГИЙГ ТОМАС ЧАЙЛД; ПАСПОРТАН ДЭЭРХ МАРКИЙГ АШЛИ ТЕАРЕ

Би гэрийнхэнтэйгээ хамт наран шарлагын олон өөр газарт очих дуртай. Бид нэг удаа дэлхийд хамгийн том газар доорх голтой Палаван арал дээр очсон. Би тэнд амьсгалах хоолойвч зүүн шумбаж, олон янзын өнгө алагласан үй түмэн загас бужигнаж байхыг харсан.

БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

Нэг өдөр сургууль дээр манай ангийн хэдэн хүүхэд мормончууд Бурханд итгэдэггүй гэхэд нь бид Бурханд итгэдэг шүү дээ гэж би хэлсэн. Маргааш нь би нүүрэн талдаа Есүсийн зурагтай, ар талдаа Итгэлийн тунхгийг нийтэлсэн сүмийн танилцуулах хуудас хэдийг авчирлаа. Манай ангийнхан зургийг хараад итгэлийн тунхгаас заримыг нь уншаад биднийг Бурханд итгэдгийг мэдсэндээ баяртай байлаа.

Бид Филиппиний Себу хотын ариун сүмд ойрхон амьдардаг азтай хүмүүс. Би энэ ариун сүмийг адислагдахаас өмнө гэрийнхэнтэйгээ хамт тэнд аялалаар очсон. Ариун сүм үзэсгэлэнтэй сайхан, жинхэнэ амар амгалангийн газар байлаа. Ариун сүмүүдийн ачаар манай гэр бүл үүрд хамтдаа байж чадна гэдэгт би баяртай байдаг.

АРИУН СҮМ ЯВАХАД БЭЛЭН БОЛЛОО!

Дриа өөрийн дуртай зарим зүйлсээр аяны цүнхээ дүүргэжээ. Чи эдгээр зүйлсээс алийг нь цүнхэндээ авч явах вэ?

Есүсийн тухай бодоход

Мабэл Жөүнс Габотт

Есүсийн тухай, өндөр гүвээн дээрх Түүний загалмайн тухай, Түүний зовлон шаналлын тухай мөн Тэр миний төлөө юу хийснийг чимээгүй суугаад бодох нь хэцүү биш ээ.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КАТИ МАКДИЙ

Тоост замаар Тэр
олон бээрийг явган
туулсныг би бодлоо,





Хэрхэн хайрлахад
мөн хэрхэн итгэхэд
Тэр хүүхдүүдэд
тусалсныг би бодлоо;

Суудал дээрээ өндийн, өлмий дээрээ
суугаад чимээгүй сонсох нь хэцүү биш ээ.
Би хэдийгээр бяцхан ч, Есүсийн тухай бодох
нь хэцүү биш, огтхон ч хэцүү биш ээ. ■

ЕСҮС ХРИСТИЙН ТУХАЙ БОДОХ ОНЦГОЙ ЦАГ

Ариун ёслолын цуглаан бол анир чимээгүй сууж,
Аврагчийн тухай бодох онцгой цаг юм.

Есүс Иордан голд баптисм хүртсэн билээ.

Есүс хүмүүсийг эдгээдэг,

хүүхдүүдийг хайрладаг байлаа.

Тэр бидний төлөө зовж, бидний төлөө амиа өгсөн юм.

Есүс Улаан өндөгний баярын өглөө амилсан.

Есүсийн ачаар бид бас дахин амьдрах болно!

Өөрийнхөө зургийг энд зурах юм уу хуулбарлан тавь.

JOHN BAPTIZING JESUS (ИОХАН ЕСҮСТ БАПТИСМ ХҮРТЭЭЖ БАЙГАА НЬ), ХАРРИ АНДЕРСОН; CHRIST HEALING A BLIND MAN (ХРИСТ ХАРААГҮЙ ХҮНИЙГ ЭДГЭЭСЭН НЬ), ДЭЛ ПЭРСОН; STORY TIME IN GALILEE (ГАЛИЛ ДАХЬ ТҮҮХИЙН ЦАГ), ДЭЛ ПЭРСОН; GOLGOTHA (ГОЛГОТА), СКОТТ М. СНӨҮ; HE IS RISEN (ТЭР АМИЛСАН), ДЭЛ ПАРСОН

ИРЭЭДҮЙГЭЭС ИТГЭЛ НАЙДВАРЫГ ОЛОХ НЬ

Стэн Пагсли

2001 оны 9-р сарын 12-нд эхнэр, бид хоёр хүүгээ төрөхийг хүлээн, олон цаг санаа сэтгэлийн зовлон эдэлж, АНУ-ын Аризонагийн Таксон дахь эмнэлгийн шалан дээр алхалж байлаа. Бидний зурагт бас эмнэлгийн барилга доторх зурагт бүр нь нэгэн цагт Нью-Йорк хотын тэнгэрийг баганадан сүндэрлэж байснаа өмнөх өдөр нь үнс балгас болж нурж унасан ихэр хоёр цамхгийн тухай сурвалжлага мэдээгээр биднийг булж байв. Олон цаг үргэлжилсэн тэрхүү сурвалжлага мэдээ болон зурагтын нэвтрүүлэг бидэнд гуниг цөхрөлийн мэдрэмж төрүүлж байлаа. Ийм бараан баргар, айдас хүйдэс төрүүлэм дэлхийд, ийм цаг үед хүүхэд төрүүлнэ гэдэг хүсмээр зүйл огт биш юм шиг санагдаж билээ.

Маргааш өглөө эрт манай бяцхан хүү мэндэллээ. Би өөдсийн чинээхэн хүүгээ гартаа барьж байхдаа сүүлчийн ганц хоёрхон хоногт болсон сүйрүүлэгч үйл явдлуудын тухай, тэр ч байтугай 1988 онд Елөүстөүн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд гарсан түймрийн тухай эргэн санаж билээ. Тэр түймэр ойролцоогоор 800000 акр буюу 323750 га ойг устгасан юм. Цэцэрлэгт хүрээлэн бүрмөсөн сүйрсэн юм шиг санагдаж байлаа. Зурагтын мэдээгээр зөвхөн түймэрт хуйхлагдсан газар, тэнгэрт суунагласан өтгөн хар утааг л харуулж байв. Сүйрлийн ул мөрийг түргэн арилгаж, хэвийн байдлыг сэргээх нь хүмүүний хүч чармайлтаас хэт ахадсан юм шиг, тэр ч бүү хэл, байгалийн өөрийнх нь хүч болон түүний тасралтгүй нөхөн сэргэлт ч гэсэн түймрийн сүйрүүлэгч хүчтэй харьцуулах аргагүй юм шиг санагдаж байж билээ.

Биднийг нүдэж, айлгахаар заналхийлж буй тэрхүү салхи бас өөрчлөлт, өсөлтийн боломжийг бидэнд олгодог юм.

Гэтэл ердөө дараагийн хавар нь гайхамшиг тохиож, түймэрт хуйхлагдаж харласан газраас жижигхэн ургамлууд болон цэцэгс цухуйн соёолсон байлаа. Аажимдаа улам олон цэцэг, бут сөөг, модод газраас үндэслэн ургасан. Цэцэрлэгт хүрээлэнг сэргээн, хуучин байдалд нь оруулах үйл явц урт удаан, нарийн чимхлүүр, жижиг мэт санагдах ажил үйлсээр дүүрэн байсан бөгөөд цаг хугацаа өнгөрөх тусам үр дүн нь сэтгэл догдлуулам байлаа.

Елөүстөүний хуйхлагч түймэр лүгээ адил биднийг залгиж мэдэх айдсын хормуудад итгэл найдвар алдагддагийн даваан дээр бид өмнөө тулгарах хилэнцэт хүчнээс хамаагүй илүү хүчтэй, нам гүмхэн хийгээд хөдөлшгүй бат бөх нэгэн суурь өөрсдийнхөө дотор байдгийг санах ёстой. Хиламан энэ суурийг "Бурханы Хүү, Христ болох бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар суурьиа тавих ёстойг санагтун" хэмээн тайлбарласан билээ. Хэрэв бид өөрсдийгөө Түүнд бүрэн захируулбал "чөтгөр хүчит салхиа, тийм ээ, хуй салхин дахь дайралтаа илгээхэд, тийм ээ, түүний бүхий л мөндөр мөн хүчит шуурга та нар дээр нүдэхэд энэ нь та нарыг зовлонгийн хийгээд төгсгөлгүй халаглалын ангал тийш доош чирж дийлэх хүчгүй байх болно, та нар дээр нь босгогдсон, бат бөх суурь дээр, хүмүүн нь үүний дээр баривал унах аргагүй суурь болох хадны учир болой" (Хиламан 5:12).

Ухаан жолоогоо алдсан хилэнцэт хүчнүүд хийгээд дэлхийн уруу таталтуудтай тулгарсан үедээ бид сайн мэдээний энгийн бөгөөд өчүүхэн нөлөө хүчин мөхөсдөж мөн дийлдсэн хэмээн бодож болно. Бид буруу зүйлс зөв болж, асуудлууд шийдэгдэхийг дэмий хоосон хүлээж суух юм бол эргэлзээ ба цөхрөлд хүрч мэднэ. Гэвч биднийг нүдэж буй тэрхүү салхи нь өөрчлөлт, өсөлтийн боломжийг бидэнд олгож байгаа бөгөөд сайн мэдээний агуу хүч нь итгэл найдвар ба амьдралын мянга мянган өчүүхэн үрийг тарин, газар дэлхийн хөрсөн дор чимээгүйхэн соёолж байна. ■

Зохиогч нь АНУ-ын Аризонад амьдардаг.

ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЭРИК СВОНСОН

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ РОБЭРТ Т.БАРРЭТТ

ХОВАРД В.ХАНТЭР

Ховард В.Хантэр Скаутын бүргэд шагналаа (залуу эрэгтэйчүүдэд зориулсан амжилтын хөтөлбөрийн дээд шагнал) 15 настайдаа авчээ. Тэр **удмын бичиг хөтлөх ажлыг** ихэд сонирхон, сүмийн удмын бичгийн номын санд судалгаа хийж эсвэл гэр бүлд зочлон олон цагийг өнгөрүүлдэг байв. Төлөөлөгчөөр үйлчилж байхдаа тэр **Бригам Янгийн Их сургуулийн Иерусалим төвийг** барих газрыг сонгоход тусалсан ажээ. Тэрээр сүмийн ерөнхийлөгч байхдаа гишүүдийг ариун сүмд олон удаа ороход нь дэмждэг байсан бөгөөд нас барахаасаа хоёр сар хүрэхгүй хугацааны өмнө **Ютагийн Баунтифул ариун сүмийг** адисалжээ.

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Хэрэв та нар

Миний алдар суугийн

40

төлөө бүхнээ зориулах аваас

Аврагчийн үлгэр жишээг дагаж, даруухан амьдрах нь юу гэсэн үг болохыг дэлхий даяарх залуучууд тунгаан бодож байна.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



Сар ногоон уу? Саран дээр газардсан явдал хуурамч байсан уу? Энэ тааврыг тааж, Бурханы үнэнийг Сатаны худал хуурмаг зүйлээс хэрхэн ялган таних талаар мэдэж ав.

ЗӨВ ҮҮ, БУРУУ ЮУ?

64

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

“Өвөө, энэ чинь маш амархан!”

67

Хэрэв та Мормоны Номыг бүхэлд нь нэг өдөр хагасын дотор уншиж чадна гэдгийг мэдвэл гайхах уу?

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN
4 021098436 3 0